

Тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулийн
“СУРГУУЛЬ БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ АРГА ХАНДЛАГА”
багц гарын авлага

ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС



АГУУЛГА

1.	Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх үйл явцын төлөв байдлын үнэлгээ	
1.1.	СБААХ-ын нэвтрэлтийн төлөв байдлын үнэлгээний хуудас:	
	ЕБС-ийн удирдах ажилтан	5
1.1.1.	ЕБС-ийн удирдах ажилтан: Засаглал ай	8
1.1.2.	ЕБС-ийн удирдах ажилтан: Хүний нөөцийн чадавхын хөгжил ай	18
1.1.3.	ЕБС-ийн удирдах ажилтан: Сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуй ай	30
1.1.4.	ЕБС-ийн удирдах ажилтан: Сургууль ба сургалтын орчин ай	40
1.1.5.	ЕБС-ийн удирдах ажилтан: Түншлэл ай	50
1.2.	СБААХ-ын нэвтрэлтийн төлөв байдлын үнэлгээний хуудас: ЕБС-ийн багш	61
1.2.1.	ЕБС-ийн багш: Засаглал ай	64
1.2.2.	ЕБС-ийн багш: Хүний нөөцийн чадавхын хөгжил ай	74
1.2.3.	ЕБС-ийн багш: Сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуй ай	86
1.2.4.	ЕБС-ийн багш: Сургууль ба сургалтын орчин ай	96
1.2.5.	ЕБС-ийн багш: Түншлэл ай	106
1.3.	СБААХ-ын нэвтрэлтийн төлөв байдлын үнэлгээний хуудас: ЕБС-ийн ажилчид	116
1.3.1.	ЕБС-ийн ажилчид: Засаглал ай	120
1.3.2.	ЕБС-ийн ажилчид: Хүний нөөцийн чадавхын хөгжил ай	130
1.3.3.	ЕБС-ийн ажилчид: Сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуй ай	142
1.3.4.	ЕБС-ийн ажилчид: Сургууль ба сургалтын орчин ай	144
1.3.5.	ЕБС-ийн ажилчид: Түншлэл ай	154
1.4.	СБААХ-ын нэвтрэлтийн төлөв байдлын үнэлгээний хуудас: ЕБС-ийн сурагчид	165
1.4.1.	ЕБС-ийн сурагчид: Засаглал ай	168
1.4.2.	ЕБС-ийн сурагчид: Сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуй ай	176
1.4.3.	ЕБС-ийн сурагчид: Сургууль ба сургалтын орчин ай	182
1.4.4.	ЕБС-ийн сурагчид: Түншлэл ай	188
1.5.	СБААХ-ын нэвтрэлтийн төлөв байдлын үнэлгээний хуудас:	197
	ЕБС-ын сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид	
1.5.1.	ЕБС-ийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагч: Засаглал ай	200
1.5.2.	ЕБС-ийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагч:	
	Сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуй ай	210
1.5.3.	ЕБС-ийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагч: Сургууль ба сургалтын орчин ай	220
1.5.4.	ЕБС-ийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагч: Түншлэл ай	230
1.6.	СБААХ-ын нэвтрэлтийн төлөв байдлын үнэлгээний хуудас: Олон нийт	239
1.6.1.	Олон нийт: Засаглал ай	242
1.6.2.	Олон нийт: Сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуй ай	252
1.6.3.	Олон нийт: Сургууль ба сургалтын орчин ай	262
1.6.4.	Олон нийт: Түншлэл ай	272
2.	Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг нэвтрүүлэх менежментийн циклийн үе шатны үнэлгээ	282



1

СУРГУУЛЬ БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ
АРГА ХАНДЛАГЫГ НЭВТРҮҮЛЭХ
ҮЙЛ ЯВЦЫН ТӨЛӨВ
БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

1.1

УДИРДАХ АЖИЛТАН

Код:
у

5 айн 24 агуулгын хүрээний 240 асуулт

ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ БҮТЭЦ, АГУУЛГА: СУРГУУЛИЙН УДИРДЛАГА

Ай		Агуулгын хүрээ		ТХБ-ын цөм агуулга ба айн зарчим	Асуулт	Бойжилтын түвшин
Код	Утга	Код	Утга	Код/Утга	Код	
у.зас	ЗАСАГТАЛ	1	Бодлого, төлөвлөлт: Судалгаа боловсруулалт	ТХБ-ын цөм агуулга: 1. Тогтвортой хөгжил 2. Хүний эрх 3. Жендэрийн тэгш байдал 4. Дэлхийн иргэншил Зарчим: 5. Үр дүн, үр өгөөж 6. Оролцоо 7. Ил тод байдал 8. Хариуцлага 9. Тэгш байдал 10. Хууль тогтоомжид нийцэх байдал	у.зас.1.1.-1.10	1-Өөрчлөлтгүй 2-Өөрчлөлт хийж эхлэх 3-Зарим ахиц дэвшил ажиглагдах 4-Бодит байдалд ахиц дэвшил тодорхой болох 5-Зорьсон үр дүнд хүрч тогтвортой байдал төлөвших
		2	Төсөвлөлт: Тооцоолол, хуваариалалт		у.зас.2.1.-2.10	
		3	Хэрэгжилт: Зохион байгуулалт, зохицуулалт		у.зас.3.1.-3.10	
		4	Гүйцэтгэл: Үр дүн, ахиц дэвшил		у.зас.4.1.-4.10	
		5	Манлайлал: Чадвар, нөлөөлөл		у.зас.5.1.-5.10	
у.хнх	ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙН ХӨГЖИЛ	1	Байгууллагын ажиллаганы бүтэц, тавил	ТХБ-ын цөм агуулга: 1. Тогтвортой хөгжил 2. Хүний эрх 3. Жендэрийн тэгш байдал 4. Дэлхийн иргэншил Зарчим: 5. Суралцагч эрэгцүүлдэг, алсын хараатай байх 6. Суралцагч чадамжаа илрүүлэх, ашиглах боломжоор хангагддаг байх 7. Суралцагч нийгмийн сүлжээнд идэвхитэй ажилладаг байх 8. Суралцагчийн тусгай хэрэгцээ (equity) хангагддаг байх 9. Суралцагчийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь системтэй, эрэмбэлэгдсэн байх 10. Суралцагчийн суралцахуй нь оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурладаг байх	у.хнх.1.1.-1.10	1-Мэдээлэл авах 2-Мэдээллийг кодлож, бүртгэх 3-Мэдээллийг боловсруулах 4-Мэдээллийг хадгалах, хэрэглэх 5-Хандлага, зан үйлээ өөрчлөх
		2	Манлайлал		у.хнх.2.1.-2.10	
		3	Мэдлэг		у.хнх.3.1.-3.10	
		4	Эгэх хариуцлага		у.хнх.4.1.-4.10	
у.хбс	СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ	1	Сургалтын хөтөлбөр	ТХБ-ын цөм агуулга: 1. Тогтвортой хөгжил 2. Хүний эрх 3. Жендэрийн тэгш байдал 4. Дэлхийн иргэншил Зарчим: 5. Мэдлэг эзэмших 6. Шинэлэг, оролцооны арга, аргазүй 7. Эв нэгдэл ба үүрэг хариуцлага 8. Боловсролын цөм байх 9. Харилцан хамааралд нь авч үзэх 10. Насан туршийн боловсрол	у.хбс.1.1.-1.10	1-Эмх цэгцгүй 2-Эхлэх 3-Хэрэглэх 4-Оруулах 5-Хувиргах
		2	Багшлахуй		у.хбс.2.1.-2.10	
		3	Суралцахуй		у.хбс.3.1.-3.10	
		4	Сургалтыг дэмжих үйл ажиллагаа		у.хбс.4.1.-4.10	
		5	Үнэлгээ		у.хбс.5.1.-5.10	
у.орч	СУРГУУЛИЙН БА СУРГАЛТЫН ОРЧИН	1	Гадаад орчны тохижилт, аюулгүй байдал, эрүүл ахуй	ТХБ-ын цөм агуулга: 1. Тогтвортой хөгжил 2. Хүний эрх 3. Жендэрийн тэгш байдал 4. Дэлхийн иргэншил Зарчим: 5. Санхүүжилт 6. Үр ашигтай байдал 7. Нийцтэй байдал 8. Хүрээлэл орчин ба тогтвортой байдал 9. Эрсдэл 10. Өөрчлөлт	у.орч.1.1.-1.10	1-Өөрчлөлтгүй, урсгалаараа байх 2-Өөрчлөлт, хэрэгцээг мэдрэх 3-Хүчин чармайлт гаргаж, ахиц гаргах 4-Үр дүнд хүрч, нөхцөл байдал сайжрах 5-Зохих хэрэгцээ шаардлагыг хангах
		2	Дотоод орчны тохижилт, тоног төхөөрөмжийн хангамж, аюулгүй байдал, эрүүл ахуй		у.орч.2.1.-2.10	
		3	Материаллаг нөөцийн хэрэглээ, хог хаягдлын менежмент		у.орч.3.1.-3.10	
		4	Барилга байгууламж, эдэлбэр газрын ашиглалт, хамгаалалт		у.орч.4.1.-4.10	
		5	Эрүүл мэнд, харилцаа хандлага, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж		у.орч.5.1.-5.10	
у.түн	ТҮНШЛЭЛ	1	Нийгмийн тулгамдсан асуудал: Хүүхэд хамгаалал	ТХБ-ын цөм агуулга: 1. Тогтвортой хөгжил 2. Хүний эрх 3. Жендэрийн тэгш байдал 4. Дэлхийн иргэншил Зарчим: 5. Тэгш байдлыг хангах 6. Ил тод байдлыг хангах 7. Үр дүнд баримжаалах 8. Хамтын хариуцлага хүлээх 9. Харилцан бие биеэ нөхөх 10. Олон нийтийн эрх ашигт нийцсэн байх	у.түн.1.1.-1.10	1-Мэдээлэх 2-Санал сонсох 3-Зөвшилцөх 4-Оролцуулах 5-Түншлэх
		2	Эдийн засгийн тулгамдсан асуудал: Залуучуудын зохистой хөдөлмөр эрхлэлт		у.түн.2.1.-2.10	
		3	Байгаль орчны тулгамдсан асуудал: Хүүхэд, залуучуудын экологийн боловсрол, төлөвшил		у.түн.3.1.-3.10	
		4	Өв уламжлал, соёл: Нүүдэлчин соёл, өв уламжлалт дэлхийн монгол хүн		у.түн.4.1.-4.10	
		5	Тогтвортой хөгжлийн гурван тулгуурын интеграц		у.түн.5.1.-5.10	



ЕБС-ийн УДИРДАХ АЖИЛТНЫ АНКЕТ

1. Таны хүйс: Эрэгтэй
 Эмэгтэй
2. Таны эрхэлж буй албан тушаал: Захирал
 Гүйцэтгэх/Дэд захирал
 Сургалтын менежер
3. Боловсролын салбарт ажилласан нийт жил:
4. Удирдах албан тушаалд ажилласан нийт жил:
5. Тухайн сургуульд ажилласан нийт жил:
6. Таны мэргэжлийн чиглэл: Бага ангийн багш
 Хэл хүмүүнлэгийн ухааны багш
 Математик, мэдээллийн технологийн багш
 Байгалийн ухааны багш
 Нийгмийн ухааны багш
 Урлаг, дизайн, технологийн багш
 Бусад мэргэжил
7. Таны боловсролын түвшин: Доктор
 Магистр
 Бакалавр
 Диплом
 Бусад
8. Таны мэргэжлийн зэрэг: Зөвлөх
 Тэргүүлэх
 Арга зүйч
 Мэргэжлийн зэрэггүй



1.1.1. ЕБС-ийн УДИРДАХ АЖИЛТАН: ЗАСАГЛАЛ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ: СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.1.1. Сургуулийн бодлого, төлөвлөлтийг ТХ/ТХБ-ын үзэл баримтлалд тулгуурлахын тулд сургуулийн хэрэгцээ, нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа хийсэн үү?				
ТХ/ТХБ-ын бодлогын баримт бичгүүдэд тулгуурлаж байгаа ч судалгаа хийгээгүй	Сургуулийн нөхцөл байдлын судалгаа хийсэн боловч үр дүнг тусгаж чадаагүй	Сургуулийн гадаад, дотоод орчны нөхцөл байдлын ерөнхий дүр зургийг тодруулах судалгаа хийсэн	Сургуулийн нөхцөл байдлын шинжилгээ хийн тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлуудыг тодорхойлон шийдлийн оновчтой хувилбарыг боловсруулсан	Сургуулийн нөхцөл байдлын шинжилгээ, бодлогын боловсруулалтын шинэлэг арга зүйд тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй, сайн боловсруулж чадсан, хэрэгжүүлэх арга зүй, хүрэх үр дүн нь тодорхой
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.1.2. Сургууль дахь асуудлыг тодорхойлох, шийдлийн хувилбар боловсруулах зэрэг нь оролцогч талуудын эрх ашигт нийцэж байдаг уу?				
Сургуулийн бодлого, стратегийг оролцогч талуудын эрх ашигт нийцүүлэх талаар анхаарч байгаагүй	Багш, ажилтнууд, суралцагчдын эрх ашигт нийцүүлэх оролдлого хийгдэг боловч бусад оролцогчдын эрх ашигийг тооцоогүй	Оролцогч талуудын эрх ашгийг тооцохыг чухалчилж үздэг	Сургуулийн бодлого, аль ч шатны төлөвлөлтийн асуудал, шийдлийг боловсруулахдаа оролцогч талуудын нийтлэг болон ялгаатай талыг судлан тооцож, хүний эрхийг хангахад онцгойлон анхаарч байгаа	Оролцогч талуудын нийтлэг болон ялгаатай талыг судлан тооцож, хүн бүрийн эрх, оролцогч талуудын сонирхлыг нэгтгэж чадсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.1.3. Сургуулийн бодлого, төлөвлөлт ЖТЭ-ийг бүрэн хангаж чадаж байна уу?				
Бодлого, төлөвлөлтөд энэ талыг онцолж үзээгүй	Сургуулийн бодлого, төлөвлөлтөд жендэрийн мэдрэмжтэй хандах талаар ярилцдаг болж байна	Жендэрийн асуудлыг бодлого, төлөвлөлтөд анхаарч үздэг болж байна	Жендэрийн тэгш эрхийг хангах нь бодлого, төлөвлөлтийн нэг зарчим болсон	Сургуулийн бодлого, төлөвлөлт бүхэлдээ жендэрийн тэгш эрхийг хангасан, тодорхой, онцлог зорилт, үйл ажиллагааг тусгайлан тусгасан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.1.4. Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, стратегид суралцагчдааа ХХI зууны дэлхийн иргэн болгон төлөвшүүлэх үзэл санааг тусгасан уу?				
Сургуулийн бодлогод дэлхийн иргэнийг төлөвшүүлэх үзэл санаа тусгалаа олж эхэлж байна	Сургуулийн бодлого, төлөвлөлтийн суурь зарчмуудын нэг нь энэ бөгөөд сургалтын хөтөлбөрт юуг тусгах нь тодорхой болсон	Сургуулийн бодлого, стратегид дэлхийн иргэний танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл зүйн, биеэ авч явах арга ухаанд сургах арга зүйг тусгасан	Сургуулийн бодлогод дэлхийн иргэний эзэмшсэн байх мэдлэг чадварыг бүх хичээлийн агуулгад суурьшуулж чадсан	Энэ талаар сургуулийн бодлогын баримт бичгүүд болон хичээлийн хөтөлбөрүүдэд бүрэн тусгагдаж чадсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.1.5. Бодлого, төлөвлөлтийг боловсруулахдаа үр дүнг нь үндэслэлтэй тооцож, тодорхойлж чаддаг уу?				
Урт хугацааны стратегийн төлөвлөгөөнд үр дүнг тодорхойлсон боловч хэр оновчтой эсэхийг хэлж мэдэхгүй байна	Урт, дунд, богино хугацааны аль ч төлөвлөлтөд тодорхойлсон үр дүнгүүдийн заримыг нь хэрэгжих магадлал муутай гэж дүгнэдэг	Сургуулийн бодлого, төлөвлөлтийн хүрэх үр дүнг тодорхойлсон боловч ч хамт олноор хэлэлцүүлээгүй	Сургуулийн бодлого, төлөвлөлтийн үр дүнг хамтдаа хэлэлцэж тусгадаг	Хүрэх үр дүн, оролцогч талуудад үзүүлэх үр өгөөж, санхүүгийн үр ашиг, үр нөлөө зэргийг тооцон хамтдаа хэлэлцэн тусгадаг төдийгүй тэдгээрийг тооцох аргачлалыг ч мэднэ
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.1.1. ЕБС–ийн УДИРДАХ АЖИЛТАН: ЗАСАГЛАЛ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ: СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТ

Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.1.6. Бодлого, төлөвлөлтийн боловсруулалтад талуудын оролцоог хэрхэн хангадаг вэ?				
Бодлого, төлөвлөлтийн боловсруулалтад удирдлагын багаас гадна багш нарын төлөөлөл оролцдог	Бодлого, төлөвлөлтийн боловсруулалтад багш, ажилтан, эцэг эхийн төлөөлөл оролцдог	Бодлого, төлөвлөлтийн оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн баг/эко зөвлөл хийдэг	Бодлого, төлөвлөлтийг оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн баг/эко зөвлөл хийдэг бөгөөд тэд олон янзын арга, хэлбэр ашиглан оролцогч талуудын өргөн хүрээг хамарсан арга хэмжээ зохион байгуулж хэлэлцүүлдэг	Бодлого, төлөвлөлтийг оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн баг/эко зөвлөл хийдэг бөгөөд тэд олон янзын арга, хэлбэр ашиглан оролцогч талуудын өргөн хүрээг хамарсан арга хэмжээ зохион байгуулж хэлэлцүүлдэг, оролцогч талууд ч идэвхтэй оролцож хэвшсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.1.7. Бодлого, төлөвлөлтийн боловсруулах үйл ажиллагаа хэр нээлттэй явагддаг вэ?				
Удирдлагын багаас боловсруулан баталж, танилцуулга, сурталчилгаа хийдэг	Бодлого, төлөвлөлтийн баг/эко зөвлөл өөрсдийн үйл ажиллагааг тогтмол биш ч гэлээ танилцуулж байдаг тул хэрхэн ажиглаж байгааг нь ажиглах боломжтой байдаг	Бодлого, төлөвлөлтийн баг/эко зөвлөл үйл ажиллагааныхаа талаар оролцогч талуудыг байнга мэдээллээр хангаж ажилладаг	Бодлого, төлөвлөлтийн баг/эко зөвлөл бүхий л мэдээллийн сувгийг ашиглан өөрсдийн үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар оролцогч талуудад мэдээллийг тогтмол хүргэдэг	Бодлого, төлөвлөлтийн баг/эко зөвлөл бүхий л мэдээллийн сувгийг ашиглан өөрсдийн үйл ажиллагаа, түүний үр дүнг мэдээллэхээс гадна оролцогч талуудын санал, хүсэлт, зөвлөмжийг нээлттэй хүлээн авдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.1.8. Бодлого, төлөвлөлтөд оролцогч талууд, хүн бүрийн үүргийг тодорхой болгон, хариуцлага хүлээх механизмыг бүрдүүлдэг үү?				
Бодлого, төлөвлөлтөд оролцогч талууд тодорхой үүрэг хүлээдэг	Бодлого, төлөвлөлтийн баг/эко зөвлөлийн гишүүд, оролцогч талуудын хүлээх үүрэг тодорхой байдаг	Удирдлагын баг болон бодлого, төлөвлөлтийн баг/эко зөвлөл, оролцогч талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тусгасан дүрэм, журамтай	Оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр хүлээх үүрэг, хариуцлагаа тодорхойлдог	Оролцогч талууд зөвшилцөн хүлээх үүргээ тодорхойлон, ажил хэргийн болон ёс суртахууны хариуцлагын талаар харилцан баталгаажуулж, мөрдөхөөр дүрэм, журамдаа тусгадаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.1.9. Бодлого, төлөвлөлтийн бүх үе шатны шалгуур үзүүлэлтүүд нь тэгш байдлыг хангаж байдаг уу?				
Бодлого, төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, түүнд баримтлах тэгш байдлын зарчим зэрэг нь тодорхой биш	Шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан хэдий ч үндэслэлтэй, зөв боловсруулсан, тэгш байдлыг хангасан эсэхийг дүгнэхэд хэцүү байна	Бодлого, төлөвлөлтийн зөвхөн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг л ерөнхий байдлаар тодорхойлсон бөгөөд энэ нь тэгш байдлыг хэрхэн хангадаг эсэхийг тооцдоггүй	Шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа тэгш байдал буюу ялгаварлалгүй, хүртээмтэй, бүх талын оролцоотой, үр дүн нь хэн бүхэнд өгөөжтэй байх талаар анхаарсан онцлогтой	Бодлого, төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтүүд нь тэгш байдлыг бүрэн хангаж чадсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.1.10. Сургуулийн бодлого, төлөвлөлтийн боловсруулалт нь Монгол улсын Бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид бүрэн нийцсэн үү?				
Холбогдох хууль тогтоомжтой ерөнхийдөө нийцэж байгаа боловч давхардал, хийдэл багагүй байдаг	Холбогдох хууль тогтоомжтой уялдуулахад зориуд анхаарч байна	Холбогдох хууль тогтоомжид суурилсан байдаг	Холбогдох хууль тогтоомжид суурилсан, оролцогч талуудаар хэлэлцэгдэж, хянагддаг	Холбогдох хууль тогтоомжуудыг судлан суурилж хэвшсэн, оролцогч талуудаар хэлэлцэгдэж, хянагддаг, зарим үед эрх зүйн зөвлөгөө авдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. ТӨСӨВЛӨЛТ: ТООЦООЛОЛ, ХУВААРИЛАЛТ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.2.1. ТХБ-ын сургалтын хөтөлбөр, түүнийг дэмжих үйл ажиллагаанд тусгайлсан төсөв хуваарилсан уу?				
Сургуулийн төсөв ийм үйл ажиллагаанд төдийлөн хүрэлцдэггүй тул санхүүгийн бусад эх сурвалжуудыг нээх талаар анхаарч байна	Сургуулийн санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэхэд оролцогч талуудын хүч нөөцийг ашиглах санаачилга, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхжүүлсэн	Сургуулийн санхүүгийн хэрэгцээтэй нөөцийг тооцон, оролцогч талуудын дэмжлэгээр нэмэгдүүлж чадсан	Оролцогч талуудын дэмжлэгээр хэрэгцээтэй санхүүгийн нөөц хуримтлуулж чаддаг болсон	Оролцогч талуудын дэмжлэгээр хэрэгцээтэй санхүүгийн нөөцийг хуримтлуулж чаддаг болсон бөгөөд энэ талаар тодорхой төсөв хуваарилагдсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.2.2. Төсөвлөлт нь багш, суралцагчид, эцэг эх болон бусад оролцогч талуудын эрхэд суурилдаг уу?				
Төсөвлөлтийг зөвхөн удирдлагын баг хийдэг бөгөөд оролцогч талуудад мэдээлэл сайн өгч байгаа	Төсөвлөлтийг зарим оролцогч талууд хянадаг болсон	Төсөвлөлтийг хэд хэдэн оролцогч талууд хамтаар хэлэлцэж хийдэг болсон	Төсөвлөлтийг ихэнх оролцогч талуудын төлөөлөл хамтран хэлэлцэж боловсруулдаг туршлага бий болж байна	Төсөвлөлтийг ихэнх оролцогч талуудын төлөөлөл хамтран хэлэлцэж боловсруулж хэвшсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.2.3. Төсөвлөлт нь жендэрийн мэдрэмжтэй хийгддэг үү?				
Төсөв нь жендэрийн мэдрэмжтэй байх шаардлагыг мэддэг болсон	Жендэрийн мэдрэмжтэй төсөв, хэрэгжүүлэх арга зүйг мэдэж, анхаардаг болсон	Сургуулийн төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийдэг болсон	Энэ шинжилгээний дүнд тулгуурлан асуудал байгаа эсэхийг тодорхойлсон	Асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авдаг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.2.4. Төсөвлөлтийн үйл явцад суралцагчид оролцдог уу?				
Эко зөвлөлд суралцагчийн төлөөлөл байдаг	Төсөвлөлтийн үйл явцад бусад суралцагчдыг оролцуулахаар зохих мэдлэг чадвар эзэмшүүлж байна	Суралцагчид нэг оролцогч тал тул журмын дагуу оролцдог	Суралцагчдын төлөөлөл төсөвлөлтөд оролцож хэвшсэн	Суралцагчид төсөвлөлтөд тооцоолол хийж, санал бодлоо илэрхийлж, идэвх санаачилгатай оролцдог болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.2.5. Сургуулийн төсвийн зарцуулалтын үр дүн, үр өгөөж, үр ашгийг оновчтой тооцоолж байна уу?				
Төсвийн зарцуулалтын үр дүнг хэрхэн тооцдогийг мэдэхгүй	Төсвийн зарцуулалтын үр дүнг хэрхэн тооцдогийг мэддэг болсон	Төсвийн зарцуулалтын үр дүнг тусгайлан тооцдог болсон	Төсвийн зарцуулалтын үр дүнгийн тооцооллыг хийж, үйл ажиллагаандаа хэвшил болгож байна	Эдгээрээс гадна төсвийн үр өгөөжийн шинжилгээ хийж байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. ТӨСӨВЛӨЛТ: ТООЦООЛОЛ, ХУВААРИЛАЛТ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.2.6. Төсөвлөлтөд оролцогч талуудын оролцоо ямар байна вэ?				
Оролцогч талууд тоон мэдээлэлтэй танилцдаг	Оролцогч талууд санхүүгийн нөөцийн бүрдүүлэлт, түүний хуваарилалтад оролцож байна	Оролцогч талууд төсвийн бүрдүүлэлт, хуваарилалтад оролцож, өөрсдөө тооцоолол хийж шинжиж чадаж байгаа	Оролцогч талууд төсвийн орлого, зарлагад шинжилгээ хийн, тодорхой санал боловсруулан оролцдог болж байна	Оролцогч талууд судалгаатай, үндэслэлтэй хийсэн тооцоололтой тодорхой санал боловсруулан, идэвхтэй оролцдог болж байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.2.7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ямар байна вэ?				
Хууль хэрэгжиж эхэлсний дараа зарим мэдээлэл ил болсон	Шилэн дансны мэдээлэл нээлттэй болж, хамт олон мэдээлэлтэй танилцдаг болж байна	Шилэн дансны тухай хуулинд заасан үзүүлэлтээр мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр танилцуулж, хамт олон мэдээлэлтэй анхааралтай танилцдаг болсон	Төсвийн орлого, зарлагын мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээллийн хэд хэдэн сувгаар ил тод өгч хэвшсэн, хамт олон ч анхааралтай танилцдаг	Төсвийн орлого, зарлагын мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээллийн хэд хэдэн сувгаар ил тод өгч хэвшсэн, хамт олон ч анхааралтай танилцаж, тодорхой дүгнэлт хийдэг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.2.8. Төсөвлөлтөд хэрхэн хяналт тавьдаг вэ?				
Сургуулийн төсвийн хяналт ихэвчлэн гадны аудитын байгууллагуудаар хийгддэг	Төсвийн хяналтад бодлого, төлөвлөлтийн баг/эко зөвлөл оролцдог болсон	Төсвийн мэдээлэл нээлттэй болсон тул бүгд анхаарал хандуулдаг болсон	Оролцогч талуудын хяналт сайжирсан, тодотгол хийдэг болж, зөрчил, дутагдал байвал засаж сайжруулдаг	Оролцогч талуудын хяналт сайжирснаар төсвийн хуваарилалт зарцуулалтад ахиц дэвшил гарсан, хариуцлага өндөр болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.2.9. Санхүүгийн нөөцийг хуваарилалтад тэгш байдлыг бүрэн хангаж чаддаг уу?				
Санхүүгийн нөөцийн хуваарилалтад тэгш байдлын талаар анхаардаггүй	Тэгш байдлын зарчмыг баримталдаг боловч доголдол, дутагдалтай зүйл байдаг	Төсвийн хуваарилалтад тэгш бус, ялгавартай хандсан тохиолдол байгаагүй.	Төсвийг оролцогч талуудын хяналтын дор шаардлагатай, хэрэгцээтэй нөөцийн судалгаанд тулгуурлан хуваарилдаг	Төсвийг оролцогч талуудын хяналт дор ямар нэгэн ялгаварлал, тэгш бус байдлыг гаргуулалгүй, үр дүнтэй байхаар төсөвлөх чадавхтай болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.2.10. Төсөвлөлт нь Монгол улсын Төсвийн тухай хууль, түүнтэй холбоотой бусад хууль, тогтоомжтой нийцэж байна уу?				
Төсөвлөлтийг өмнөхөөс илүү сайжруулсан хэдий ч зарим нэг дутагдал байгаа	Төсөвлөлтийг удирдлагын баг хийдэг ингэхдээ хууль тогтоомжид нийцүүлдэг	Төсөвлөлтөд оролцогч талуудын төлөөлөл оролцдог болсон тул нийцэл сайжирсан гэж дүгнэж байна	Төсөвлөлтийг хамтдаа хэлэлцэж, харилцан зөвшилцөж хийдэг бөгөөд оролцогч талуудын мэргэжилтнүүд ч тусламж, зөвлөгөө өгдөг	Төсөвлөлт хуульд бүрэн нийцсэн гэдэгт эргэлзэх зүйлгүй
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. ХЭРЭГЖИЛТ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.3.1. ТХ/ТХБ-ын сургалтын хөтөлбөр, түүнийг дэмжих үйл ажиллагааны удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь зохистой, үйл ажиллагаа нь тогтвортой байна уу?				
Удирдлагаар хангах гол субъект нь сургуулийн удирдлагын баг	Удирдлагын бүтэц нь сургуулийн удирдлагын баг, эко зөвлөл	Удирдлагын бүтэцэд сургуулийн удирдлагын баг, эко зөвлөл, удирдах зөвлөл, тэнхим, ЗАН-ийн ахлагч нар багтах бөгөөд хэрэгжүүлэх чиг үүрэг нь тодорхой	Удирдлагын бүтэц, чиг үүрэг нь тодорхой, дүрэм, журмаар зохицуулагдсан	Сургуулийн удирдлагын баг, эко зөвлөл, УЗ, ЗАН, багш нарын зөвлөл, эцэг эхийн зөвлөл, суралцагчдын зөвлөл, албадын ахлагчид, бусад оролцогч талуудын удирдах удирдах албан тушаалтнуудын эрх, чиг үүрэг, хариуцлага, хариуцаж хийх үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг хэлэлцэж баталсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.3.2. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд хүний эрхийг зөрчих тохиолдол байдаг уу?				
Зарим нэг зөрчил гардаг	Сургуульд “илт” хүний эрхийг зөрчөөд байдаггүй ч харилцааны явцад зарим нэг доголдол гардагийг үгүйсгэхгүй	Хүний эрхийн нарийвчилсан шинжилгээгээр хүний эрхийг бүрэн хамгаалж, хангаж чадахгүй байгаа зүйл илэрч болно	Сургуулийн орчинд тусгайлсан шинжилгээг үе үе хийн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлдэг	Судалгаанаас гадна энэ талаарх мэдээллийг сайн хүргэж, хамтын анхаарал, халамж, хандлага, харилцаа, хүндлэл, итгэлцэл зэрэг эрхийг хангах сэтгэл зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажилладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.3.3. Сургуульд жөндөрийн тэгш эрхийг хангах талаар тодорхой ахиц дэвшил гарсан уу?				
Багшлах бүрэлдэхүүний хүйсийн тэгш байдалд анхаарах, эмэгтэй багш нарын ар гэрийн онцлог байдалтай холбон ажлын цагийн зохицуулалт хийх зэргээр тодорхой үйл ажиллагаа хэрэгжиж эхэлж байна	Сургуулийн бүх мэдээллийг хүйсээр гаргаж, охид, хөвгүүдийн онцлогийг харгалзан үйл ажиллагааг зохион байгуулах, сургууль завсардалт зэрэг асуудлыг жөндөрийн тэгш эрхийг хангах арга замаар шийдвэрлэх зэргээр анхаарч ажиллаж байна	Сургуульд жөндөрийн тэгш эрх алдагдаж болох бүхий л үйл ажиллагаа, нөхцөл байдалд суурь судалгаа хийн илрүүлэлт хийсэн, энэ дагуу зохицуулалт, зохион байгуулалтыг чиглүүлэн ажиллаж байна	Жөндөрийн шижилгээний дүнд тулгуурлан бодлого, төлөвлөлт хийсэн, хэрэгжилт нь сайн байна	Сургуульд жөндөрийн тэгш эрхийг зөрчих тохиолдол, хэлбэрүүдийг бүрэн арилгасан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.3.4. Суралцагчдыг дэлхийн иргэн болгон хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийн үр дүн ямар байна вэ?				
Дэлхийн иргэнд байх ёстой мэдлэг, чадварыг суралцагчдад эзэмшүүлж чадахгүй байгаа	Дэлхийн иргэн байх талаар хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хэрэгжүүлдэг болсон	Дэлхийн иргэний боловсролын хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийж ахиц дэвшил, дутагдал доголдлоо тодорхойлж ажиллаж байна	Хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд энэ зорилтын хүрээнд хийж буй үйл ажиллагаа нь суралцагчдад сонирхолтой болж, багш бүр анхаарч ажиллаж байна	Ямар ахиц дэвшилд хүрсэнээ суралцагчийн, багшийн, нэгж хэсгийн, сургуулийн түвшинд үндэслэлтэй тогтоон тодорхойлж чаддаг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.3.5. Хэрэгжилтэд “үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээ” хийж, мөчлөг бүрийн үр дүн, үр өгөөж, үр ашгийг оновчтой тооцож, ахиц дэвшлийг тодорхойлон, шаардлагатай зохицуулалтыг цаг тухайд нь хийж чадаж байна уу?				
Хэрэгжилтийг тайлагнадаг боловч “үр дүнд суурилсан” хяналт шинжилгээний арга зүйд суралцаагүй байгаа	Хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг тодорхойлоход сургуулийн хамт олон оролцож байна	Хяналт шинжилгээ, үнэлгээг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тодорхой мөчлөгөөр хийдэг, дүнг үйл ажиллагаандаа хэрэглэж хэрэгжүүлдэг	Хяналт шинжилгээ, үнэлгээг “үр дүнд суурилсан” арга зүйгээр хийж байна	Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг байнга хийж, үр дүнг судалж, үйл ажиллагаандаа зохицуулалт хийж чаддаг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. ХЭРЭГЖИЛТ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.3.6. Хэрэгжилтэд оролцогч талууд, сургуулийн хамт олны гишүүн бүр идэвхтэй оролцож, бүтээлч, санаачилгатай байж чадаж байна уу?				
Үйл ажиллагаанд оролцогч талуудыг "зориуд" зохион байгуулж л оролцуулдаг	Сургуулийн хамт олноос бусад оролцогч талууд тухайн цаг үед сонирхон оролцох хэлбэр давамгайлж байна	Сургуулийн хамт олноос бусад оролцогч талууд сайн дурын үндсэн дээр оролцох байдал давамгайлдаг болсон	Сургуулийн хамт олноос бусад оролцогч талууд байнгын, санал, санаачилгатай оролцдог болсон	Оролцогч талууд бүгд хамтран, санаачилгатай, тогтмол, үр дүнтэй ажиллаж хэвшсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.3.7. Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн явц, хяналт шинжилгээ үнэлгээний дүн, бусад мэдээлэл хэр нээлттэй, шуурхай байна вэ?				
Энэ талаарх мэдээлэл нээлттэй болж байгаа ч шуурхай, тогтмол биш байна	Энэ талын мэдээлэл харьцангуй шуурхай, тогтмол болж байна	Хамтдаа хэрэгжүүлж, хамтдаа хянаж шинжилж үнэлдэг учраас мэдээлэл шуурхай, нээлттэй байдаг	Мэдээлэл нээлттэй байх тогтолцоо бүрдсэн	Байгууллага дахь харилцан мэдээллийн урсгал шаардлага хангасан, боловсруулалт сайтай хийгдсэн, найдвартай мэдээллээр хангахад анхаардаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.3.8. Хүн бүр хүлээсэн үүрэг, хариуцсан ажлаа бүтээлчээр, санаачилгатай гүйцэтгэж хэвшсэн үү?				
Сургуулийн хамт олны гишүүн бүр хариуцсан ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэх байдалд зохих дэвшил ажиглагдаж байгаа	Сургуулийн хамт олны гишүүн бүр хариуцлагатай ажилладаг болж, ёс суртахууны зөрчил гарахгүй болж байна	Сургуулийн хамт олны гишүүн бүр хүлээсэн үүргээ ямар нэг зөрчилгүй ажил хэрэгч хийн, тодорхой санал, санаачилга нэмэгдсээр байна	Сургуулийн хамт олны гишүүн бүр төдийгүй оролцогч талууд хариуцлагатай болж, ажил хэргийн болон ёс суртахууны зөрчил дутагдал гарахгүй болсон	Ямар нэг шалтгаанаар үйл ажиллагааны хэрэгжилт тасрах, хүлээсэн үүргээ умартах, хариуцлагагүй хандах, харилцаа, хандлагад зохисгүй байдал үүсэх зэрэг зөрчил гарахгүй болсон. Хүн бүр, байгууллага, нэгж бүрийн аливаад бүтээлчээр хандах байдал шаардлагын түвшинд хүрч жигдэрсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.3.9. Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн явцад ялгаварлан гадуурхал, тэгш бус хандлага, ёс суртахуунгүй үйлдэл, тал тохой татах, элдэв дарамт зэрэг илэрдэг үү?				
Өдөр тутмын үйл ажиллагаанд иймэрхүү дутагдал гардаг ч ноцтой үр дагавар үүсгэхгүй байна	Ажлын байран дахь дарамт, ялгаварлан гадуурхал, авлига, хээл хахууль, албан тушаалаа урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчил гаргах зэрэгт дутагдал эрс багассан	Байгууллагад байж болох элдэв ялгаварлалтай удирдлагын багаас тууштай тэмцдэг болсон	Энэ чиглэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийн дүнд тэгш бус байдлын үндэс, шалтгааныг олж тогтоон тодорхой үе шаттай арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн	Энэ чиглэлийн үйл ажиллагааны үр дүнд тэгш бус байдлын үндэс, шалтгааныг арилгахын зэрэгцээ, тэгш байдлын боломж, нөхцөлийг бүрдүүлж өөрийн гэсэн туршлага хуримтлуулсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.3.10. Сургуулийн дотоод журам, бусад дүрэм, журмуудын хэрэгжилтийн явцад зөрчил, бэрхшээл учирч байна уу?				
Зөрчигдөх тохиолдол багагүй бий	Зөрчил гардаг ч тухай бүрд нь шийдвэрлэхэд анхаардаг	Зөрчил, бэрхшээлийн шалтгаан үр дагаврыг судалдаг болсон	Сургуулийн дотоод журам, бусад дүрэм, журмуудын хэрэгжилтэд шинжилгээ хийдэг болсон	Энэ шинжилгээний дүн болон нөхцөл байдалтай уялдуулан зүйл, заалтыг уян хатан байлгаж сайжруулдаг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ГҮЙЦЭТГЭЛ: ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.4.1. ТХБ эзэмшсэнээр суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагад ямар ахиц дэвшил гарч байна вэ?				
Одоохондоо ахиц дэвшил ажиглагдахгүй байна	Ахиц дэвшил бага боловч ажиглагдаж байна	Ахиц дэвшлийг нь тодорхойлж чадаж байна	Ахиц дэвшлийг шинжиж тодорхойлсноос үзэхэд боломжийн байна	ТХБ-ын эзэмшилтийн түвшин сайн, мэдлэг, чадвар, хандлагад маш сайн дэвшил гарч байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.4.2. Бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтийн үйл ажиллагаа нь суралцагч бүрийн ялгаатай байдлыг тооцсон олон төрөл хэлбэртэй болж баяжиж чадсан уу?				
Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа төрөл, хэлбэрийн хувьд төдийлөн өргөн хүрээтэй болж чадаагүй	Суралцагч бүрийн ялгаатай байдлыг тооцдог болсон	Суралцагч бүрийн ялгаатай байдлыг тооцсон олон төрөл хэлбэртэй болж эхэлж байна	Олон төрөл хэлбэрийн үйл ажиллагааг хэрэгжүүлснээс гадна үр дүн, үр нөлөө нь нэмэгдсэн	Суралцагч бүрийн ялгаатай байдлыг тооцсон арга хэмжээнүүдийг өргөн зохион байгуулсан нь тэдний хөгжилд мэдэгдэхүйц нөлөөллийг үзүүлээ
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.4.3. Гүйцэтгэлийн үнэлгээний явцад жендэрийн тэгш эрхийг хангаж хэвшсэн үү?				
Гүйцэтгэлийн үнэлгээний явцад жендэрийн тэгш эрхийг тооцож чадаагүй	Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний явцад жендэрийн тэгш эрхийг хангахад анхаарч байгаа	Гүйцэтгэлийн үнэлгээний явцад жендэрийн шинжилгээ хийдэг	Гүйцэтгэлийн үнэлгээний явцад хийсэн жендэрийн шинжилгээний дүнгээр тэгш эрхийг зөрчсөн тохиолдол гарч байгаагүй	Гүйцэтгэлийн үнэлгээ жендэрийн тэгш эрхэд бүрэн нийцсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.4.4. Дэлхийн иргэнд байх ёстой мэдлэг, чадвар, хандлагыг суралцагчид хэр эзэмшиж байна вэ?				
Ямар нэгэн ахиц ажиглагдаагүй байна	Зарим талаар мэдлэгтэй болж байгаа ч чадвар, хандлага болж төлөвшөөгүй	ДИБ-ын талаар суралцагчид жигд мэдлэгтэй болж, зохих чадвар эзэмшиж байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээнээс ажиглагдаж байна	Эзэмшилтэд мэдэгдэхүйц ахиц гарч чадсан нь нотлогдож байна	Олон улсын түвшинд тавигддаг шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар, хандлага эзэмшиж байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.4.5. Сургууль хамт олноороо ямар амжилтад хүрч байна вэ?				
Бүртгүүлсэн, тодорхой мэдлэг ойлголттой болсон	Хүрэл гэрэгэний үр дүнд хүрсэн	Мөнгөн гэрэгэний үр дүнд хүрсэн	Ногоон тугийн үр дүнд хүрсэн	Ногоон тугийн үр дүнд дахин хүрсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ГҮЙЦЭТГЭЛ: ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.4.6. Оролцогч “бүх” талуудын оролцооны ерөнхий түвшин ямар байв?				
Бүх талуудын оролцоо хангалтгүй байна	Зарим талуудын оролцоо сайжирч байгаа боловч зарим нь бараг л оролцоогүй хэвээр байна	Оролцогч талууд сургуулийн засаглалаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаандаа бүгд оролцдог болсон	Оролцогч талуудын үйл ажиллагаа жигдэрч оролцоо сайжирсан	Оролцогч талууд нягт хамтран ажиллаж үр дүн ч нь сайн байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.4.7. Гүйцэтгэлийн үнэлгээний дүн /сургуулийн, нэгжийн, хувь хүний ажлын гүйцэтгэлийн тайлан/ хэр ил тод байна бэ?				
Үнэлгээний дүн нь ил тод биш байна	Хувь хүний ажлын тайланг хэлэлцэж байгааг эс тооцвол төдийлөн нээлттэй биш	Энэ дүн өмнөх үеэс илүү тод болж байгаа	Байгууллагын бүх түвшний гүйцэтгэлийн үнэлгээний дүн нээлттэй, ил тод байгаа	Зөвхөн оролцогч талуудын төдийгүй иргэдэд цахим хэлбэрээр нээлттэй байдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.4.8. Гүйцэтгэлийн үнэлгээ /сургуулийн, нэгжийн, хувь хүний ажлын гүйцэтгэлийн тайлан/ хэр шударга явагддаг вэ?				
Ихэнхдээ шударга бус, хувь хүн болон багйууллагад үр өгөөж муутай	Сургуулийн болон нэгжийн түвшинд бол боломжийн боловч хувь хүний түвшинд шударга бус байдал байсаар байна	Үнэлгээнд шударга бус байдал байхгүй байж болно	Шударга бус хандсан талаар ямар нэг гомдол санал гараагүй	Үнэлгээнд бүх талууд сэтгэл ханамжтай болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.4.9. Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээ тэгш байдалд хэр нийцэж байна вэ?				
Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээнд тэгш бус байдал, элдэв ялгаварлал байсаар байна	Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээнд ялгаварлал ажиглагддаг	Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээнд ямар нэгэн ялгаварлал ажиглагдахаа больж байгаа	Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээнд ялгаварлал, тэгш бус явдал байсан талаар санал, гомдол гараагүй	Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээ тэгш байдалд бүрэн нийцсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.4.10. Сургууль дахь гүйцэтгэлийн үнэлгээ нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан хэрэгжүүлж байгаа сургууль, багш, суралцагчдын үнэлгээтэй уялдаж байна уу?				
Эко сургуулийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж байна	Гүйцэтгэлийн үнэлгээнд улмаар сургуулийн үйл ажиллагааг үнэлэх БСШУС-ын яамны аргачлалыг хэрэглэнэ	Эдгээрт тулгуурлан илүү сайжруулах, шалгуур үзүүлэлтүүдийг тодотгохоор ажиллаж байна	Яамны аргачлалуудад үндэслэнэ, улмаар үр нөлөө зэргийг илүү тодруулж гүйцэтгэлийг үнэлэхэд анхаарч байна	Сургуулийн түвшний гүйцэтгэлийн үнэлгээний тусгайлсан аргачлалыг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ нь БСШУС-ын яамны аргачлалтай уялдаатай, шалгуур үзүүлэлт, тооцох арга зүйгээрээ илүү дэвшилттэй
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 5. МАНЛАЙЛАЛ: ЧАДВАР, НӨЛӨӨЛӨЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.5.1. ТХБ-ыг суралцагчдад эзэмшүүлэх нэгдмэл үнэт зүйл, стратеги, зорилгод бүх талууд хүчээ нэгтгэж чадсан уу?				
Сургуулийн удирдлагын баг байгууллагын үнэт зүйл, алсын хараа, стратегийг тодорхойлсон боловч түүнд бусад талуудын хүчийг нэгтгэх чадвар дутагдаж байна	Байгууллагын зорилго, хэрэгцээг хувь хүний зорилго, хэрэгцээтэй уялдуулах чадвар дутагдаж байна	Бүгдээрээ нэг зорилго, үнэт зүйлтэй гэдэг итгэл үнэмшлийг хамт олондоо төрүүлж эхэлж байна	Сургуулийн удирдлагын баг нэгдмэл үнэт зүйл, стратегид хамт олноо нэгтгэж чадсан	Сургуулийн удирдлагын баг хамт олноо нэгдмэл үнэт зүйл, стратегид нэгтгэж, түүний төлөө идэвх санаачилгатай ажиллах сэдлийг төрүүлж чадсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.5.2. Удирдлагын баг нь оролцогч талууд, хүн бүрийн идэвх санаачилгыг өрнүүлж, дэмжиж чаддаг уу?				
Оролцогч талуудыг хамтын ажиллагаанд уриалж чадаж байгаа боловч идэвхийг өрнүүлж чадаагүй байна	Удирдлагын баг нь оролцогч талуудтай хамтран ажиллах мэдлэг эзэмшсэн боловч бодит ажил болгохдоо тулгамдаж байна	Сургуулийн хамт олны идэвх санаачилгыг өрнүүлэх зорилгод үйл ажиллагаа хэрэгжүүлж чадаж байна	Сургуулийн хамт олныг идэвхжүүлэх арга барил эзэмшсэн, бусад оролцогч талуудтай ажиллах чадвартай	Удирдлагын баг нь бусдад нөлөөлж, тэднийг идэвхжүүлэх өндөр чадвартай
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.5.3. Сургуулийн удирдлагын баг нь ялгаатай үзэл бодлыг мэдэрч, хамтран ажиллахад чиглүүлж, дасгалжуулж чаддаг уу?				
Ялгаатай үзэл бодлыг мэдэрч хамтран ажиллахад чиглүүлж, дасгалжуулах чадвар дутагдаж байна	Ийм чадварт суралцаж байна	Ийм чадварыг зохих түвшинд эзэмшиж байна	Хамт олныг үлгэрлэн хөгжүүлж чаддаг болсон	Хамт олныг хамтран ажиллах арга ухаанд сургаж, хамт олны таатай уур амьсгалыг бүрдүүлж чадсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.5.4. Өөрийгөө байнга хөгжүүлэн шинэ содон зүйлийг соргог мэдрэн, сэдэн үйлдэж бусдыг дагуулах чадварыг удирдлагын баг хэр эзэмшсэн бэ?				
Энэ чадваруудыг төдийлөн эзэмшээгүй	Өөрийгөө хөгжүүлэх талаар анхаарч байдаг боловч бусдад нөлөөлж, дагуулах чадвар одоохондоо сул байна	Эдгээр дөрвөн чадварын заримыг нь хэр эзэмшсэнийг дүгнэж чадахгүй ч боломжийн чадварлаг гэж болно	Эдгээр чадваруудаар хамт олныг үлгэрлэж чадаж баайаа	Эдгээр чадваруудыг маш сайн эзэмшсэн, байнга содон, сонирхолтой байж чаддаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.5.5. Удирдлагын багийн үйл ажиллагааны үр нөлөөг үнэлнэ үү?				
Үр нөлөөтэй байж чадахгүй байна	Зарим үр дүн байгаа ч бодлогоор "үр нөлөө"-тэй ажиллахгүй байна	Удирдлагын багийн үйл ажиллагаа, үр нөлөөг тооцдог болсон	Оролцогч талуудад үзүүлэх үр нөлөөг тооцож байгаа нь ажиглагддаг болсон	Төлөвлөж, зохион байгуулж байгаа үйл ажил бүр давхар зорилготой, хэтийн нөлөөг сайн тооцдог
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 5. МАНЛАЙЛАЛ: ЧАДВАР, НӨЛӨӨЛӨЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.зас.5.6. Хүн бүрийг сонсож, санал бодлыг хүндэтгэн хүлээн авч, хамтдаа хэлэлцэн шийдвэр гаргах удирдлагын багийн чадвар ямар байна вэ?				
Удирдлагын баг ихэнхдээ хүн бүрийг сонсон, санал бодлыг нь хүлээн аваад байдаггүй, асуудлыг өөрсдөө л хэлэлцэж шийдвэрлэдэг	Удирдлагын баг нь хүн бүртэй нөхөрсөг харилцан санал бодлыг анхааралтай сонсдог боловч асуудлыг хамт олонтойгоо тэр бүр хэлэлцэж шийдвэрлэдэггүй	Удирдлагын баг бусдын санал бодлыг хүлээн авч шаардлагатай тохиолдолд асуудлыг хэлэлцдэг	Удирдлагын баг шийдвэр гаргахдаа хүн бүрийн санал бодлыг судалж, аль болох хамтаараа хэлэлцэж шийдэлд хүрэх арга барилаар ажилладаг	Хамт олноороо бие биедээ хүндэтгэлтэй хандаж, бүгд санал бодлоо солилцож байж шийдэлд хүрдэг уламжлалтай болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.5.7. Баг, багаар бүтээмжтэй ажиллаж, бие биеийхээ туршлагаас суралцаж, хамтаараа эрч хүчтэй, итгэл төгс, хүсэл эрмэлзлэлтэй ажилладаг болсон уу?				
Бид багаар биш нэгж нэгжээр ажилладаг бөгөөд бие биеийхээ туршлагаас тэр бүр суралцдаггүй, мэдээлэл солилцоод байдаггүй	Багаар ажиллах арга зүйд суралцаж байна.	Төлөвлөсөн үйл ажиллагааг баг баг хариуцан зохион байгуулж, аль баг юу хийж байгаагаа нээлттэй болгож чадсан	Удирдлагын баг нь багийн менежментийг хэрэгжүүлж чаддаг	Удирдлагын баг нь бидэнтэй хамтран багаар ажиллаж, үйл ажиллагааг нээлттэй болгосноор илүү сонирхолтой, бүтээмжтэй ажилладаг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.5.8. Удирдлагын багийн хариуцлага, ёс суртахууны байдлыг үнэлнэ үү?				
Хариуцлага, ёс суртахууны төлөвшил тааруу гэж үзэж болно	Зарим үед хариуцлагагүй хандах, ёс суртахууны доголдол гаргах тохиолдол бий	Маш цөөн тохиолдолд л энэ талаар дутагдал гарсан	Ямар нэгэн зөрчил дутагдал сүүлийн жилд гаргаагүй, цаашдаа ч итгэж болно	Энэ талаар бусдыг үлгэрлэгч, итгэл даах хариуцлагатай, ёс суртахууны эрхэмлэх чанар төлөвшсөн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.5.9. Хүн бүрийн сэтгэл зүйн ялгаатай төлөв байдалд тохируулан харилцаж, нөлөөлж чаддаг уу?				
Харилцааны явцад тэгш бус хандан ноцтой зөрчил гаргаад байдаггүй ч хүний сэтгэл зүйн онцлогт нийцүүлэн харилцах эв дүй дутмаг	Харилцааны явцад хүнийг сонсож, хүндэтгэн, үг хэллэг оновчтой байх боловч хүнийг ойлгох, нөлөөлөх чадвар сул байдаг	Харилцааны зохих чадвартай, ялгаварлан, тэгш бус ханддаггүй, бусдыг ойлгон нөлөөлөх чадвар дунд зэрэг	Харилцааны чадвар сайтай, ялгаварлал, тэгш бус хандлагагүй	Харилцааны өндөр чадвартай
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.зас.5.10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012), Авлигын эсрэг хууль (2006)-ийн заалтуудыг удирдлагын баг өөрсдөө болон хамт олноороо даган мөрдөх байдал ямар байна вэ				
Эдгээр хуулийг сурталчилах, дагаж мөрдөх байдалд зорилготой ахиц дэвшил ажиглагдахгүй байна	Хуулийн талаар мэдлэг түгээдэг боловч бодит байдалд өөрчлөлт бага байна	Ашиг сонирхлын болон авилгын талаар ямар нэгэн зөрчил маргаан гардаггүй	Энэ талаар системтэй сургалт, төлөвшлийн арга хэмжээнүүдийг авдаг, нийтийн хяналт сайжирсан, удирдлагын баг болон хамт олон даган мөрдөх байдал хэвшсэн	Энэ талаар бүх түвшинд ямар нэгэн зөрчил гардаггүй, цаашид ч энэ байдал тогтвортой байх бүхий л нөхцөл, чадавх бүрдсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.1.2. ЕБС–ийн УДИРДАХ АЖИЛТАН: ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫН ХӨГЖИЛ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, АЖИЛЛАГААНЫ ТАВИЛ

Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.1.1. Танай сургуулийн хөгжлийн бодлого, практик үйл ажиллагаа болон бүтцийн нэгжүүд хоорондын зохицуулах механизмууд нь хүний нөөцөө чадавхжуулахад хэр зэрэг нийцсэн байдаг вэ?				
... зориулагдсан нийтлэг дүрэм журмыг мөрддөг	... зориулагдсан боломжуудыг шинээр хайн судалж байна	... зориулагдсан хөгжлийн тасралтгүй хэрэгцээг хангаж чадахуйц уян хатан, нээлттэй оновчтой бүтэц, механизмыг бий болгож чадсан	... зориулагдсан бүтэц, механизмууд үр өгөөжтэй ажиллаж эхэлсэн	... зориулагдсан бүтэц, механизмууд нийцтэй, үр өгөөжтэй, үр ашигтай, тогтвортой ажилладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.1.2. Танай сургуулийн орчинд суралцагч үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргахад оролцох, өөрийн итгэл үнэмшилтэй байх, нэр төрөө эрхэмлэх, бие махбод, оюун ухаан, сэтгэл санааны аливаа хүчирхийлэл, доромжлол, бэртэл гэмтэлд өртөхөөс хамгаалуулах эрхээ эдлэх боломжийг олгосон бодлого, эрх зүй, ёс зүйн харилцааг зохицуулсан дүрэм журмууд ямар түвшинд үйлчилж байна вэ?				
... нийтлэг дүрэм, журмыг мөрддөг. Тэдгээрийн үйлчилгээ нь хүүхдийн эрхийг цогцоор нь бүрэн дүүрэн эдлүүлдэг гэдэгт эргэлздэг	... -ыг хүүхдийн эрхийн бүрэлдэхүүн хэсэг бүрийг нарийвчлах, сургууль дээр тэдний эрхийг эдлүүлэх, хамгаалахад тохиолдож буй сорилт, асуудлуудын шалтгааныг илрүүлэх судалгааг эхлүүлсэн	Судалгаа хийнгээ суралцаж, судалгааны үр дүнд тулгуурлан ... -ыг сайжруулах үндэслэл, арга замыг тодруулж, холбогдох бодлого, дүрэм, журмаа "Хүний эрхэд суурилсан арга хандлага"-ын дагуу шинэчилсэн	"Хүний эрхэд-суурилсан арга хандлага"-д суурилсан бодлого, эрх зүй, ёс зүйн шинэ механизмуудыг хэрэгжүүлж эхэлснээр энэ арга хандлага нь зардал хэмнэдэг, асуудлыг цогцоор нь шийдвэрлэдэг, шударга ёсыг дэмждэг ач холбогдолтойг хамт олноороо мэдэрч, эхэлсэн	Нэг талаас, багш, суралцагч, бусад оролцогчдын эрхээ эдлэх, эдлэхийг шаардах нөгөө талаас, үүрэг гүйцэдгэгч үүргээ гүйцэдгэх чадавх нь нэмэгдэхийн хэрээр эрхээ хэрэгжүүлэх эрх мэдэлтэй болж, хүний эрхийг хүндэлдэг нийгэмд шилжих үндэс суурийг тавигдаж байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.1.3. Жендэрийн тэгш бус байдалд нөлөөлдөг нийгэм, соёлын ялгаанаас үүдэлтэй эрэлтийн болон сургуулийн бүхий л үйл ажиллагаанд шингэсэн байдаг нийлүүлэлтийн хүчин зүйлсийн хамаарлыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн стандарт, дүрэм журмуудын үйлчлэл аль түвшинд байна вэ?				
Эрэлт ба нийлүүлэлтийн хүчин зүйлсэд юу ордгийг гүйцэд, сайн мэдэхгүй тул тэдгээрийн тэнцвэржилтийг цогцоор нь хангасан зохицуулалт учир дутагдалтай байна	Эрэлт ба нийлүүлэлтийн хүчин зүйлсийг тус тусад нь үнэлж, дүгнэх судалгааг хийж байна	Энэ асуудлыг харилцан хамааралд авч үзэн судалж, дүгнэлт зөвлөмж гарган, бодлого, төлөвлөгөөний төслүүд боловсруулсан	Боловсруулсан төслүүдээ өргөн хүрээнд хэлэлцүүлж батлаад хэрэгжилтийг зохион байгуулж эхэлсэн	Баталсан бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг тохируулах үнэлгээ (assessment) ба дүгнэх үнэлгээ (evaluation)-ний арга хэрэгслүүд боловсруулан хэрэглэж байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.1.4. Танай сургуулийн хөгжлийн бодлого, практик үйл ажиллагаанд дэлхийн иргэний боловсролын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлс, ёс суртахууны кодуудыг интеграцчилахад шаардагдах хүний нөөцийн чадавх аль түвшинд байна вэ?				
Энэ чадавх сайн бүрдээгүй байна. Учир нь хүмүүсийн ойлголт, мэдлэг тодорхой бус, эмх цэгц муутай, харилцан адилгүй байна	Ийм чадавхыг хөгжүүлэх сургалтын болон бусад дэмжлэгийн хэрэгцээг судлах хүрээнд асуудалтай танилцаж байна	Хүний нөөцийн чадавхаа хөгжүүлэх чиглэлээр зорилтот бүлгүүдэд зориулсан төлөвлөгөө, хөтөлбөрүүд боловсруулж, олон арга хэлбэрийн сургалтууд зохион байгуулж байна	Хүний нөөцийн ялангуяа, багшийн чадавхын хөгжилд ахиц гарч, сургалын болон бусад үйл ажиллагаанд дэлхийн иргэний боловсрол интерацчилагдаж байна	Дэлхийн иргэний боловсролын хүрээнд олсон амжилт, туршлагаа сум, аймаг, үндэсний түвшинд сурталчилж, туршлага хуваалцагч болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.1.2. ЕБС–ийн УДИРДАХ АЖИЛТАН: ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫН ХӨГЖИЛ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, АЖИЛЛАГААНЫ ТАВИЛ

Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.1.5. Та сургуулийнхаа хөгжлийн алсын харааг тодорхойлох болон түүнд дөхөх үйл хэрэгт хэр зэрэг оролцдог вэ?				
"... алсын хараа"-ны талаар тодорхой ойлголтгүй байна	... алсын харааг тодорхойлоход оролцоогүй	... алсын харааг тодорхойлоход оролцсон	... алсын хараанд дөхөх үйл хэрэгт ухамсартайгаар хувь нэмрээ оруулдаг	... алсын хараагаа илүү тодорхой болгох шаардлагатай гэж үздэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.1.6. Танай сургууль хүний нөөцийн чадавхаа дайчлан илрүүлж бүрэн ашигладаг уу?				
... чадавхын талаар тодорхой сайн ойлголтгүй байна	... чадавхаа дайчлан илрүүлдэггүй, бүрэн ашигладаггүй	... чадавхаа дайчлан илрүүлдэггүй, илэрсэнээ бүрэн ашигладаг	... чадавхаа дайчлан илрүүлдэг ч бүрэн ашигладаггүй	... чадавхаа дайчлан илрүүлдэг, бүрэн ашигладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.1.7. Бусад сургууль ба олон нийтийн сүлжээнд хамтран ажиллах танай сургуулийн хүний нөөцийн болон технологийн чадавх аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Хүний нөөцийн чадавх нь зөвхөн сургууль, эцэг эх, олон нийтийн хүрээнд, сум/дүүргийн түвшний сүлжээнд	Хүний нөөц болон технологийн чадавх нь зөвхөн сургууль, эцэг эх, олон нийтийн хүрээнд, сум/дүүргийн түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиуд, олон нийтийн хүрээнд, аймаг/нийслэлийн түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиудын хүрээнд, үндэсний түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиудын хүрээнд, олон улсын түвшний сүлжээнд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.1.8. Танай сургуулийн хүний нөөцийн чадавх нь сургуулийнхаа 1) хэмжээ (хүүхдийн тоо) 2) бүтэц (5,9,12 жилийн), 3) байршил (баг, сум, аймаг/нийслэлийн төвд буюу хот, хөдөөд), 4) үйлчлүүлэгчдийн тусгай хэрэгцээ (малчдын хүүхэд-дотуур байр, гадаад хэл дээрх сургалт г.м.) , 5) хэв шинж (гүнзгийрүүлсэн, төрөлжсөн олон улсын хамтарсан г.м.)-ийн онцлогтой хэр зэрэг нийцдэг вэ?				
Зөвхөн 1 онцлогт нийцсэн	Эдгээрээс 2 онцлогт нийцсэн	Эдгээрээс 3 онцлогт нийцсэн	Эдгээрээс 4 онцлогт нийцсэн	5 онцлогт нийцсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.1.9. Танай сургуулийн албан тушаалтан бүрийн албан тушаалын тодорхойлолтод тэдний үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа, тэдгээрийн гүйцэтгэлд тавигдах шаардлагууд эрэмбэлэгдэн уялдсан байдаг уу? Тэдгээрийг уялдуулах арга механизм бий юу?				
... нь хоорондоо хэр зэрэг эрэмбэлэгдэн уялдсан байдгийг сайн мэдэхгүй	Миний ажлын байр ба бусад ажлын байрны ... нь хоорондоо хангалттай түвшинд эрэмбэлэгдэж уялдаагүй	Миний ажлын байр ба бусад ажлын байрны ... нь хоорондоо хангалттай түвшинд эрэмбэлэгдэн уялдсан	Албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлэх нийтлэг болон тусгай арга механизмууд байдаг ч сайн үйлчилдэггүй	Албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлэх нийтлэг болон тусгай арга механизмууд сайн үйлчилдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.1.10. Танай сургууль хүний нөөцийн чадавхаа хөгжүүлэхэд бусад сонирхогч талууд болон түншлэгчдийг татан оролцуулж, ямар түвшинд хамтран ажилладаг вэ?				
... шаардлагатай хэрэгцээ ба хөрөнгө, хүчийг үнэлж тодорхойлдог	... шаардлагатай гэж үзвэл сонирхогч болон түншлэгч талуудыг татан оролцуулдаг	... зориулсан тусгай төлөвлөгөө, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг	Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх төрөл бүрийн хариу арга хэмжээ авдаг	Хүний нөөцийн чадавхын хөгжлийг тогтмол үнэлж, цаашдын хэрэгцээ, зорилтоо тодорхойлдог
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.2.1. Та ТХЗ-ууд ялангуяа, ТХЗ 4-ыг хангахад бусдад нөлөөлж, урам зориг өгч, зорилгодоо хүрэх, улмаар тэднийг өөрийнхөө зорилгын хязгаараас давж урагшлахад нь сэдэл тэмүүлэлтэй болгоход нь ямар түвшинд илүү нөлөөлдөг вэ?				
...би хийж үглгэрлэдэг, тэд анхааралтай ажигладаг, бид ярилцдаг	... би хийж үглгэрлэдэг, тэд тусалдаг, бид ярилцдаг	... тэд хийдэг, би тусалдаг, бид ярилцдаг	... тэд хийдэг, би анхааралтай ажигладаг, бид ярилцдаг	... тэд хийдэг, тэднийг хэн нэгэн анхааралтай ажигладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.2.2. Боловсролын үйлчилгээ үзүүлэх хамран тойргийнхоо хүүхэд, залуучууд, иргэдэд чанартай боловсрол эзэмшүүлэх тэгш боломж (equality) олгох, үл алагчилал (equity)-ыг хэрэгжүүлэх, ялгаварлан гадуурхал (discrimination)-аас сэргийлэх, хүн бүрийн тусгай хэрэгцээг багтаасан (inclusive) байх, тогтолцооны гадна хэнийг ч үлдээхгүй (exclusion) байх зэрэг хүний эрхийн чухал стратегийг хэрэгжүүлэхэд таны манлайлал аль түвшинд байна вэ?				
Эдгээр стратегиуд, тэдгээрийн хоорондох ялгаа, харилцан хамаарлыг сайн ялгаж ойлгодоггүй. Би өөрийгөө манлайлагчийн аль хэв маягт илүү хамаарагдахаа мэддэг	Би өөрийгөө эдгээр стратегийг хэрэгжүүлэхэд хамт олноо манлайлж, орон нутагтаа эергээр нөлөөлөх боломжтой удирдагчдын нэг гэж үздэг	Эдгээр стратегийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх менежментийг манлайлахад миний ур чадварт ямар ямар сул тал, зааг завсар (gap) байгаа талаар би байнга эрэгцүүлж боддог	Эдгээр стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай манлайллын ур чадвараа хөгжүүлэх талаар залгамж чанартай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг	Хүний эрхийн салбар дахь карьерийн зорилгоо тодорхойлж, манлайллын ур чадвараа хэрэгжүүлэхэд болон ирээдүйн удирдагчид зориулсан замын зураглал боловсруулдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.2.3. Жендэрийн тэгш байдал (gender equality)-ыг хангах чиглэлээр сектор дамнан арга хандлагад суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мөн сургуульдаа Жендэрийн мэдлэг (gender aware) ба мэдрэмжтэй (gender sensitive), жендэрийн харалган (Gender blind) бус шинжтэй сургалт, үйл ажиллагааг төлөвшүүлэхэд Таны өөрөө үлгэрлэн манлайлах чадвар аль түвшинд байна вэ?				
Эдгээр ойлголт, ухагдахуун, тэдгээрийн хоорондох ялгаа, харилцан хамаарлыг сайн ялгаж ойлгодоггүй. Би өөрийгөө манлайлагчийн аль хэв маягт илүү хамаарагдахаа мэддэг	Би өөрийгөө эдгээр ойлголтыг ухагдахууны сүлжээнд нь танин мэдэж, хамт олноо манлайлж, орон нутагтаа эергээр нөлөөлөх боломжтой удирдагчдын нэг гэж үздэг	Эдгээр ойлголтыг үйл ажиллагаандаа тусгах, менежментийг манлайлахад шаардлагатай миний ур чадварт ямар сул талууд, зааг завсар (gap) байгаа талаар би байнга эрэгцүүлж боддог	Эдгээр ойлголтыг амжилттай интеграцчилахад шаардлагатай манлайллын ур чадвараа хөгжүүлэх талаар залгамж чанартай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг	Жендэрийн тэгш байдлын талбар дахь өөрийн карьерийн зорилгоо тодорхойлж, манлайллын ур чадвараа хэрэгжүүлэхэд болон ирээдүйн удирдагчид зориулсан замын зураглал боловсруулдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.2.4. Танай сургууль дэлхийн иргэний боловсролын танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн, зан үйлийн түвшинд харгалзах мэдлэг чадварын ач холбогдол хийгээд "Дэлхийн түвшинд сэтгэж, нутгийн түвшинд үйлдэх" гэсэн стратегийг орон нутгийнхаа иргэдэд таниулан сурталчлах, тэднийг манлайлах үйл ажиллагаа аль түвшинд явагдаж байна вэ?				
... сурталчлах, тэднийг манлайлах ажиллагаа манай сургууль дээр эхлээгүй байна	... сурталчлах, тэдэнд нөлөөлөх арга замыг судалж, төлөвлөгөө боловсруулсан	Орон нутгийн иргэд, олон нийтийг сургуулийн жижиг төсөлд татан оролцуулах замаар тэдний арга хандлагад нөлөөлж байна	Орон нутгийнхаа иргэдэд дэлхийн иргэний боловсролын хэрэгцээ, агуулга, ач холбогдлыг сурталчилж, тэдний боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг болсон	Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, олон нийт дэлхийн иргэний боловсролын хүрээнд санаачилга гаргаж, хөрөнгө босголцож, сургуультай олон арга хэлбэрээр хамтран ажилладаг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.2.5. Та сургуульдаа, салбартаа юуны төлөө боловсролын хувирган өөрчлөлт хийх хэрэгтэй байгааг ямар түвшинд урьдчилан харж байна вэ?				
Хувирган өөрчлөлт, өөрчлөлт шинэчлэл, өөрчлөлт зэрэг ойлголт, тэдгээрийн хэрэгцээ ба зорилгын ялгаатай талуудыг тодорхой мэдэхгүй	Дэлхий нийтийн, үндэсний, сургуулийн түвшинд юуны төлөө боловсролын хувирган өөрчлөлтийг хийх хэрэгтэй болсон мөн энэ хүрээнд юу хийхээр төлөвлөж, баталсныг ерөнхийд нь төсөөлнө	Дэлхий нийтийн, үндэсний, сургуулийн түвшинд боловсролын хувирган өөрчлөлтийн хүрээнд юу хийхээр төлөвлөж баталсныг тодорхой сайн мэднэ	Сургуулийнхаа менежментийг хувирган өөрчлөхийн тулд юуг шинээр хийх шаардлагатайг ерөнхийдөө мэднэ	Сургуулийнхаа менежментийг хувирган өөрчлөх хүрээнд юуг шинээр хийх шаардлагатайг сайн мэднэ
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.2.6. Та сургуулийнхаа болон салбарынхаа зорилгын төлөө бусдад нөлөөлж, урам зориг өгч, бусдыг сэдэл тэмүүлэлтэй болгоход ямар түвшинд хувь нэмэр оруулдаг вэ?				
Ур чадвар, тууштай байдал, хамтрагчдаа хүндэлдэг, зөв зам мөртэй, хариуцлагатай, сайн зан чанартай зэрэг байхыг хичээдэг	Зорьсондоо хүрэх итгэл үнэмшилтэй, "хийж чадна" гэсэн зорилгыг хандлагатай, хүмүүсийнхээ урам зоригийг бадраадаг, тэдэнд тусалдаг, өөдрөг сэтгэл, урам зоригтой ажилладаг	Хүмүүсийг сонсдог, тэдний хэрэгцээ, сайн сайхан байдал нь санаа тавьдаг, манлайлын чадавхыг хөгжүүлдэг, тэдэнтэй шинийг "хамтран бүтээх"-ийн төлөө ажилладаг	Хамтрагчдаа мэхэлдэггүй, шинийг санаачилж, шинийг хийх үед нь тулгарсан сорилттой нь хамт тэднийг орхидоггүй, харин хамтдаа алдаан дээрээ суралцаж, гайхалтай үр дүнд хүрэхийг уриалдаг	Өөртөө итгэлтэй, өөрийгөө сурталчлах чадвартай ч даруу байхыг хичээдэг. Алдаа гаргавал түүнийгээ хүлээн зөвшөөрч, гол нь бусдыг нухацтай сонсож, тэдний санал хүсэлтийг авч алдаанаасаа суралцах ёстой гэж үздэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.2.7. Та тодорхой нэг зорилгын төлөө сонгосон байгууллага, хүмүүстэй мэдээлэл солилцож, харилцаа холбоотой байхын тулд тухайн сүлжээнд хэрхэн ажилладаг вэ?				
Сүлжээ үүсгэнэ гэдэг нь хүмүүстэй уулзаж, харилцах үйл явц учраас харилцаандаа хүндэтгэлтэй, ёс зүйтэй, мэргэжлийн байхыг эрмэлздэг	Тухайн хүн болон байгууллагын нэр, чиг үүрэг, ажил мэргэжлийн талаарх товч мэдээлэл олж, сүлжээнд ажиллах зорилгоо урьдчилан тодорхойлдог	Мэдээлэл болон яриагаа товч, тодорхой бэлтгэж, мэдээлэл солилцоходоо аль болох бусдын цагийг шаардлагагүй зүйлд үрэхгүйг хичээдэг	Танд цаг, зав гаргаж, үнэтэй мэдээлэл солилцсоны төлөө харилцагч нартаа талархал илэрхийлэхийг чухалчилдаг	Сүлжээндээ идэвхтэй ажиллаж, тогтоосон холбоо харилцаагаа хадгалж байхыг хичээдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.2.8. Танай сургуулийн хувирган өөрчлөгдөх үйл явц дахь эрсдэл (гамшгийн, үйл ажиллагааны, санхүүгийн, стратегийн гэсэн төрөлтэй)-ийн менежмент дэх Таны манлайлал аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуульд тохиолдож болох эрсдэлийн төрлүүдийг мэргэжлийн экспертүүд, хамт олонтойгоо хамтран байнга эрэмбэлж, болзошгүй эрсдлийг тодорхойлж байдаг	Эрсдэл гарах магадлал болон эрсдэлийн нөлөөллийн зэргийг түүний давтамж, ноцтой байдлаар тооцож, хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө зардлын зураглал хийдэг	Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, эрсдэлийг хянаж урьдчилан сэргийлэх, шилжүүлэх зэрэг байж болох бусад шийдлийг үнэлдэг	Боломжит бүх шийдлээс сонгон шийдвэр гаргаж, шаардлагатай нөөцүүдийг бэлтгэн, худалдан авалт хийж, уг шийдвэрээ дэс дараатай, тууштай хэрэгжүүлэн албан ёсны үйл ажиллагаа болгон хувиргадаг	Албажсан үйл ажиллагаагаа дэмжиж, эрсдэлийн соёлыг хөгжүүлснээр байгууллага аливаа өөрчлөлтийн өмнө илүү уян хатан, дасан зохицох чадвартай болдог
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.2.9. Танай сургуулийн хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх (ХНЧХ) менежментийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний оновчтой, шат дараалсан, тууштай, үр өгөөжтэй, тогтвортой байдал аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Шинэ стратеги боловсруулахын өмнө сургуулиа дотоод, гадаад орчинд нь сайтар судлаж, зорилго, бүтэц, албан тушаалын чиг үүргүүд, ажиллах хүч, түүний чадавх зэргийг үнэлж, хамт олныхоо урам зориг, тэдэнд учирч буй сорилт, бэрхшээлийг олж мэддэг	Судалгааны үр дүндээ тулгуурлан хүний нөөцийн хөгжлийн бүхий л чиглэлийг хамарсан шинэ стратеги боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх бүх оролцогчдод танилцуулж ойлгуулдаг	Шинэ стратеги хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхын, санхүүгийн, ложистик нөөцийг шинжилж, одоо байгаа болон шинээр шаардагдах нөөцийг харьцуулан зөрөөг тооцож, нөөц хомсдолтой байгаа бол санхүүжилт татах арга замыг судалж, санхүүжилт босгодог	Хүрэлцээтэй нөөцтэй, төгс стратегитэй байгаад ч тодорхой арга хэмжээ авч, үйл хийхгүй бол тэдгээр нь үнэ цэнтэй эрдэм чадал болон хувирч чаддаггүй тул хэрэгжилтэд онцгой ач холбогдол өгч, үйл явцыг дуустал нь үргэлжлүүлдэг	Стратеги хэрэгжүүлэх үйл явцыг дагаж хянах замаар гарч буй ахиц дэвшил, төлөвлөлтөөс зөрж хазайсан өөрчлөлтүүдийг тус тус илрүүлж, тэдгээрийн шалтгааныг олж тогтоон цаг тухайд нь тохиргоо хийж залруулж ажилладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.2.10. Үйл ажиллагаандаа дотроосоо болон гаднаас мэргэжлийн экспертүүдийг татан оролцуулах, тэднийг тогтоон барих сургуулийн тогтолцоо ба механизмын бүрдүүлэлт мөн жендэрийн зөрөөтэй байдлын индекс-ЖЗБИ (gender parity) аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуулийн дэвшүүлсэн зорилго, зорилтыг хангах, тулгамдаж буй сорилт, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай байгаа чиглэлээр эксперт ажиллуулах хэрэгцээг тодруулдаг. Сургуульдаа ЖЗБИ-ийг 0.97-оос 1.03-т дөхүүлэх бодлого баримталдаг	Эксперт урихдаа хувь хүнийг тодорхойлдог гол хүчин зүйлс болох төрөлхийн авьяас чадвар, боловсрол, мэргэшил, туршлага, нийгэм дэх идэвхтэй сүлжээ буюу салбартаа тогтоосон харилцаа зэргийг судалж, экспертүүдийн нөөцийн жагсаалт гаргадаг	Эксперттэй үр өгөөжтэй хамтран ажиллахын тулд сургуулийн нөөц ба чадавх, бүтэц, тогтолцоо ба үйл явцууд, манлайлал, дотоод сүлжээ, сургалт, багууд зэрэг хүчин зүйлсийн онцлогоо тооцож, зохих бэлтгэлийг хангадаг	Сургуулийнхаа тогтвортой хөгжлийг хангахын тулд хамт олон дундаасаа экспертүүдийг өсгөн бойжуулах бодлогын хүрээнд ухаалаг, гүйцэдгэл сайтай, хүмүүсийг ажилд авч, тэднийг хөгжүүлэх, хадгалах, гадагш нь алдахгүй ажиллуулах стратеги баримталдаг	Сургуульдаа аль болох олон тооны өөрийн экспертүүд бойжуулж, тэднийг тасралтгүй хөгжүүлэх, тууштай ажиллуулах, тогтоон барих, дэвшсэн ч эргэх холбоотой ажиллах зорилттой ажилладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.3.1. Тогтвортой хөгжил (ТХ), ногоон хөгжил (НХ), тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ), тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол (ТХЗБ)-ын талаарх мэдлэг, ТХБ-ын болон тогтвортой байдлын цогц чадамжуудын төлөвшил аль үе шатанд илүү харгалзаж байна вэ?				
.. -тай холбоотой түлхүүр үг, нэр томъёо, тэдгээрийн хоорондох харилцан хамаарлыг өөрт байгаа арга хэрэгслийг ашиглан хайх замаар эхлээд хөгжүүхийг хүсэж буй мэдлэг, чадвараа тодорхойлдог	... -тай холбоотой ухагдахуун, тэдгээрийн хоорондох холбоосуудыг үүсгэн ухагдахууны сүлжээ зурж, өөрийн үгээр товч тэмдэглэл хийх замаар тэдгээрийг хэрэглэхэд бэлтгэж, цаашид өөрөө болон бусадтай хамтран баяжуулан, гүнзгийрүүлж суралцдаг	... -тай холбоотой зарим сэдвүүд, харилцан хамаарлуудыг ойлгохгүй, хэрэглэж чадахгүй байгаа “гох дэгээ”-г олж тайлахын тулд мөн өөр өнцгөөс хандахын тулд дахин дахин уншиж, бичиж, эргэцүүлж, агуулгыг эзэмшдэг	... тай холбоотой хэвлэмэл, аудио, видео, болон цахим эх сурвалжуудыг ашиглан тухайн сэдэв, үзэл баримтлалтай холбоотой танин мэдэхүйнхээ хамрах хүрээг аажмаар өргөжүүлдэг	... -тай холбоотой мэдлэгийн гүнзгийрэл, ур чадварын өсөлтөө байнга өөрөө шалгаж үнэлж, хөгжүүлж байдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.3.2. Хүний эрхэд суурилсан арга хандлага, түүний зарчмууд болон боловсролд хамрагдах, чанартай боловсрол эзэмших, сургуулийн орчинд хүндлүүлэх суралцагчийн эрх, мөн эдгээр эрхийг эдлүүлэх үүрэг хүлээсэн гүйцэтгэгчдийн үүргийн талаарх мэдлэг, чадвар, тэдгээрийн хэрэглээ, үр дүн аль шатанд илүү харгалзаж байна вэ?				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, эмх цэгц муутай байна	Эдгээр асуудлыг судалж эхлэх буюу тэдгээртэй танилцаж байна	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүрэгтэй холбоотой мэдлэгээ гүнзгийрүүлж, тодорхой үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлж байна	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүрэгтэй холбоотой мэдлэг, туршлагаа үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүргүүд сургуулийн үйл ажиллагаанд бүрэн нэвтэрч, эерэг үр нөлөөгөө өгдөг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.3.3. Жендэрийн дүн шинжилгээ хийх (Gender analyses), жендэрийн асуудлыг харгалзсан төлөвлөлт хийх (Gender- responsive planning), жендэрийн асуудлыг харгалзсан төсөв боловсруулах, батлуулах (Gender responsive budgeting), жендэрийн асуудлыг харгалзсан арга хэмжээ авах (Gender responsive) мэдлэг, ур чадвар, тэдгээрийн хэрэглээ аль шатанд илүү харгалзаж байна вэ?				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, эмх цэгц муутай байна	Эдгээр асуудлыг судалж эхлэх буюу тэдгээртэй танилцаж байна	Эдгээр суудалтай холбоотой мэдлэгээ гүнзгийрүүлж, тодорхой үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлж байна	Эдгээр ур чадвартай холбоотой мэдлэг, туршлагаа үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна	Эдгээр ур чадваруудаа ашиглан сургуулийн үнэлгээ, судалгаа, төлөвлөлт, төсөвлөлтөд жендэрийн асуудлууд харилцан уялдаатайгаар бүрэн тусаж, эерэг үр нөлөөгөө өгдөг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.3.4. Дэлхийн иргэний боловсрол нь “Суралцахуйд эрхэмлэх үнэт эрдэм” сэдэвт Делорсын илтгэл (1996), Бага, дунд боловсролын стандарт, кирриюлимьг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлалын суралцахуйн 4 тулгуур багана (2002), ТХЗ 4.7 ба насан туршийн болон амьдралын олон талт агуулга (lifelong, life-wide) бүхий боловсрол (2015)-той тус тус хэрхэн холбоотойгоор хөгжиж ирсэн замналын талаар танай хамт олны мэдлэг, чадвар аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
... талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, уялдаа холбоогүй, эмх цэгц муутай байна	... талаарх ойлголт, мэдлэгээ цэгцлэх болон асуудлуудын хоорондох холбоо хамаарлыг тогтоох чиглэлээр судалгаа хийж байна	... хүрээнд асуудлуудын хоорондох холбоо хамаарлыг илрүүлснээр хүний эрх, жөндөрийн тэгш байдал, тогтвортой хөгжлийн сургуулийн түвшний бодлого, стратегиүдтэй холбох арга замыг эрэлхийлж байна	Дурдагдсан стратегиүдийг сургуулийн менежмент, үйл ажиллагаанд цогцоор нь интеграцчилах төлөвлөгөө боловсруулсан	Боловсруулсан төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлсэн ба энэ интеграцчилалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга хэрэгсэл боловсруулан туршиж эхэлсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.3.5. Дэлхий нийтийн болон үндэсний түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн замнал болон хувирган өөрчлөлтийн алсын хараа, зорилго, зорилтын талаарх Таны мэдлэг аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Монгол Улсын ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар ерөнхийд нь мэддэг	Монгол Улсын ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын тодорхой сайн мэддэг	Дэлхий нийтийн түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар ерөнхийд нь мэддэг	Дэлхий нийтийн түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар тодорхой сайн мэддэг	Дэлхий нийтийн болон үндэсний түвшинд боловсролыг хувирган өөрчлөх 2030 он хүртлэх алсын хараа, зорилго, зорилтууд, тэдгээрийн бие биедээ эрэмбэлэгдсэн байдлын тодорхой сайн мэддэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.3.6. Суралцахуй ба эзэмшихүйн зүй тогтол, багшлахуйн конструктив арга хандлагын талаарх Таны мэдлэг, чадвар аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Тодорхой нэг судлагдахууны дидактикт суурилсан багшлах түвшинд	Хэд хэдэн судлагдахууныг интеграцчилах дидактикт суурилсан багшлах түвшинд	Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх түвшинд	Дидактикийн онол, арга зүйгээр зөвлөн туслах түвшинд	Дидактикийн онол, арга зүйгээр магадлан шинжлэх түвшинд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.3.7. Та өөрийн мэргэжил, эрхэлж буй албан тушаалд тавигдах мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд аль түвшний (үйл ажиллагаа (operatioanal)-ны, хувь хүн (personal)-ний, стратеги (strategic)-ийн сүлжээг хэр зэрэг ашигладаг вэ?				
Өөрийн мэргэжил, эрхэлж буй албан тушаалын гүйцэтгэлд тавигдах мэдлэгээ гүнзгийрүүлж, чадвараа хөгжүүлэхэд сүлжээний олон түвшин, төрлийг хэрхэн ашиглахаа тодорхой сайн мэдэхгүй байна	Ажлыг үр өгөөжтэй явуулах, гүйцэдгэлийн чадавхыг тэтгэх зориулалттай үйл ажиллагааны түвшний сүлжээнд ажилладаг. Энэ түвшний сүлжээ нь голдуу удирдлагаас өгөгдөх үүрэг даалгавартай холбоотой тул хувь хүний хэрэгцээг хангахдаа хязгаарлагдмал байдаг	Хувь хүний хөгжлийн асуудлуудаа шийдвэрлэхдээ сонирхол нэгтэй мэргэжлийн болон төгсөгчдийн холбоо, клубт элсэн сургуулиас гадуурх танилын хүрээгээ тэлж, мэдээлэл солилцох, дадлагажих суралцах замаар хувь хүний хөгжлийг дэмждэг сүлжээнд ажилладаг	Хувийн сүлжээний тусламжтайгаар өөрийгөө болон илүү өргөн хүрээтэй орчныг танин мэдэж, мэргэжлийн нийгэмлэгт олсон харилцаагаа сургуулийнхаа зорилгод нийцүүлэн ашигладаг манлайлагч болж хөгжихийн тулд хувийн сүлжээгээ өргөжүүлэн ажилладаг	Техникийн чадавхаа хөгжүүлэхдээ үндэсний болон дэлхий нийтийн түвшинд сэтгэж, сургууль, орон нутгийнхаа түвшинд үйлдэн боловсролын хувирган өөрчлөлтийг хөшүүрэгдэхэд хувь нэмрээ оруулахын тулд стратегийн түвшний сүлжээнд ажилладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.3.8. Хувь хүн мэргэжлийн болон бусад хүрээний чадавхаа хөгжүүлэх эрэлт хэрэгцээгээ хангахад өнөөгийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны үйлчлэл буюу энэ чиглэлээр сургууль, орон нутаг, үндэсний түвшнөөс үзүүлж буй дэмжлэг туслалцаа аль төлөв байдалд илүү харгалзаж байна вэ?				
МД тогтолцоон дахь албан сургалтуудын агуулга, арга зүй нь сургалтын хөтөлбөрийн хөгжлийн тухайн үеийн онцлог хэрэгцээнд төвлөрдөг, багш, ажилтан бүрийг хамруулдаг, хүлээн зөвшөөрөгдөн гэрчилгээждэг, улс ба орон нутгийн төсвөөр санхүүжигдэж тогтворжсон давуу талуудтай. Энэ төрлийн сургалт давтамж холтой, хугацаа богинотой, агуулга ихтэй байдгаас хувь хүнд ачаалалтай, бэрхшээлтэй, тулгасан шинжтэй байдаг сул талтай	Үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшинд захиргааны ба мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулагддаг, тэдний боловсруулсан агуулга, арга зүй бүхий МД төрөлжсөн сургалтуудаас сонгон суралцах боломжт олгодог ч санхүүжилт ба цаг хугацааны нөөц хомс, хувь хүнийхээ хөгжлийн төлөө хийсэн чармайлтаа хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулах боломж хязгаарагдмал байдаг	Аль ч түвшний байгууллагаас зохион байгуулж буй сургалт, үйл ажиллагааны зорилго, хэрэгцээ, цаг хугацаа нь дээд түвшний удирдлагаас хүчтэй хамааралтай өөрөөр хэлбэл, хүний нөөцийн чадавхын хөгжилд чиглэсэн үйлчилгээ нь хувь хүмүүсийн бодит хэрэгцээ, боломжинд бус үйлчилгээ үзүүлэгч талын нийлүүлэлтэд давамгайлж байгаа тул суралцагч бүрийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, боломжид бүрэн нийцэхийг зорьдог	Сургуулиас бусадтай харилцаж, нийгэм-соёл, зан үйлийн хүрээний хандлага, дадлага, туршлагаа хөгжүүлэх боломж олгодог интерактив сургалтууд мөн хувь хүний үнэт зүйл, сонирхол, хандлага, ажил мэргэжлийн хүлээлт, суралцах хэв маяг, хөгжлийн боломж зэргээ шинжин бие даасан шийдвэр гаргаж, өөрийгөө хөгжүүлэх боломж олгодог арга зам (цахим мэтийн)-уудыг хөгжүүлж, оновчтой, хослуулан ашиглахад анхаарч ажилладаг	Ирээдүйн хэрэгцээнд баримжаалсан тасралтгүй өсөн нэмэгдэж буй хэрэгцээ нь гүйцэдгэж буй ажил үүргийнхээ хүлээлтийг нарийвчлан тодруулах, гүйцэдгэлийн сайжруулалтыг чухалчилах, ажил үүргийн ерөнхий ба эрхэм ховор чадварууд мөн янз бүрийн хам нөхцөлд зөөгдөн хэрэглэгдэх бусад ерөнхий цогц чадамж эзэмших үйл явцыг дэмждэг насан туршийн сурацахуйн зарчим, арга хэлбэрийг хөгжүүлэх стратеги барьдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.3.9. Насан туршын суралцахуйн стратегийн хүрээнд ТХ-ын төлөөх загвар сургуульд шаардагдах мэргэжлийн тасралтгүй хөгжлөө хангахарТа аль түвшинд ажиллаж байна вэ?				
Юу мэдэж, чаддаг болсон, юу мэдэж, чадаж байгаа, юуг илүү мэдэж чадахыг хүсэж байгаагаа эрэгцүүлж бодож өөрийгөө таниж мэддэг	Хүссэн мэдлэг, чадвараа хэрхэн эзэмших арга замаа тодорхойлж, хүрэх үр дүн, ахиц дэвшлээ хянах алхмуудаа төлөвлөдөг	Төлөвлөгөөний дагуу ажиллаж, суралцах үйлээ нээлттэй байлгаж, өдөр тутмын суралцахуйн үр өгөөжөө дээд хэмжээнд байлгахын тулд туршлагажих үйлийнхээ талаар тогтмол эрэгцүүлэн боддог	Онолоо практикт хувиргах, сурсан зүйлээ ажилдаа нэвтрүүлэх, мэдлэгээ гүнзгийрүүлэх, хамт олны дэмжлэгээс ашиг тус хүртэхийн тулд өөрийн мэдлэгээ олон нийттэй хуваалцдаг	Хийж буй ажилд суралцахуй маань ямар үр нөлөө үзүүлж байгааг хэмжиж үнэлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.3.10. ТХ/ТХБ-ын талаар танай сургуулийн багш, ажилтан, эцэг эх болон иргэд, олон нийтэд хүргэж буй мэдлэг, мэдээллийн агуулга, энэ төрлийн боловсролын үйлчилгээний менежмент, үр өгөөж ямар түвшинд байна вэ?				
Сум/дүүрэгт энэ төрлийн үйл ажиллагаа үе үе явагддаг ч түүний агуулга, менежмент, үр өгөөжийг үнэлж сайн мэдэхгүй	Сум/дүүрэгт энэ төрлийн үйл ажиллагаа үе үе явагддаг ба уг арга хэмжээ нь сонирхолтой, хэрэгцээтэй агуулгатай байдаг	Сургууль энэ төрлийн үйл ажиллагааг эцэг эх, олон нийттэй хамтарч, чухал агуулга, сонирхолтой хэлбэрээр тогтмол зохион байгуулж, тэдний хандлагад нөлөөлдөг	Хүмүүсийн ажил, амьдралын тодорхой хэрэгцээнд нийцсэн, сонирхолтой арга хэмжээ үе үе явагдаж, тэдний мэдлэг, хандлагад зарим өөрчлөлтүүд гарч эхэлсэн	Хүмүүсийн ажил, амьдралын олон талт хэрэгцээнд нийцсэн, системтэй үйл ажиллагаа тогтмолжиж, тэдний мэдлэг, хандлага, зан үйлд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
<p>у.хнх.4.1. Танай сургуульд эгэх хариуцлагын соёлыг хөгжүүлэх үйл явц нь таны болон хамт олны тогтвортой байдлын түлхүүр 8 цогц чадамж (тогтолцоон сэтгэлгээ; урьдчилан тооцоолох; хэм хэмжээг мөрдөх; стратеги боловсруулах хэрэгжүүлэх; хамтран ажиллах; шүүмжлэлт сэтгэлгээ; өөрийгөө таньж мэдэх; асуудал шийдвэрлэх)-ын эзэмшилт, төлөвшлийн түвшнээс хэр зэрэг хамаарч байна вэ?</p>				
Хамааралтай эсэхийг хэлж мэдэхгүй. Учир нь хүмүүс эдгээр асуудлаар нэгдсэн ойлголтгүй, өөр өөрийн төсөөлөлтэй байна	Хамааралтай гэж таамаглаж байна. Гэвч эдгээр асуудлыг дөнгөж судалж эхэлсэн, тэдгээртэй танилцаж байна	Хамааралтай гэж боддог болсон. Учир нь эгэх хариуцлагын тодорхой үйл гүйцэдгэхдээ эдгээр цогц чадамжыг хэрэглэж, эзэмшиж байна	Хамааралтай гэж итгэх хариуцлагад эдгээр цогц чадамжуудыг хэрэглэдэг болсноор хүмүүс өөрчлөгдөж үүрэг хариуцлагын гүйцэдгэл эрс сайжирсан	Нийт хамт олон хамааралтай гэсэн итгэл үнэмшилтэй болсон. Учир нь эгэх хариуцлага ба тогтвортой байдлын цогц чадамжууд нь байгууллагад шинэ соёл авчирч чадсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<p>у.хнх.4.2. Эрх эзэмшигч эрхээ эдлэх, үүрэг хүлээгч үүргээ биелүүлэх харилцааг зохицуулах механизмыг дэмждэг, хүний эрхэд суурилсан арга хандлагыг хэрэгжүүлэхэд тусалдаг "Сайн хөтөлбөр"-ийн талаарх Таны мэдлэг чадвар аль түвшинд байна вэ?</p>				
"Сайн хөтөлбөр"-ийн талаар тодорхой мэдэхгүй байна	"Сайн хөтөлбөр"-ийн талаар судалж эхлэсэн буюу түүнтэй танилцаж байна	"Сайн хөтөлбөр"-ийн талаар нарийвчлан судалж, сургуулийн "Сайн хөтөлбөр"-тэй болсон	Сургуулийнхаа "Сайн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байна	Сургуулийнхаа "Сайн хөтөлбөр"-ийн явцын болон үе шатны гүйцэдгэлийг үнэлдэг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<p>у.хнх.4.3. Жендэрийн тэгш байдлыг хангаж буй эсэхийг хэмжих индикаторууд бүхий хэсэгчилсэн болон иж бүрэн жендэрийн анализын арга хэрэгсэл, мөн сонирхогч болон түншлэгч талуудыг оролцуулсан эргэх холбооны механизмыг тус тус бүтээж, жендэрийн асуудлыг сургуулийн өөрийн үнэлгээний гол шалгуурын нэг болгон нотолгоонд суурилсан, ил тод шийдвэр гаргах соёлын төлөвшил аль түвшинд байна вэ?</p>				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань сургуулийн түвшинд нэлээд ерөнхий, эмх цэгц муутай, хамтрагч ба түншүүд ойлголтын зөрөө их байна	Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буй эсэхийг хэмжих үнэлгээний төрлүүд, тус бүрийнх нь шалгуур, индикаторууд, арга аргачлалыг боловсруулж байна	Жендэрийн тэгш байдлыг хангах талаар хамтрагч, түншлэгч нартаа сурталчилж, жендэрт суурилсан эргэх холбооны механизмыг бий болгож байна	Жендэрийн мэдлэг, мэдрэмжтэй, жендэрийн тэгш оролцоотой байх шаардлага үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна	Жендэрийн тэгш байдалд суурилсан эгэх хариуцлагын тогтолцоо бүрэлдэж байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.4.4. Дэлхийн иргэний боловсролын хүрээнд сургуульд боловсролын үйлчилгээ эрхлэгчид ба тэдний үйлчлүүлэгч нар, мөн хяналтын ажилтнуудын үйл ажиллагааны уулзварт бусад сонирхогч, хувь нийлүүлэгч бүх талуудыг татан оролцуулах систем, механизмыг бий болгох, тэдний санал хүсэлтийг авч ашиглах эргэх холбоо тогтоох, түүнчлэн шаардлагатай платформуудыг ашиглах чадавх, бэлэн байдал ямар түвшинд бүрдсэн бэ?				
Үйлчилгээ эрхлэгчид, үйлчилгээ хүртэгчид, хяналтын албаныхан (үндсэн оролцогчид)-тай харилцаж, зохих эрх зүйн зохицуулалтын хүрээнд тэдний санал хүсэлтийг авч ашиглах түвшинд	Үндсэн оролцогчдоос гадна бусад сонирхогч ба хувь нийлүүлэгч талуудыг татан оролцуулах механизм, платформуудыг ашиглах түвшинд	Бүх талуудтай эргэх холбоо тогтоож, үйл ажиллагаагаа зохицуулах бэлэн байдал хангагдах түвшинд	Бүх талуудтай тогтоосон эргэх холбоогоо ашиглан тэднээс суралцах, өөрийгөө зохицуулах, өөрчлөх түвшинд	Эгэх хариуцлагын хүрээнд гаргах шийдвэр нь хууль ёсны, ил тод байх, хариу үйлдэл үзүүлэх чадавх дээшилсэн, эрх ашгийн нөлөөлөл буурсан байх түвшинд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.4.5. Танай сургуульд эгэх хариуцлагын тогтолцоог хэр бүрэн гүйцэт тодорхой, ойлгомжтой түвшинд бүрдүүлж, ажиллуулдаг вэ?				
Эгэх хариуцлагын ажиллагаа сайтай тогтолцоо бүрэлдээгүй	Эгэх хариуцлагын тогтолцоог тодорхой, ойлгомжтой байдлаар боловсруулж баталгаажуулсан ч түүнийг бүрэн мөрдөж ажилладаггүй	Энэ тогтолцоон дахь шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчид ба сонирхогч талуудын санал, хүсэлтийг тусгах механизмын ажиллагаа доголдолтой	Энэ тогтолцоон дахь шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчид ба сонирхогч талуудын санал, хүсэлтийг тусгах механизмын ажиллагаа сайн..	Эгэх хариуцлагын биелэлтийг тооцож ажиллах соёл төлөвшиж байгаа..
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.4.6. Танай сургуулийн хамт олны гишүүн бүр өөрийн дуу хоолойгоо илэрхийлэх, үр өгөөжтэй шийдвэрлүүлэх тогтолцоо механизм хэр зэрэг үр өгөөжтэй ажилладаг вэ?				
Хамт олны гишүүд дуу хоолойгоо сургуулийн удирдлагад хүргэж санал хүсэлтээ илэрхийлдэг, тэдгээрийг оновчтой зөв шийдвэрлүүлдэг эгэх хариуцлагын инклюзив тогтолцоо, механизм бүрэн бүрдээгүй байна	Хамт олон санал хүсэлтээ илэрхийлж, үр дүн шаардахад зориулагдсан тусгай журам боловсруулж, энэ үйл ажиллагаанд мөрдөх зөв хэм хэмжээг тогтоох чиглэлд сургуулийн удирдлагууд санаачилгатай, үр нөлөөтэй ажилладаг	Хамт олны гишүүдээс дуу хоолойгоо хүргэж буй зан үйл, өнгө аяс, түүнд бусад хүмүүсийн татагдан оролцох байдал зэргийг судалж, хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг	Хамт олны гишүүн бүр дуу хоолойгоо илэрхийлж, санал хүсэлт санаачилга гаргахад нь шаардлагатай нөөц боломжоор хангаж, тэднийг сонсож, хүлээн зөвшөөрч, урамшуулж, харилцан ойлголцож, уян хатан ажилладаг	Сургуулийн удирдлага хамт олны дуу хоолойг хүлээн авах, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлдэг тасралтгүй “суралцагч байгууллагын” эгэх хариуцлагын дэвшилтэт соёл төлөвшиж байна
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.4.7. Та болон танай байгууллагын удирдлагууд эгэх хариуцлагын хүрээнд хариу үйлдэл үзүүлэх чадвараа нэмэгдүүлэх, гаргасан шийдвэр нь ил тод, хууль ёсны байлгахад ямар шалгуур тавьж, хэрхэн ажилладаг вэ?				
Тухайн асуудлыг судлан хэлэлцэж, шийдвэрлэх шаардлагатай асуудал мөн болохыг хүлээн зөвшөөрч, гаргах шийдвэрийнхээ зорилгыг тодорхойлдог	Асуудлын шийдлийг дэнслэн үнэлэх, сонголт хийхэд шаардлагатай шалгуур, индикаторыг боловсруулж, холбогдох мэдээлэл цуглуулдаг	Шийдвэрийн хувилбаруудыг хууль эрх зүйн зөрчилгүй байхаар боловсруулж, тэдгээрээс улбаалан үүсэж болох үр дагаварыг урьдчилан тооцдог	Шийдвэрийн хувилбаруудыг ил тод хэлэлцэж, шударга, бусдыг хүндэлсэн, амжилтаа хэмжих, урамшуулах боломжтой, эргэлзэхгүйгээр шууд үйлдэж болох, сэтгэл хөдлөлд хөтлөгдөөгүй байх зэрэг "сайн шийдвэр"-ийн үнэт зүйлсийн шалгуурыг дааж чадахуйц эцсийн шийдвэр гаргахыг эрмэлздэг	Эцсийн шийдвэрээ үнэлж, түүний үйлчлэл оновчтой сайн байна гэдэгт итгэлтэй болох, шаардлагатай бол залруулж, сайжруулдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.4.8. Та болон танай сургуулийн удирдлагууд эгэх хариуцлагын хүрээнд бусад байгууллага, нийгмийн бүлгүүдтэй холбоо тогтоон тэдний саналыг авч, өөрийн байгууллагын хөгжлийн хэрэгцээгээ хэр зэрэг ханган ажилладаг вэ?				
Хамтын ажиллагаанд ямар хүндрэл, эрсдэл тохиолдох, ямар үр өгөөж, ашиг тустай байх хүчин зүйлсийг судалж, боломжит түншүүдийн мэдээллийн санг төрөлжүүлэн бүрдүүлдэг, жагсаалт гаргаж, эхний шатны түүвэр хийдэг	Эгэх хариуцлагын циклийн хүрээнд хамтын ажиллагааны зорилго, үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэлд тавигдах шаардлагууд зэргийг агуулсан ажлын даалгавар, гэрээний төсөл боловсруулж баталдаг	Түншлэгчдийн мэдээллийн сангаас эхний шатны түүвэр хийж, хамтран ажиллах санал, танилцуулгыг түүвэрт хамрагдсан хувь нийлүүлэгчдэд хүргүүлж, шаардлагатай бол уулзалт хийж, тэдний санал зөвлөмж, болзлыг сонсдог	Сургуулийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, сургуулийн үнэт зүйлсийн хүндэтгэсэн, үр өгөөжтэй хамтран ажиллах түншлэгчээ сонгон шалгаруулж, шийдвэр гарган хариу мэдэгддэг	Сонгогдсон түнштэйгээ холбогдох гэрээ, хэлцэл байгуулж, хамтын ажиллагааны явцад талуудын хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлтэд хяналт тавьж, зохицуулан ажилладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хнх.4.9. Танай сургууль ТХ-ийн төлөөх загвар сургууль болж хувиран өөрчлөгдөхөд шаардлагатай стратегиүдийг хэрэгжүүлэхийн тулд эгэх хариуцлагын хүрээнд тасралтгүй суралцан хөгжиж, өөрсдийгөө зохицуулан өөрчлөгдөж байгааг үнэлдэг тогтолцоо, арга механизм нь аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуулийн үйлчилгээнд соёл ба зан үйл хоорондын хамаарлыг үл тоомсорлож, соёл, уламжлалын олон янз байдалд бүрэн нийцээгүй, хөгжүүлэлт хийгдээгүй үйлчилгээний тогтолцоо, арга барилыг үйлчлүүлэгчдэд тулгасан (Жишээ нь малчдын хүүхдийн сургалт)-аар, эрэлт, нийлүүлэлтэд зай завсар үүсэж, соёлд сорилт үүсэн буй нь ажиглагддаг. Иймд сургуулийн өөрийн үнэлгээний хяналтын хуудас, бойжилтын загвар, PDCA цикл зэрэг арга хэрэгслийг судалж байна	Сургуулийн үйлчилгээнд далд нуугддаг шударга бус байдал, үйлчлүүлэгчдэд учрах дарамт зэрэг нь тэдний хэрэгцээнд нийцсэн, уян хатан, үл алагчилсан үйлчилгээ бүрэн үзүүлж чадахгүй байх, голдуу үйлчлүүлэгчийн идэвхтэй оролцоог хязгаарлах, эсвэл соёлын ялгаанд нийцсэн боловсролын үйлчилгээг багасгахад хүргэж, үл алагчлах стратегийг хэрэгжүүлэх чадавх илт дутагдаж байна	Соёлын ялгаатай бүлэг бүрийн хүмүүс ижил соёл ба дадал хэвшилтэй байдаг гэсэн соёлын харалган төсөөлөл нь түгээмэл байгаа учраас сургууль нь үүсэл гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн давхарга зэргийн ялгаанаас үл хамааран бүх үйлчлүүлэгчдэд боловсролын "сайн" үйлчилгээг хүргэж, ялгаварлан гадуурхахын эсрэг сурталчилгаа явуулах, холбогдох бодлого, хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй гэж боддог	Сургуулийн үйлчилгээнд нийгэм соёлын хүчин зүйлс хүчтэй нөлөөлдгийг ухаарч, тэдгээрийг цаашид зайлшгүй тооцох нь зүйтэйг мэддэг болсноор соёлын ялгаатай хүн амд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр судалгаа эхлүүлэх, зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах, захиргааны ба мэргэжлийн байгууллагууд, зөвлөх багуудас дэмжлэг тусалцаа авах замаар нийгэм-соёл, зан үйлийн хүрээний цогц чадамжуудаа нэмэгдүүлж эхэлсэн	Үйлчилгээндээ үл алагчлах стратегийг нэвтрүүлэхийн ач холбогдлыг ойлгож, өөрсдийн цогц чадамжуудаа хөгжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч, энэ чиглэлээр сургуулийн өөрийн үнэлгээ хийх, стратеги төлөвлөгөө боловсруулахдаа оролцооны ил тод зарчмыг баримталж, хамт олон тасралтгүй суралцахдаа хүчин чармайлт гаргадаг, соёлын өвөрмөц онцлогт тохирсон үйлчилгээндээ байнгын үнэлгээ ба сайжруулалт хийдэг болсон
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хнх.4.10. Танай сургууль хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоондоо оролцогч талуудын хамтын ажиллагаанд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлийг шийдвэрлэх, эрх ашгийн нөлөөллийг бууруулах шалгуур, индикаторуудын хэрэглээ аль түвшинд байна вэ?				
Хувийн сонирхол буюу эрх ашиг гэж юу болох, тэдгээрт ямар хүчин зүйлс нөлөөлдөг, түүнийг хэрхэн бууруулдаг, үнэлэхдээ ямар индикаторууд хэрэглэдэг талаар сайн мэдэхгүй байна	Түншлэгчдийн сонирхлын зөрчилд нөлөөлдөг хүчин зүйлс нь юу (ашиг орлогын ногдол, хувь хүмүүсийн хандлагын өвөрмөц шинжүүд, үр дүнгийн гинжин хамаарал, үйлдэл хийх үр чадвар) болохыг судалж байна	Эрх ашгийн сонирхолд харгалзан үзэх гол шалгуур болох хувь хүний хандлагын объект ба түүний төрөл (үнэт зүйлийн, сэтгэгдэлийн, гаралтын үр дүнгийн)-үүд болохыг судалж, тэдгээрийг эрх ашгийн нөлөөллийг бууруулах индикаторууд болгон хэрэглэх бэлтгэлээ хангаж байна	Хамтрагч талуудын хоорондох үүсэж болох бодит, эсвэл болзошгүй зөрчил болон талууд өөрсдийн байгууллагууддаа үнэнч байх үүрэг хүлээсэн тохиолдолд үүсэх ашиг сонирхлын зөрчлийг талуудын хооронд байгуулах гэрээгээр, шаардлагатай бол гэрээнд өөрчлөлт оруулж шийдвэрлэдэг	Хамтрагч талуудын эрх ашгийг зохих ёсоор тэнцвэржүүлж, зохицуулаагүй, байгууллага ба нийгмийн хооронд үүссэн ашиг, сонирхлын зөрчил гаргахгүй байхад анхаарч, гарсан тохиолдолд хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.1.3. ЕБС-ийн УДИРДАХ АЖИЛТАН: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хбс.1.1. Сургуулийн сургалтын болон хичээлийн хөтөлбөрт ТХБ-ыг интеграцчилах арга, хандлага (ТХБ-ын цогц чадамж төлөвшүүлэх нэгж, ТХ/ТХБ-той холбогдох сэдэв, ТХ/ТХБ-ын асуудал нь сурагчийн шийдэх асуудал байх г.м.)-ын талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
.....-ын талаар нэгдсэн ойлголт бүрдээгүй, багш бүр өөрийнхөөрөө л хөтөлбөртөө ТХБ-ыг тусгадаг-тай танилцаж, нэгдсэн ойлголт авч байна-ыг хэрэгжүүлэхэд сургуулиараа хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлдэг-ыг бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.1.2. Сургуулийн сургалтын болон хичээлийн хөтөлбөр*-ийг төлөвлөх хэрэгжүүлэхэд хүний эрхэд суурилсан байх зарчим (нэг талаас сурагчийн эрхийг хүндэтгэсэн сургалт, үнэлгээгээр багш бүр, нөгөө талаас хүний эрхийг хангахын төлөөх сургуулийн үйл ажиллагаа соёлоор хүний эрхийн боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэх)-ыг биелүүлдэг үү?				
* -Үндэсний хөтөлбөрийн дагуу нийгмийн ухаан, эрх зүйн боловсролын зэрэг зохих хичээлээр хүний эрхийн тухай заахаас гадна				
.....-ыг биелүүлэх талаар нэгдсэн ойлголтгүй-ыг хэрхэн биелүүлэх талаар танилцаж байна-ыг хэрхэн биелүүлэхэд хийнгээ суралцаж байна-ыг биелүүлдэг-ыг бүрэн биелүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.1.3. Сургуулийн хэмжээнд сургалтын болон хичээлийн хөтөлбөрийг жөндөрийн мэдрэмжтэй төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
..... нэгдсэн ойлголтгүй, багш бүр өөрийнхөөрөө нэгдсэн ойлголттой болох эхлэл тавигдсан ч олон төрлийн хичээлүүдийн хувьд нийтлэг болон ялгаатай талаа тодорхойлоогүй нэгдсэн ойлголттой, хичээл бүрт төлөвлөх, хэрэгжүүлэх онцлогийг тодорхой болгоход багш нар хийнгээ суралцаж байгаа нэгдсэн ойлголттой, хичээл бүрийн хувьд төлөвлөж хэрэгжүүлдэг нэгдсэн ойлголттой, хичээл бүрийн хувьд бүрэн төлөвлөж хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.1.4. Дэлхийн иргэний боловсрол (ардчилсан байдлаар үйлдэх, нийгмийн хариуцлагатай үйлдэх, бүтээлчээр сэтгэх, бусадтай үр дүнтэй, бүтээлчээр харилцах)-ыг эзэмшүүлэх сургуулийн нэгдсэн бодлого, зарчим хэрэгжүүлдэг үү?				
.....гүй, багш бүр өөрийнхөөрөө-тай танилцаж байна-ыг хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлдэг-ыг бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.1.5. Сургуулийн болон хичээлийн хөтөлбөрт ТХ/ТХБ-той холбоотой мэдлэгийг сурагч өөрийн идэвхтэй үйл ажиллагаагаар эзэмшихүйц төлөвлөлт хийж, хэрэгжүүлдэг үү?				
..... хийж, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт байхгүй, багш бүр өөрийнхөөрөө хийж, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголттой танилцаж байна хийж, хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна хийж, хэрэгжүүлдэг хийж, бүрэн дүүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.1.3. ЕБС–ийн УДИРДАХ АЖИЛТАН: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хбс.1.6. Хөтөлбөрт ТХЗ-ын төлөөх оролцооны шинэлэг арга (бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх, шинжилгээ судалгаа хийх, бодит хамтын үйл ажиллагаанд оролцох, алсын хараатай болох)-уудыг оновчтой сонгож бүрэн хэрэгжүүлдэг үү?				
.....уудыг оновчтой сонгож хэрэгжүүлэх нэгдсэн ойлголт бүрдээгүй, багш бүр өөрийнхөөрөө сургалтын аргаа сонгодогуудыг бүтээлчээр сонгож хэрэгжүүлэх талаар танилцаж байнауудыг бүтээлчээр сонгож хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байнауудыг бүтээлчээр сонгож хэрэгжүүлдэгуудыг бүтээлчээр сонгож бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.1.7. Инклюзив (хүйс, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, танин мэдэхүйн, бие бялдар, сэтгэл зүйн нөхцөлөөс үл хамааран) бодож сэтгэх, үйлдэх болон эв нэгдэлтэй байх, хариуцлага хүлээх чадвар, хандлага төлөвших хэмжээнд сургуулийн соёл бүрдсэн үү?				
..... бүрдэх талаар нэгдсэн ойлголтгүй бүрдүүлэх талаар танилцаж байна бүрдүүлэхэд хийнгээ суралцаж байна бүрдүүлсэн бүрэн бүрдсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.1.8. ТХБ нь тусгаар хичээл биш, түүнчлэн аль нэг хичээл дээрх нэмэлт хэсэг ч биш, харин сургуулийн болон хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөний «цөм» болж интеграцчилдаг байх зарчим-ыг хэрэгжүүлдэг үү?				
.....-ын талаар нэгдсэн ойлголтгүй, багш бүр өөрийн хэмжээнд интеграцчилдаг-ын талаар судалж байна-ын талаар хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлдэг-ыг бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.1.9. Харилцан хамааралд нь авч үзэх зарчим (ТХ-ийн үндсэн тулгуур (хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг)-ыг хамарч, орон нутгийн онцлогийг тооцох, соёлын олон янз байдал, түүх, соёлын хам нөхцөлийн ялгааг хүндэтгэх ТХБ-ын зарчим)-ыг хангасан сургуулийн хөтөлбөр-ийг төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
.....-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар судалж байна-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна-ийг төлөвлөж, хэрэгжүүлдэг-ийг мэргэшсэн түвшинд төлөвлөж, хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.1.10. Насан туршийн суралцахуйн чадвар, хандлага (өөрийн удирдлагатай суралцах, өөрийн танин мэдэхүйн онцлогоо мэдэх, дотоод сэдлээ удирдах г.м.) төлөвшүүлэхэд чиглэсэн сургуулийн нэгдсэн хөтөлбөр-ийг төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
.....-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар судалж байна-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна-ийг төлөвлөж, хэрэгжүүлдэг-ийг мэргэшсэн түвшинд төлөвлөж, хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. БАГШЛАХУЙ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хбс.2.1. ТХБ (Байгаль, нийгэмтэй харилцахдаа, өөртөө хандахдаа хамгийн зохистой шийдлийг хийх мэдлэг, чадвар, хандлага)-ыг дэмжсэн багшлахуй үйл ажиллагаа-г хэрэгжүүлдэг үү?				
.....-ны талаар харилцан адилгүй мэдлэгтэй-тай танилцаж байна-нд хийнгээ суралцаж байна-г хэрэгжүүлдэг-г бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.2.2. Багш өөрийн хичээлийн бүхий л үйл ажиллагаандаа «хүний эрхэд суурилсан боловсрол»-ын зарчмын өмнө хүлээсэн үүрэг (Боловсролд хамрагдах эрхийг хангах үүрэг, Чанартай боловсролд хамрагдах эрхийг хэрэгжүүлэх үүрэг, Суралцахуйн орчинд хүүхдийн эрхийг хүндлэх үүрэг)-ээ биелүүлдэг үү?				
.....-ийн талаар нэгдсэн ойлголт байхгүй, багш бүр харилцан адилгүй-тэй танилцаж байна-ийг биелүүлэхэд хийнгээ суралцаж байна-ийг биелүүлдэг-ийг бүрэн биелүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.2.3. Жендэрийн мэдрэмжтэй буюу хичээлийн төлөвлөлт болон анги дахь үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдал, үл алагчлах, хүйсийн ялгаатай онцлог-ийг тооцсон багшлахуйг хэрэгжүүлдэг үү?				
.....-ийг тооцох байдал багш бүрийн хувьд харилцан адилгүй-ийг хэрхэн тооцохтой танилцаж байна-ийг тооцсон багшлахуйг хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна-ийг тооцсон багшлахуйг хэрэгжүүлдэг-ийг мэргэшсэн түвшинд тооцож хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.2.4. Багшлахуйн үйл ажиллагаагаар дэлхийн иргэний боловсрол (ардчилсан байдлаар үйлдэх, нийгмийн хариуцлагатай үйлдэх, бүтээлчээр сэтгэх, бусадтай үр дүнтэй, бүтээлчээр харилцах)-ыг дэмждэг үү?				
.....-ыг хэрхэн дэмжих талаар нэгдсэн ойлголтгүй-ыг хэрхэн дэмжих талаар танилцаж байна-ыг хэрхэн дэмжихэд хийнгээ суралцаж байна-ыг дэмждэг-ыг бүрэн дүүрэн дэмждэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.2.5. Хичээлийн төлөвлөлт болон анги дахь үйл ажиллагаанд ТХ/ТХБ-той холбоотой мэдлэгийг сурагч өөрөө эзэмших арга, хандлага-ыг хэрэгжүүлдэг үү?				
.....-ыг хэрхэн хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголтгүй-ыг хэрхэн хэрэгжүүлэх тухай танилцаж байна-ыг хэрхэн хэрэгжүүлэх талаар хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлдэг-ыг бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. БАГШЛАХҮЙ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
у.хбс.2.6. Судлагдахууны болон сэдвийн онцлогтойгоор оролцооны шинэлэг арга (бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх, шинжилгээ судалгаа хийх, бодит хамтын үйл ажиллагаанд оролцох, алсын хараатай болох)-уудыг хичээл, анги дахь үйл ажиллагаандаа бүтээлчээр сонгож бүрэн хэрэгжүүлдэг үү?				
.....уудыг хичээл, анги дахь үйл ажиллагаандаа сонгож хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголтгүйуудыг хичээл, анги дахь үйл ажиллагаандаа бүтээлчээр сонгож хэрэгжүүлэх талаар танилцаж байнауудыг хичээл, анги дахь үйл ажиллагаандаа бүтээлчээр сонгож хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байнауудыг хичээл, анги дахь үйл ажиллагаандаа бүтээлчээр сонгож хэрэгжүүлдэгуудыг хичээл, анги дахь үйл ажиллагаандаа бүтээлчээр сонгож бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.2.7. Инклюзив (хүйс, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, танин мэдэхүйн, бие бялдрын, сэтгэл зүйн урьдач нөхцөлөөс үл хамааран) бодож сэтгэх, үйлдэх болон эв нэгдэлтэй байх, хариуцлага хүлээх чадвар, хандлага-ын үлгэр дуурайл болох багшлахуйг хэрэгжүүлдэг үү?				
.....-ын талаар нэгдсэн ойлголтгүй	Багш-ын үлгэр дуурайл байх талаар танилцаж байна	Багш-ын үлгэр дуурайл байх талаар хийнгээ суралцаж байна	Багш-ын үлгэр дуурайл болдог	Багш-ын үлгэр дуурайл бүрэн болдог
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.2.8. Судлагдахууны болон сэдвийн онцлогтойгоор ТХБ-ыг хичээл, багшлахуй үйл ажиллагааны «цөм» байхаар интеграцчилах арга, хандлага-ыг хэрэгжүүлдэг үү?				
.....-ын талаар нэгдсэн ойлголтгүй-ыг судалж байна-д хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлдэг-ыг бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
у.хбс.2.9. Багшлахуйд харилцан хамааралд нь авч үзэх зарчим (ТХ-ийн үндсэн тулгуур (хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг)-ыг хамарч, орон нутгийн онцлогийг тооцох, соёлын олон янз байдал, түүх, соёлын хам нөхцөлийн ялгааг хүндэтгэх ТХБ-ын зарчим)-ыг хэрэгжүүлдэг үү?				
б.хнх.1.3. Жендэрийн тэгш бус байдалд нөлөөлдөг нийгэм, соёлын ялгаанаас үүдэлтэй эрэлтийн болон сургуулийн бүхий л үйл ажиллагаанд шингэсэн байдаг нийлүүлэлтийн хүчин зүйлсийн хамаарлыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн стандарт, дүрэм журмуудын үйлчлэл аль түвшинд байна вэ?				
Эрэлт ба нийлүүлэлтийн хүчин зүйлсэд юу ордгийг гүйцэд, сайн мэдэхгүй тул тэдгээрийн тэнцвэржилтийг цогцоор нь хангасан зохицуулалт учир дутагдалтай байна.	Эрэлт ба нийлүүлэлтийн хүчин зүйлсийг тус тусад нь үнэлж, дүгнэх судалгааг хийж байна.	Энэ асуудлыг харилцан хамааралд авч үзэн судалж, дүгнэлт зөвлөмж гарган, бодлого, төлөвлөгөөний төслүүд боловсруулсан.	Боловсруулсан төслүүдээ өргөн хүрээнд хэлэлцүүлж батлаад хэрэгжилтийг зохион байгуулж эхэлсэн.	Баталсан бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг тохируулах үнэлгээ (assessment) ба дүгнэх үнэлгээ (evaluation)-ний арга хэрэгслүүд боловсруулан хэрэглэж байна.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.1.4. Танай сургуулийн хөгжлийн бодлого, практик үйл ажиллагаанд дэлхийн иргэний боловсролын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлс, ёс суртахууны кодуудыг интеграцчилахад шаардагдах хүний нөөцийн чадавх аль түвшинд байна вэ?				
Энэ чадавх сайн бүрдээгүй байна. Учир нь хүмүүсийн ойлголт, мэдлэг тодорхой бус, эмх цэгц муутай, харилцан адилгүй байна.	Ийм чадавхыг хөгжүүлэх сургалтын болон бусад дэмжлэгийн хэрэгцээг судлах хүрээнд асуудалтай танилцаж байна.	Хүний нөөцийн чадавхаа хөгжүүлэх чиглэлээр зорилтот бүлгүүдэд зориулсан төлөвлөгөө, хөтөлбөрүүд боловсруулж, олон арга хэлбэрийн сургалтууд зохион байгуулж байна	Хүний нөөцийн ялангуяа, багшийн чадавхын хөгжилд ахиц гарч, сургалын болон бусад үйл ажиллагаанд дэлхийн иргэний боловсрол интерацчилагдаж байна.	Дэлхийн иргэний боловсролын хүрээнд олсон амжилт, туршлагаа сум, аймаг, үндэсний түвшинд сурталчилж, туршлага хуваалцдаг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.2.2. ЕБС–ийн БАГШ: ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫН ХӨГЖИЛ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, АЖИЛЛАГААНЫ ТАВИЛ

Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
6.хнх.1.5. Та сургуулийнхаа хөгжлийн алсын харааг тодорхойлох болон түүнд дөхөх үйл хэрэгт хэр зэрэг оролцдог вэ?				
"... алсын хараа"-ны талаар тодорхой ойлголтгүй байна.	... алсын харааг тодорхойлоход оролцоогүй	... алсын харааг тодорхойлоход оролцсон.	... алсын хараанд дөхөх үйл хэрэгт ухамсартайгаар хувь нэмрээ оруулдаг	... алсын хараагаа илүү тодорхой болгох шаардлагатай гэж үздэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6.хнх.1.6. Танай сургууль хүний нөөцийн чадавхаа дайчлан илрүүлж бүрэн ашигладаг уу?				
... чадавхын талаар тодорхой сайн ойлголтгүй байна.	... чадавхаа дайчлан илрүүлдэггүй, бүрэн ашигладаггүй	... чадавхаа дайчлан илрүүлдэггүй, илэрсэнээ бүрэн ашигладаг	... чадавхаа дайчлан илрүүлдэг ч бүрэн ашигладаггүй	... чадавхаа дайчлан илрүүлдэг, бүрэн ашигладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6.хнх.1.7. Бусад сургууль ба олон нийтийн сүлжээнд хамтран ажиллах танай сургуулийн хүний нөөцийн болон технологийн чадавх аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Хүний нөөцийн чадавх нь зөвхөн сургууль, эцэг эх, олон нийтийн хүрээнд, сум/дүүргийн түвшний сүлжээнд	Хүний нөөц болон технологийн чадавх нь зөвхөн сургууль, эцэг эх, олон нийтийн хүрээнд, сум/дүүргийн түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиуд, олон нийтийн хүрээнд, аймаг/нийслэлийн түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиудын хүрээнд, үндэсний түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиудын хүрээнд, олон улсын түвшний сүлжээнд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6.хнх.1.8. Танай сургуулийн хүний нөөцийн чадавх нь сургуулийнхаа 1) хэмжээ (хүүхдийн тоо) 2) бүтэц (5,9,12 жилийн), 3) байршил (баг, сум, аймаг/нийслэлийн төвд буюу хот, хөдөөд), 4) үйлчлүүлэгчдийн тусгай хэрэгцээ (малчдын хүүхэд-дотуур байр, гадаад хэл дээрх сургалт г.м.) , 5) хэв шинж (гүнзгийрүүлсэн, төрөлжсөн олон улсын хамтарсан г.м.)-ийн онцлогтой хэр зэрэг нийцдэг вэ?				
Зөвхөн 1 онцлогт нийцсэн.	Эдгээрээс 2 онцлогт нийцсэн.	Эдгээрээс 3 онцлогт нийцсэн.	Эдгээрээс 4 онцлогт нийцсэн.	5 онцлогт нийцсэн.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6.хнх.1.9. Танай сургуулийн албан тушаалтан бүрийн албан тушаалын тодорхойлолтод тэдний үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа, тэдгээрийн гүйцэтгэлд тавигдах шаардлагууд эрэмбэлэгдэн уялдсан байдаг уу? Тэдгээрийг уялдуулах арга механизм бий юу?				
... нь хоорондоо хэр зэрэг эрэмбэлэгдэн уялдсан байдгийг сайн мэдэхгүй	Миний ажлын байр ба бусад ажлын байрны ... нь хоорондоо хангалттай түвшинд эрэмбэлэгдэж уялдаагүй	Миний ажлын байр ба бусад ажлын байрны ... нь хоорондоо хангалттай түвшинд эрэмбэлэгдэн уялдсан	Албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлэх нийтлэг болон тусгай арга механизмууд байдаг ч сайн үйлчилдэггүй	Албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлэх нийтлэг болон тусгай арга механизмууд сайн үйлчилдэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6.хнх.1.10. Танай сургууль хүний нөөцийн чадавхаа хөгжүүлэхэд бусад сонирхогч талууд болон түншлэгчдийг татан оролцуулж, ямар түвшинд хамтран ажилладаг вэ?				
... шаардлагатай хэрэгцээ ба хөрөнгө, хүчийг үнэлж тодорхойлдог.	... шаардлагатай гэж үзвэл сонирхогч болон түншлэгч талуудыг татан оролцуулдаг	... зориулсан тусгай төлөвлөгөө, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.	Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх төрөл бүрийн хариу арга хэмжээ авдаг.	Хүний нөөцийн чадавхын хөгжлийг тогтмол үнэлж, цаашдын хэрэгцээ, зорилтоо тодорхойлдог.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.2.1. Та ТХЗ-ууд ялангуяа, ТХЗ 4-ыг хангахад бусдад нөлөөлж, урам зориг өгч, зорилгодоо хүрэх, улмаар тэднийг өөрийнхөө зорилгын хязгаараас давж урагшлахад нь сэдэл тэмүүлэлтэй болгоход нь ямар түвшинд илүү нөлөөлдөг вэ?				
...би хийж үглгэрлэдэг, тэд анхааралтай ажигладаг, бид ярилцдаг.	... би хийж үглгэрлэдэг, тэд тусалдаг, бид ярилцдаг.	... тэд хийдэг, би тусалдаг, бид ярилцдаг.	... тэд хийдэг, би анхааралтай ажигладаг, бид ярилцдаг.	... тэд хийдэг, тэднийг хэн нэгэн анхааралтай ажигладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.2.2. Боловсролын үйлчилгээ үзүүлэх хамран тойргийнхоо хүүхэд, залуучууд, иргэдэд чанартай боловсрол эзэмшүүлэх тэгш боломж (equality) олгох, үл алагчилал (equity)-ыг хэрэгжүүлэх, ялгаварлан гадуурхал (discrimination)-аас сэргийлэх, хүн бүрийн тусгай хэрэгцээг багтаасан (inclusive) байх, тогтолцооны гадна хэнийг ч үлдээхгүй (exclusion) байх зэрэг хүний эрхийн чухал стратегийг хэрэгжүүлэхэд таны манлайлал аль түвшинд байна вэ?				
Эдгээр стратегийг, тэдгээрийн хоорондох ялгаа, харилцан хамаарлыг сайн ялгаж ойлгодоггүй. Би өөрийгөө манлайлагчийн аль хэв маягт илүү хамаарагдахаа мэддэг.	Би өөрийгөө эдгээр стратегийг хэрэгжүүлэхэд хамт олноо манлайлж, орон нутагтаа эергээр нөлөөлөх боломжтой удирдагчдын нэг гэж үздэг	Эдгээр стратегийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх менежментийг манлайлахад миний ур чадварт ямар ямар сул тал, зааг завсар (gap) байгаа талаар би байнга эрэгцүүлж боддог.	Эдгээр стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай манлайллын ур чадвараа хөгжүүлэх талаар залгамж чанартай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг	Хүний эрхийн салбар дахь карьерийн зорилгоо тодорхойлж, манлайллын ур чадвараа хэрэгжүүлэхэд болон ирээдүйн удирдагчид зориулсан замын зураглал боловсруулдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.2.3. Жендэрийн тэгш байдал (gender equality)-ыг хангах чиглэлээр сектор дамнан арга хандлагад суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мөн сургуульдаа Жендэрийн мэдлэг (gender aware) ба мэдрэмжтэй (gender sensitive), жендэрийн харалган (Gender blind) бус шинжтэй сургалт, үйл ажиллагааг төлөвшүүлэхэд Таны өөрөө үлгэрлэн манлайлах чадвар аль түвшинд байна вэ?				
Эдгээр ойлголт, ухагдахуун, тэдгээрийн хоорондох ялгаа, харилцан хамаарлыг сайн ялгаж ойлгодоггүй. Би өөрийгөө манлайлагчийн аль хэв маягт илүү хамаарагдахаа мэддэг.	Би өөрийгөө эдгээр ойлголтыг ухагдахууны сүлжээнд нь танин мэдэж, хамт олноо манлайлж, орон нутагтаа эергээр нөлөөлөх боломжтой удирдагчдын нэг гэж үздэг	Эдгээр ойлголтыг үйл ажиллагаандаа тусгах, менежментийг манлайлахад шаардлагатай миний ур чадварт ямар сул талууд, зааг завсар (gap) байгаа талаар би байнга эрэгцүүлж боддог.	Эдгээр ойлголтыг амжилттай интеграцчилахад шаардлагатай манлайллын ур чадвараа хөгжүүлэх талаар залгамж чанартай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг	Жендэрийн тэгш байдлын талбар дахь өөрийн карьерийн зорилгоо тодорхойлж, манлайллын ур чадвараа хэрэгжүүлэхэд болон ирээдүйн удирдагчид зориулсан замын зураглал боловсруулдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.2.4. Танай сургууль дэлхийн иргэний боловсролын танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн, зан үйлийн түвшинд харгалзах мэдлэг чадварын ач холбогдол хийгээд "Дэлхийн түвшинд сэтгэж, нутгийн түвшинд үйлдэх" гэсэн стратегийг орон нутгийнхаа иргэдэд таниулан сурталчлах, тэднийг манлайлах үйл ажиллагаа аль түвшинд явагдаж байна вэ?				
... сурталчлах, тэднийг манлайлах ажиллагаа манай сургууль дээр эхлээгүй байна.	... сурталчлах, тэдэнд нөлөөлөх арга замыг судалж, төлөвлөгөө боловсруулсан.	Орон нутгийн иргэд, олон нийтийг сургуулийн жижиг төсөлд татан оролцуулах замаар тэдний арга хандлагад нөлөөлж байна.	Орон нутгийнхаа иргэдэд дэлхийн иргэний боловсролын хэрэгцээ, агуулга, ач холбогдлыг сурталчилж, тэдний боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг болсон.	Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, олон нийт дэлхийн иргэний боловсролын хүрээнд санаачилга гаргаж, хөрөнгө босголцож, сургуультай олон арга хэлбэрээр хамтран ажилладаг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.2.5. Та сургуульдаа, салбартаа юуны төлөө боловсролын хувирган өөрчлөлт хийх хэрэгтэй байгааг ямар түвшинд урьдчилан харж байна вэ?				
Хувирган өөрчлөлт, өөрчлөлт шинэчлэл, өөрчлөлт зэрэг ойлголт, тэдгээрийн хэрэгцээ ба зорилгын ялгаатай талуудыг тодорхой мэдэхгүй.	Дэлхий нийтийн, үндэсний, сургуулийн түвшинд юуны төлөө боловсролын хувирган өөрчлөлтийг хийх хэрэгтэй болсон мөн энэ хүрээнд юу хийхээр төлөвлөж, баталсныг ерөнхийд нь төсөөлнө.	Дэлхий нийтийн, үндэсний, сургуулийн түвшинд боловсролын хувирган өөрчлөлтийн хүрээнд юу хийхээр төлөвлөж баталсныг тодорхой сайн мэднэ.	Сургуулийнхаа менежментийг хувирган өөрчлөхийн тулд юуг шинээр хийх шаардлагатайг ерөнхийдөө мэднэ.	Сургуулийнхаа менежментийг хувирган өөрчлөх хүрээнд юуг шинээр хийх шаардлагатайг сайн мэднэ.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.2.6. Та сургуулийнхаа болон салбарынхаа зорилгын төлөө бусдад нөлөөлж, урам зориг өгч, бусдыг сэдэл тэмүүлэлтэй болгоход ямар түвшинд хувь нэмэр оруулдаг вэ?				
Ур чадвар, тууштай байдал, хамтрагчдаа хүндэлдэг, зөв зам мөртэй, хариуцлагатай, сайн зан чанартай зэрэг байхыг хичээдэг.	Зорьсондоо хүрэх итгэл үнэмшилтэй, "хийж чадна" гэсэн зэрэг хандлагатай, хүмүүсийнхээ урам зоригийг бадраадаг, тэдэнд тусалдаг, өөдрөг сэтгэл, урам зоригтой ажилладаг.	Хүмүүсийг сонсдог, тэдний хэрэгцээ, сайн сайхан байдал нь санаа тавьдаг, манлайлын чадавхыг хөгжүүлдэг, тэдэнтэй шинийг "хамтран бүтээх"-ын төлөө ажилладаг.	Хамтрагчдаа мэхэлдэггүй, шинийг санаачилж, шинийг хийх үед нь тулгарсан сорилттой нь хамт тэднийг орхидоггүй, харин хамтдаа алдаан дээрээ суралцаж, гайхалтай үр дүнд хүрэхийг уриалдаг.	Өөртөө итгэлтэй, өөрийгөө сурталчлах чадвартай ч даруу байхыг хичээдэг. Алдаа гаргавал түүнийгээ хүлээн зөвшөөрч, гол нь бусдыг нухацтай сонсож, тэдний санал хүсэлтийг авч алдаанаасаа суралцах ёстой гэж үздэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.2.7. Та тодорхой нэг зорилгын төлөө сонгосон байгууллага, хүмүүстэй мэдээлэл солилцож, харилцаа холбоотой байхын тулд тухайн сүлжээнд хэрхэн ажилладаг вэ?				
Сүлжээ үүсгэнэ гэдэг нь хүмүүстэй уулзаж, харилцах үйл явц учраас харилцаандаа хүндэтгэлтэй, ёс зүйтэй, мэргэжлийн байхыг эрмэлздэг.	Тухайн хүн болон байгууллагын нэр, чиг үүрэг, ажил мэргэжлийн талаарх товч мэдээлэл олж, сүлжээнд ажиллах зорилгоо урьдчилан тодорхойлдог.	Мэдээлэл болон яриагаа товч, тодорхой бэлтгэж, мэдээлэл солилцоходоо аль болох бусдын цагийг шаардлагагүй зүйлд үрэхгүйг хичээдэг.	Танд цаг, зав гаргаж, үнэтэй мэдээлэл солилцсоны төлөө харилцагч нартаа талархал илэрхийлэхийг чухалчилдаг.	Сүлжээндээ идэвхтэй ажиллаж, тогтоосон холбоо харилцаагаа хадгалж байхыг хичээдэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.2.8. Танай сургуулийн хувирган өөрчлөгдөх үйл явц дахь эрсдэл (гамшгийн, үйл ажиллагааны, санхүүгийн, стратегийн гэсэн төрөлтэй)-ийн менежмент дэх Таны манлайлал аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуульд тохиолдож болох эрсдэлийн төрлүүдийг мэргэжлийн экспертүүд, хамт олонтойгоо хамтран байнга эрэмбэлж, болзошгүй эрсдлийг тодорхойлж байдаг.	Эрсдэл гарах магадлал болон эрсдэлийн нөлөөллийн зэргийг түүний давтамж, ноцтой байдлаар тооцож, хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө зардлын зураглал хийдэг	Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, эрсдэлийг хянаж урьдчилан сэргийлэх, шилжүүлэх зэрэг байж болох бусад шийдлийг үнэлдэг.	Боломжит бүх шийдлээс сонгон шийдвэр гаргаж, шаардлагатай нөөцүүдийг бэлтгэн, худалдан авалт хийж, уг шийдвэрээ дэс дараатай, тууштай хэрэгжүүлэн албан ёсны үйл ажиллагаа болгон хувиргадаг.	Албажсан үйл ажиллагаагаа дэмжиж, эрсдэлийн соёлыг хөгжүүлснээр байгууллага аливаа өөрчлөлтийн өмнө илүү уян хатан, дасан зохицох чадвартай болдог
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.2.9. Танай сургуулийн хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх (ХНЧХ) менежментийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний оновчтой, шат дараалсан, тууштай, үр өгөөжтэй, тогтвортой байдал аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Шинэ стратеги боловсруулахын өмнө сургуулиа дотоод, гадаад орчинд нь сайтар судлаж, зорилго, бүтэц, албан тушаалын чиг үүргүүд, ажиллах хүч, түүний чадавх зэргийг үнэлж, хамт олныхоо урам зориг, тэдэнд учирч буй сорилт, бэрхшээлийг олж мэддэг.	Судалгааны үр дүндээ тулгуурлан хүний нөөцийн хөгжлийн бүхий л чиглэлийг хамарсан шинэ стратеги боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх бүх оролцогчдод танилцуулж ойлгуулдаг.	Шинэ стратеги хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхын, санхүүгийн, ложистик нөөцийг шинжилж, одоо байгаа болон шинээр шаардагдах нөөцийг харьцуулан зөрөөг тооцож, нөөц хомсдолтой байгаа бол санхүүжилт татах арга замыг судалж, санхүүжилт босгодог.	Хүрэлцээтэй нөөцтэй, төгс стратегитэй байгаад ч тодорхой арга хэмжээ авч, үйл хийхгүй бол тэдгээр нь үнэ цэнтэй эрдэм чадал болон хувирч чаддаггүй тул хэрэгжилтэд онцгой ач холбогдол өгч, үйл явцыг дуустал нь үргэлжлүүлдэг.	Стратеги хэрэгжүүлэх үйл явцыг дагаж хянах замаар гарч буй ахиц дэвшил, төлөвлөлтөөс зөрж хазайсан өөрчлөлтүүдийг тус тус илрүүлж, тэдгээрийн шалтгааныг олж тогтоон цаг тухайд нь тохиргоо хийж залруулж ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.2.10. Үйл ажиллагаандаа дотроосоо болон гаднаас мэргэжлийн экспертүүдийг татан оролцуулах, тэднийг тогтоон барих сургуулийн тогтолцоо ба механизмын бүрдүүлэлт мөн жендэрийн зөрөөтэй байдлын индекс-ЖЗБИ (gender parity) аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуулийн дэвшүүлсэн зорилго, зорилтыг хангах, тулгамдаж буй сорилт, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай байгаа чиглэлээр эксперт ажиллуулах хэрэгцээг тодруулдаг. Сургуульдаа ЖЗБИ-ийг 0.97-оос 1.03-т дөхүүлэх бодлого баримталдаг.	Эксперт урихдаа хувь хүнийг тодорхойлдог гол хүчин зүйлс болох төрөлхийн авьяас чадвар, боловсрол, мэргэшил, туршлага, нийгэм дэх идэвхтэй сүлжээ буюу салбартаа тогтоосон харилцаа зэргийг судалж, экспертүүдийн нөөцийн жагсаалт гаргадаг.	Эксперттэй үр өгөөжтэй хамтран ажиллахын тулд сургуулийн нөөц ба чадавх, бүтэц, тогтолцоо ба үйл явцууд, манлайлал, дотоод сүлжээ, сургалт, багууд зэрэг хүчин зүйлсийн онцлогоо тооцож, зохих бэлтгэлийг хангадаг.	Сургуулийнхаа тогтвортой хөгжлийг хангахын тулд хамт олон дундаасаа экспертүүдийг өсгөн бойжуулах бодлогын хүрээнд ухаалаг, гүйцэдгэл сайтай, хүмүүсийг ажилд авч, тэднийг хөгжүүлэх, хадгалах, гадагш нь алдахгүй ажиллуулах стратеги баримталдаг.	Сургуульдаа аль болох олон тооны өөрийн экспертүүд бойжуулж, тэднийг тасралтгүй хөгжүүлэх, тууштай ажиллуулах, тогтоон барих, дэвшсэн ч эргэх холбоотой ажиллах зорилттой ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.3.1. Тогтвортой хөгжил (ТХ), ногоон хөгжил (НХ), тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ), тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол (ТХЗБ)-ын талаарх мэдлэг, ТХБ-ын болон тогтвортой байдлын цогц чадамжуудын төлөвшил аль үе шатанд илүү харгалзаж байна вэ?				
... -тай холбоотой түлхүүр үг, нэр томъёо, тэдгээрийн хоорондох харилцан хамаарлыг өөрт байгаа арга хэрэгслийг ашиглан хайх замаар эхлээд хөгжүүхийг хүсэж буй мэдлэг, чадвараа тодорхойлдог.	... -тай холбоотой ухагдахуун, тэдгээрийн хоорондох холбоосуудыг үүсгэн ухагдахууны сүлжээ зурж, өөрийн үгээр товч тэмдэглэл хийх замаар тэдгээрийг хэрэглэхэд бэлтгэж, цаашид өөрөө болон бусадтай хамтран баяжуулан, гүнзгийрүүлж суралцдаг.	... -тай холбоотой зарим сэдвүүд, харилцан хамаарлуудыг ойлгохгүй, хэрэглэж чадахгүй байгаа “гох дэгээ”-г олж тайлахын тулд мөн өөр өнгөөс хандахын тулд дахин дахин уншиж, бичиж, эргэцүүлж, агуулгыг эзэмшдэг	... тай холбоотой хэвлэмэл, аудио, видео, болон цахим эх сурвалжуудыг ашиглан тухайн сэдэв, үзэл баримтлалтай холбоотой танин мэдэхүйнхээ хамрах хүрээг аажмаар өргөжүүлдэг.	... -тай холбоотой мэдлэгийн гүнзгийрэл, ур чадварын өсөлтөө байнга өөрөө шалгаж үнэлж, хөгжүүлж байдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.3.2. Хүний эрхэд суурилсан арга хандлага, түүний зарчмууд болон боловсролд хамрагдах, чанартай боловсрол эзэмших, сургуулийн орчинд хүндлүүлэх суралцагчийн эрх, мөн эдгээр эрхийг эдлүүлэх үүрэг хүлээсэн гүйцэтгэгчдийн үүргийн талаарх мэдлэг, чадвар, тэдгээрийн хэрэглээ, үр дүн аль шатанд илүү харгалзаж байна вэ?				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, эмх цэгц муутай байна.	Эдгээр асуудлыг судалж эхлэх буюу тэдгээртэй танилцаж байна.	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүрэгтэй холбоотой мэдлэгээ гүнзгийрүүлж, тодорхой үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлж байна.	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүрэгтэй холбоотой мэдлэг, туршлагаа үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна.	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүргүүд сургуулийн үйл ажиллагаанд бүрэн нэвтэрч, эерэг үр нөлөөгөө өгдөг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.3.3. Жендэрийн дүн шинжилгээ хийх (Gender analyses), жендэрийн асуудлыг харгалзсан төлөвлөлт хийх (Gender-responsive planning), жендэрийн асуудлыг харгалзсан төсөв боловсруулах, батлуулах (Gender responsive budgeting), жендэрийн асуудлыг харгалзсан арга хэмжээ авах (Gender responsive) мэдлэг, ур чадвар, тэдгээрийн хэрэглээ аль шатанд илүү харгалзаж байна вэ?				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, эмх цэгц муутай байна.	Эдгээр асуудлыг судалж эхлэх буюу тэдгээртэй танилцаж байна.	Эдгээр суудалтай холбоотой мэдлэгээ гүнзгийрүүлж, тодорхой үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлж байна.	Эдгээр ур чадвартай холбоотой мэдлэг, туршлагаа үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна.	Эдгээр ур чадваруудаа ашиглан сургуулийн үнэлгээ, судалгаа, төлөвлөлт, төсөвлөлтөд жендэрийн асуудлууд харилцан уялдаатайгаар бүрэн тусаж, эерэг үр нөлөөгөө өгдөг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.3.4. Дэлхийн иргэний боловсрол нь “Суралцахуйд эрхэмлэх үнэт эрдэм” сэдэвт Делорсын илтгэл (1996), Бага, дунд боловсролын стандарт, кирриколимийг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлалын суралцахуйн 4 тулгуур багана (2002), ТХЗ 4.7 ба насан туршийн болон амьдралын олон талт агуулга (lifelong, life-wide) бүхий боловсрол (2015)-той тус тус хэрхэн холбоотойгоор хөгжиж ирсэн замналын талаар танай хамт олны мэдлэг, чадвар аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
... талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, уялдаа холбоогүй, эмх цэгц муутай байна.	... талаарх ойлголт, мэдлэгээ цэгцлэх болон асуудлуудын хоорондох холбоо хамаарлыг тогтоох чиглэлээр судалгаа хийж байна.	... хүрээнд асуудлуудын хоорондох холбоо хамаарлыг илрүүлснээр хүний эрх, жендэрийн тэгш байдал, тогтвортой хөгжлийн сургуулийн түвшний бодлого, стратегиүдтэй холбох арга замыг эрэлхийлж байна.	Дурдагдсан стратегиүдийг сургуулийн менежмент, үйл ажиллагаанд цогцоор нь интеграцчилах төлөвлөгөө боловсруулсан	Боловсруулсан төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлсэн ба энэ интеграцчилалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга хэрэгсэл боловсруулан туршиж эхэлсэн.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.3.5. Дэлхий нийтийн болон үндэсний түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн замнал болон хувирган өөрчлөлтийн алсын хараа, зорилго, зорилтын талаарх Таны мэдлэг аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Монгол Улсын ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар ерөнхийд нь мэддэг.	Монгол Улсын ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын тодорхой сайн мэддэг.	Дэлхий нийтийн түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар ерөнхийд нь мэддэг.	Дэлхий нийтийн түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар тодорхой сайн мэддэг.	Дэлхий нийтийн болон үндэсний түвшинд боловсролыг хувирган өөрчлөх 2030 он хүртлэх алсын хараа, зорилго, зорилтууд, тэдгээрийн бие биедээ эрэмбэлэгдсэн байдлын тодорхой сайн мэддэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.3.6. Суралцахуй ба эзэмшихүйн зүй тогтол, багшлахуйн конструктив арга хандлагын талаарх Таны мэдлэг, чадвар аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Тодорхой нэг судлагдахууны дидактик суурилсан багшлах түвшинд	Хэд хэдэн судлагдахууны интеграцчилах дидактик суурилсан багшлах түвшинд	Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх түвшинд	Дидактикийн онол, арга зүйгээр зөвлөн туслах түвшинд	Дидактикийн онол, арга зүйгээр магадлан шинжлэх түвшинд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.3.7. Та өөрийн мэргэжил, эрхэлж буй албан тушаалд тавигдах мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд аль түвшний (үйл ажиллагаа (operatioanal)-ны, хувь хүн (personal)-ний, стратеги (strategic)-ийн сүлжээг хэр зэрэг ашигладаг вэ?				
Өөрийн мэргэжил, эрхэлж буй албан тушаалын гүйцэтгэлд тавигдах мэдлэгээ гүнзгийрүүлж, чадвараа хөгжүүлэхэд сүлжээний олон түвшин, төрлийг хэрхэн ашиглахаа тодорхой сайн мэдэхгүй байна.	Ажлыг үр өгөөжтэй явуулах, гүйцэдгэлийн чадавхыг тэтгэх зориулалттай үйл ажиллагааны түвшний сүлжээнд ажилладаг. Энэ түвшний сүлжээ нь голдуу удирдлагаас өгөгдөх үүрэг даалгавартай холбоотой тул хувь хүний хэрэгцээг хангахдаа хязгаарлагдмал байдаг.	Хувь хүний хөгжлийн асуудлуудаа шийдвэрлэхдээ сонирхол нэгтэй мэргэжлийн болон төгсөгчдийн холбоо, клубт элсэн сургуулиас гадуурх танилын хүрээгээ тэлж, мэдээлэл солилцох, дадлагажих суралцах замаар хувь хүний хөгжлийг дэмждэг сүлжээнд ажилладаг.	Хувийн сүлжээний тусламжтайгаар өөрийгөө болон илүү өргөн хүрээтэй орчныг танин мэдэж, мэргэжлийн нийгэмлэгт олсон харилцаагаа сургуулийнхаа зорилгод нийцүүлэн ашигладаг манлайлагч болж хөгжихийн тулд хувийн сүлжээгээ өргөжүүлэн ажилладаг.	Техникийн чадавхаа хөгжүүлэхдээ үндэсний болон дэлхий нийтийн түвшинд сэтгэж, сургууль, орон нутгийнхаа түвшинд үйлдэн боловсролын хувирган өөрчлөлтийг хөшүүрэгдэхэд хувь нэмрээ оруулахын тулд стратегийн түвшний сүлжээнд ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.3.8. Хувь хүн мэргэжлийн болон бусад хүрээний чадавхаа хөгжүүлэх эрэлт хэрэгцээгээ хангахад өнөөгийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны үйлчлэл буюу энэ чиглэлээр сургууль, орон нутаг, үндэсний түвшнөөс үзүүлж буй дэмжлэг туслалцаа аль төлөв байдалд илүү харгалзаж байна вэ?				
МД тогтолцоон дахь албан сургалтуудын агуулга, арга зүй нь сургалтын хөтөлбөрийн хөгжлийн тухайн үеийн онцлог хэрэгцээнд төвлөрдөг, багш, ажилтан бүрийг хамруулдаг, хүлээн зөвшөөрөгдөн гэрчилгээгдэг, улс ба орон нутгийн төсвөөр санхүүжигдэж тогтворжсон давуу талуудтай. Энэ төрлийн сургалт давтамж холтой, хугацаа богинотой, агуулга ихтэй байдгаас хувь хүнд ачаалалтай, бэрхшээлтэй, тулгасан шинжтэй байдаг сул талтай.	Үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшинд захиргааны ба мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулагддаг, тэдний боловсруулсан агуулга, арга зүй бүхий МД төрөлжсөн сургалтуудаас сонгон суралцах боломжт олгодог ч санхүүжилт ба цаг хугацааны нөөц хомс, хувь хүнийхээ хөгжлийн төлөө хийсэн чармайлтаа хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулах боломж хязгаарагдмал байдаг.	Аль ч түвшний байгууллагаас зохион байгуулж буй сургалт, үйл ажиллагааны зорилго, хэрэгцээ, цаг хугацаа нь дээд түвшний удирдлагаас хүчтэй хамааралтай өөрөөр хэлбэл, хүний нөөцийн чадавхын хөгжилд чиглэсэн үйлчилгээ нь хувь хүмүүсийн бодит хэрэгцээ, боломжинд бус үйлчилгээ үзүүлэгч талын нийлүүлэлтэд давамгайлж байгаа тул суралцагч бүрийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, боломжид бүрэн нийцэхийг зорьдог.	Сургуулиас бусадтай харилцаж, нийгэм-соёл, зан үйлийн хүрээний хандлага, дадлага, туршлагаа хөгжүүлэх боломж олгодог интерактив сургалтууд мөн хувь хүний үнэт зүйл, сонирхол, хандлага, ажил мэргэжлийн хүлээлт, суралцах хэв маяг, хөгжлийн боломж зэргээ шинжин бие даасан шийдвэр гаргаж, өөрийгөө хөгжүүлэх боломж олгодог арга зам (цахим мэтийн)-уудыг хөгжүүлж, оновчтой, хослуулан ашиглахад анхаарч ажилладаг.	Ирээдүйн хэрэгцээнд баримжаалсан тасралтгүй өсөн нэмэгдэж буй хэрэгцээ нь гүйцэдгэж буй ажил үүргийнхээ хүлээлтийг нарийвчлан тодруулах, гүйцэдгэлийн сайжруулалтыг чухалчилах, ажил үүргийн ерөнхий ба эрхэм ховор чадварууд мөн янз бүрийн хам нөхцөлд зөөгдөн хэрэглэгдэх бусад ерөнхий цогц чадамж эзэмших үйл явцыг дэмждэг насан туршийн сурацахуйн зарчим, арга хэлбэрийг хөгжүүлэх стратеги барьдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.3.9. Насан туршын суралцахуйн стратегийн хүрээнд ТХ-ын төлөөх загвар сургуульд шаардагдах мэргэжлийн тасралтгүй хөгжлөө хангахарТа аль түвшинд ажиллаж байна вэ?				
Юу мэдэж, чаддаг болсон, юу мэдэж, чадаж байгаа, юуг илүү мэдэж чадахыг хүсэж байгаагаа эрэгцүүлж бодож өөрийгөө таниж мэддэг.	Хүссэн мэдлэг, чадвараа хэрхэн эзэмших арга замаа тодорхойлж, хүрэх үр дүн, ахиц дэвшлээ хянах алхмуудаа төлөвлөдөг.	Төлөвлөгөөний дагуу ажиллаж, суралцах үйлээ нээлттэй байлгаж, өдөр тутмын суралцахуйн үр өгөөжөө дээд хэмжээнд байлгахын тулд туршлагажих үйлийнхээ талаар тогтмол эрэгцүүлэн боддог.	Онолоо практикт хувиргах, сурсан зүйлээ ажилдаа нэвтрүүлэх, мэдлэгээ гүнзгийрүүлэх, хамт олны дэмжлэгээс ашиг тус хүртэхийн тулд өөрийн мэдлэгээ олон нийттэй хуваалцдаг	Хийж буй ажилд суралцахуй маань ямар үр нөлөө үзүүлж байгааг хэмжиж үнэлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.3.10. ТХ/ТХБ-ын талаар танай сургуулийн багш, ажилтан, эцэг эх болон иргэд, олон нийтэд хүргэж буй мэдлэг, мэдээллийн агуулга, энэ төрлийн боловсролын үйлчилгээний менежмент, үр өгөөж ямар түвшинд байна вэ?				
Сум/дүүрэгт энэ төрлийн үйл ажиллагаа үе үе явагддаг ч түүний агуулга, менежмент, үр өгөөжийг үнэлж сайн мэдэхгүй.	Сум/дүүрэгт энэ төрлийн үйл ажиллагаа үе үе явагддаг ба уг арга хэмжээ нь сонирхолтой, хэрэгцээтэй агуулгатай байдаг.	Сургууль энэ төрлийн үйл ажиллагааг эцэг эх, олон нийттэй хамтарч, чухал агуулга, сонирхолтой хэлбэрээр тогтмол зохион байгуулж, тэдний хандлагад нөлөөлдөг.	Хүмүүсийн ажил, амьдралын тодорхой хэрэгцээнд нийцсэн, сонирхолтой арга хэмжээ үе үе явагдаж, тэдний мэдлэг, хандлагад зарим өөрчлөлтүүд гарч эхэлсэн.	Хүмүүсийн ажил, амьдралын олон талт хэрэгцээнд нийцсэн, системтэй үйл ажиллагаа тогтмолжиж, тэдний мэдлэг, хандлага, зан үйлд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.4.1. Танай сургуульд эгэх хариуцлагын соёлыг хөгжүүлэх үйл явц нь таны болон хамт олны тогтвортой байдлын түлхүүр 8 цогц чадамж (тогтолцоон сэтгэлгээ; урьдчилан тооцоолох; хэм хэмжээг мөрдөх; стратеги боловсруулах хэрэгжүүлэх; хамтран ажиллах; шүүмжлэлт сэтгэлгээ; өөрийгөө таньж мэдэх; асуудал шийдвэрлэх)-ын эзэмшилт, төлөвшлийн түвшнээс хэр зэрэг хамаарч байна вэ?				
Хамааралтай эсэхийг хэлж мэдэхгүй. Учир нь хүмүүс эдгээр асуудлаар нэгдсэн ойлголтгүй, өөр өөрийн төсөөлөлтэй байна.	Хамааралтай гэж таамаглаж байна. Гэвч эдгээр асуудлыг дөнгөж судалж эхэлсэн, тэдгээртэй танилцаж байна.	Хамааралтай гэж боддог болсон. Учир нь эгэх хариуцлагын тодорхой үйл гүйцэдгэхдээ эдгээр цогц чадамжыг хэрэглэж, эзэмшиж байна.	Хамааралтай гэж итгэх хариуцлагад эдгээр цогц чадамжуудыг хэрэглэдэг болсноор хүмүүс өөрчлөгдөж үүрэг хариуцлагын гүйцэдгэл эрс сайжирсан.	Нийт хамт олон хамааралтай гэсэн итгэл үнэмшилтэй болсон. Учир нь эгэх хариуцлага ба тогтвортой байдлын цогц чадамжууд нь байгууллагад шинэ соёл авчирч чадсан.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.4.2. Эрх эзэмшигч эрхээ эдлэх, үүрэг хүлээгч үүргээ биелүүлэх харилцааг зохицуулах механизмыг дэмждэг, хүний эрхэд суурилсан арга хандлагыг хэрэгжүүлэхэд тусалдаг "Сайн хөтөлбөр"-ийн талаарх Таны мэдлэг чадвар аль түвшинд байна вэ?				
"Сайн хөтөлбөр"-ийн талаар тодорхой мэдэхгүй байна.	"Сайн хөтөлбөр"-ийн талаар судалж эхлэсэн буюу түүнтэй танилцаж байна.	"Сайн хөтөлбөр"-ийн талаар нарийвчлан судалж, сургуулийн "Сайн хөтөлбөр"-тэй болсон	Сургуулийнхаа "Сайн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байна.	Сургуулийнхаа "Сайн хөтөлбөр"-ийн явцын болон үе шатны гүйцэдгэлийг үнэлдэг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.4.3. Жендэрийн тэгш байдлыг хангаж буй эсэхийг хэмжих индикаторууд бүхий хэсэгчилсэн болон иж бүрэн жендэрийн анализын арга хэрэгсэл, мөн сонирхогч болон түншлэгч талуудыг оролцуулсан эргэх холбооны механизмыг тус тус бүтээж, жендэрийн асуудлыг сургуулийн өөрийн үнэлгээний гол шалгуурын нэг болгон нотолгоонд суурилсан, ил тод шийдвэр гаргах соёлын төлөвшил аль түвшинд байна вэ?				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань сургуулийн түвшинд нэлээд ерөнхий, эмх цэгц муутай, хамтрагч ба түншүүд ойлголтын зөрөө их байна.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буй эсэхийг хэмжих үнэлгээний төрлүүд, тус бүрийнх нь шалгуур, индикаторууд, арга аргачлалыг боловсруулж байна	Жендэрийн тэгш байдлыг хангах талаар хамтрагч, түншлэгч нартаа сурталчилж, жендэрт суурилсан эргэх холбооны механизмыг бий болгож байна.	Жендэрийн мэдлэг, мэдрэмжтэй, жендэрийн тэгш оролцоотой байх шаардлага үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна.	Жендэрийн тэгш байдалд суурилсан эгэх хариуцлагын тогтолцоо бүрэлдэж байна.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.4.4. Дэлхийн иргэний боловсролын хүрээнд сургуульд боловсролын үйлчилгээ эрхлэгчид ба тэдний үйлчлүүлэгч нар, мөн хяналтын ажилтнуудын үйл ажиллагааны уулзварт бусад сонирхогч, хувь нийлүүлэгч бүх талуудыг татан оролцуулах систем, механизмыг бий болгох, тэдний санал хүсэлтийг авч ашиглах эргэх холбоо тогтоох, түүнчлэн шаардлагатай платформуудыг ашиглах чадавх, бэлэн байдал ямар түвшинд бүрдсэн бэ?				
Үйлчилгээ эрхлэгчид, үйлчилгээ хүртэгчид, хяналтын албаныхан (үндсэн оролцогчид)-тай харилцаж, зохих эрх зүйн зохицуулалтын хүрээнд тэдний санал хүсэлтийг авч ашиглах түвшинд	Үндсэн оролцогчдоос гадна бусад сонирхогч ба хувь нийлүүлэгч талуудыг татан оролцуулах механизм, платформуудыг ашиглах түвшинд	Бүх талуудтай эргэх холбоо тогтоож, үйл ажиллагаагаа зохицуулах бэлэн байдал хангагдах түвшинд	Бүх талуудтай тогтоосон эргэх холбоогоо ашиглан тэднээс суралцах, өөрийгөө зохицуулах, өөрчлөх түвшинд	Эгэх хариуцлагын хүрээнд гаргах шийдвэр нь хууль ёсны, ил тод байх, хариу үйлдэл үзүүлэх чадавх дээшилсэн, эрх ашгийн нөлөөлөл буурсан байх түвшинд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.4.5. Танай сургуульд эгэх хариуцлагын тогтолцоог хэр бүрэн гүйцэт тодорхой, ойлгомжтой түвшинд бүрдүүлж, ажиллуулдаг вэ?				
Эгэх хариуцлагын ажиллагаа сайтай тогтолцоо бүрэлдээгүй.	Эгэх хариуцлагын тогтолцоог тодорхой, ойлгомжтой байдлаар боловсруулж баталгаажуулсан ч түүнийг бүрэн мөрдөж ажилладаггүй	Энэ тогтолцоон дахь шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчид ба сонирхогч талуудын санал, хүсэлтийг тусгах механизмын ажиллагаа доголдолтой.	Энэ тогтолцоон дахь шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчид ба сонирхогч талуудын санал, хүсэлтийг тусгах механизмын ажиллагаа сайн..	Эгэх хариуцлагын биелэлтийг тооцож ажиллах соёл төлөвшиж байгаа..
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.4.6. Танай сургуулийн хамт олны гишүүн бүр өөрийн дуу хоолойгоо илэрхийлэх, үр өгөөжтэй шийдвэрлүүлэх тогтолцоо механизм хэр зэрэг үр өгөөжтэй ажилладаг вэ?				
Хамт олны гишүүд дуу хоолойгоо сургуулийн удирдлагад хүргэж санал хүсэлтээ илэрхийлдэг, тэдгээрийг оновчтой зөв шийдвэрлүүлдэг эгэх хариуцлагын инклюдив тогтолцоо, механизм бүрэн бүрдээгүй байна.	Хамт олон санал хүсэлтээ илэрхийлж, үр дүн шаардахад зориулагдсан тусгай журам боловсруулж, энэ үйл ажиллагаанд мөрдөх зөв хэм хэмжээг тогтоох чиглэлд сургуулийн удирдлагууд санаачилгатай, үр нөлөөтэй ажилладаг.	Хамт олны гишүүдээс дуу хоолойгоо хүргэж буй зан үйл, өнгө аяс, түүнд бусад хүмүүсийн татагдан оролцох байдал зэргийг судалж, хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг.	Хамт олны гишүүн бүр дуу хоолойгоо илэрхийлж, санал хүсэлт санаачилга гаргахад нь шаардлагатай нөөц боломжоор хангаж, тэднийг сонсож, хүлээн зөвшөөрч, урамшуулж, харилцан ойлголцож, уян хатан ажилладаг.	Сургуулийн удирдлага хамт олны дуу хоолойг хүлээн авах, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлдэг тасралтгүй “суралцагч байгууллагын” эгэх хариуцлагын дэвшилтэт соёл төлөвшиж байна.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.4.7. Та болон танай байгууллагын удирдлагууд эгэх хариуцлагын хүрээнд хариу үйлдэл үзүүлэх чадвараа нэмэгдүүлэх, гаргасан шийдвэр нь ил тод, хууль ёсны байлгахад ямар шалгуур тавьж, хэрхэн ажилладаг вэ?				
Тухайн асуудлыг судлан хэлэлцэж, шийдвэрлэх шаардлагатай асуудал мөн болохыг хүлээн зөвшөөрч, гаргах шийдвэрийнхээ зорилгыг тодорхойлдог.	Асуудлын шийдлийг дэнслэн үнэлэх, сонголт хийхэд шаардлагатай шалгуур, индикаторыг боловсруулж, холбогдох мэдээлэл цуглуулдаг.	Шийдвэрийн хувилбаруудыг хууль эрх зүйн зөрчилгүй байхаар боловсруулж, тэдгээрээс улбаалан үүсэж болох үр дагаварыг урьдчилан тооцдог.	Шийдвэрийн хувилбаруудыг ил тод хэлэлцэж, шударга, бусдыг хүндэлсэн, амжилтаа хэмжих, урамшуулах боломжтой, эргэлзэхгүйгээр шууд үйлдэж болох, сэтгэл хөдлөлд хөтлөгдөөгүй байх зэрэг "сайн шийдвэр"-ийн үнэт зүйлсийн шалгуурыг дааж чадахуйц эцсийн шийдвэр гаргахыг эрмэлздэг.	Эцсийн шийдвэрээ үнэлж, түүний үйлчлэл оновчтой сайн байна гэдэгт итгэлтэй болох, шаардлагатай бол залруулж, сайжруулдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.4.8. Та болон танай сургуулийн удирдлагууд эгэх хариуцлагын хүрээнд бусад байгууллага, нийгмийн бүлгүүдтэй холбоо тогтоон тэдний саналыг авч, өөрийн байгууллагын хөгжлийн хэрэгцээгээ хэр зэрэг ханган ажилладаг вэ?				
Хамтын ажиллагаанд ямар хүндрэл, эрсдэл тохиолдох, ямар үр өгөөж, ашиг тустай байх хүчин зүйлсийг судалж, боломжит түншүүдийн мэдээллийн санг төрөлжүүлэн бүрдүүлдэг, жагсаалт гаргаж, эхний шатны түүвэр хийдэг.	Эгэх хариуцлагын циклийн хүрээнд хамтын ажиллагааны зорилго, үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэлд тавигдах шаардлагууд зэргийг агуулсан ажлын даалгавар, гэрээний төсөл боловсруулж баталдаг.	Түншлэгчдийн мэдээллийн сангаас эхний шатны түүвэр хийж, хамтран ажиллах санал, танилцуулгыг түүвэрт хамрагдсан хувь нийлүүлэгчдэд хүргүүлж, шаардлагатай бол уулзалт хийж, тэдний санал зөвлөмж, болзлыг сонсдог.	Сургуулийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, сургуулийн үнэт зүйлсийн хүндэтгэсэн, үр өгөөжтэй хамтран ажиллах түншлэгчээ сонгон шалгаруулж, шийдвэр гарган хариу мэдэгддэг.	Сонгогдсон түнштэйгээ холбогдох гэрээ, хэлцэл байгуулж, хамтын ажиллагааны явцад талуудын хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлтэд хяналт тавьж, зохицуулан ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хнх.4.9. Танай сургууль ТХ-ийн төлөөх загвар сургууль болж хувиран өөрчлөгдөхөд шаардлагатай стратегиудийг хэрэгжүүлэхийн тулд эгэх хариуцлагын хүрээнд тасралтгүй суралцан хөгжиж, өөрсдийгөө зохицуулан өөрчлөгдөж байгааг үнэлдэг тогтолцоо, арга механизм нь аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуулийн үйлчилгээнд соёл ба зан үйл хоорондын хамаарлыг үл тоомсорлож, соёл, уламжлалын олон янз байдалд бүрэн нийцээгүй, хөгжүүлэлт хийгдээгүй үйлчилгээний тогтолцоо, арга барилыг үйлчлүүлэгчдэд тулгасан (Жишээ нь малчдын хүүхдийн сургалт)-аар, эрэлт, нийлүүлэлтэд зай завсар үүсэж, соёлд сорилт үүсэн буй нь ажиглагддаг. Иймд сургуулийн өөрийн үнэлгээний хяналтын хуудас, бойжилтын загвар, PDCA цикл зэрэг арга хэрэгслийг судалж байна.	Сургуулийн үйлчилгээнд далд нуугддаг шударга бус байдал, үйлчлүүлэгчдэд учрах дарамт зэрэг нь тэдний хэрэгцээнд нийцсэн, уян хатан, үл алагчилсан үйлчилгээ бүрэн үзүүлж чадахгүй байх, голдуу үйлчлүүлэгчийн идэвхтэй оролцоог хязгаарлах, эсвэл соёлын ялгаанд нийцсэн боловсролын үйлчилгээг багасгахад хүргэж, үл алагчлах стратегийг хэрэгжүүлэх чадавх илт дутагдаж байна.	Соёлын ялгаатай бүлэг бүрийн хүмүүс ижил соёл ба дадал хэвшилтэй байдаг гэсэн соёлын харалган төсөөлөл нь түгээмэл байгаа учраас сургууль нь үүсэл гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн давхарга зэргийн ялгаанаас үл хамааран бүх үйлчлүүлэгчдэд боловсролын "сайн" үйлчилгээг хүргэх, ялгаварлан гадуурхахын эсрэг сурталчилгаа явуулах, холбогдох бодлого, хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй гэж боддог.	Сургуулийн үйлчилгээнд нийгэм соёлын хүчин зүйлс хүчтэй нөлөөллийг ухаарч, тэдгээрийг цаашид зайлшгүй тооцох нь зүйтэйг мэддэг болсноор соёлын ялгаатай хүн амд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр судалгаа эхлүүлэх, зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах, захиргааны ба мэргэжлийн байгууллагууд, зөвлөх багуудас дэмжлэг туслалцаа авах замаар нийгэм-соёл, зан үйлийн хүрээний цогц чадамжуудаа нэмэгдүүлж эхэлсэн.	Үйлчилгээндээ үл алагчлах стратегийг нэвтрүүлэхийн ач холбогдлыг ойлгож, өөрсдийн цогц чадамжуудаа хөгжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч, энэ чиглэлээр сургуулийн өөрийн үнэлгээ хийх, стратеги төлөвлөгөө боловсруулахдаа оролцооны ил тод зарчмыг баримталж, хамт олон тасралтгүй суралцахдаа хүчин чармайлт гаргадаг, соёлын өвөрмөц онцлогт тохирсон үйлчилгээндээ байнгын үнэлгээ ба сайжруулалт хийдэг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хнх.4.10. Танай сургууль хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоондоо оролцогч талуудын хамтын ажиллагаанд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлийг шийдвэрлэх, эрх ашгийн нөлөөллийг бууруулах шалгуур, индикаторуудын хэрэглээ аль түвшинд байна вэ?				
Хувийн сонирхол буюу эрх ашиг гэж юу болох, тэдгээрт ямар хүчин зүйлс нөлөөлдөг, түүнийг хэрхэн бууруулдаг, үнэлэхдээ ямар индикаторууд хэрэглэдэг талаар сайн мэдэхгүй байна.	Түншлэгчдийн сонирхлын зөрчилд нөлөөлдөг хүчин зүйлс нь юу (ашиг орлогын ногдол, хувь хүмүүсийн хандлагын өвөрмөц шинжүүд, үр дүнгийн гинжин хамаарал, үйлдэл хийх үр чадвар) болохыг судалж байна	Эрх ашгийн сонирхолд харгалзан үзэх гол шалгуур болох хувь хүний хандлагын объект ба түүний төрөл (үнэт зүйлийн, сэтгэгдэлийн, гаралтын үр дүнгийн)-үүд болохыг судалж, тэдгээрийг эрх ашгийн нөлөөллийг бууруулах индикаторууд болгон хэрэглэх бэлтгэлээ хангаж байна.	Хамтрагч талуудын хоорондох үүсэж болох бодит, эсвэл болзошгүй зөрчил болон талууд өөрсдийн байгууллагууддаа үнэнч байх үүрэг хүлээсэн тохиолдолд үүсэх ашиг сонирхлын зөрчлийг талуудын хооронд байгуулах гэрээгээр, шаардлагатай бол гэрээнд өөрчлөлт оруулж шийдвэрлэдэг.	Хамтрагч талуудын эрх ашгийг зохих ёсоор тэнцвэржүүлж, зохицуулаагүй, байгууллага ба нийгмийн хооронд үүссэн ашиг, сонирхлын зөрчил гаргахгүй байхад анхаарч, гарсан тохиолдолд хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.2.3. ЕБС-ийн БАГШ: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хбс.1.1. Сургуулийн сургалтын болон хичээлийн хөтөлбөрт ТХБ-ыг интеграцчилах арга, хандлага (ТХБ-ын цогц чадамж төлөвшүүлэх нэгж, ТХ/ТХБ-той холбогдох сэдэв, ТХ/ТХБ-ын асуудал нь сурагчийн шийдэх асуудал байх г.м.)-ын талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
.....-ын талаар нэгдсэн ойлголт бүрдээгүй, багш бүр өөрийнхөөрөө л хөтөлбөртөө ТХБ-ыг тусгадаг-тай танилцаж, нэгдсэн ойлголт авч байна-ыг хэрэгжүүлэхэд сургуулиараа хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлдэг-ыг бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.1.2. Сургуулийн сургалтын болон хичээлийн хөтөлбөр*-ийг төлөвлөх хэрэгжүүлэхэд хүний эрхэд суурилсан байх зарчим (нэг талаас сурагчийн эрхийг хүндэтгэсэн сургалт, үнэлгээгээр багш бүр, нөгөө талаас хүний эрхийг хангахын төлөөх сургуулийн үйл ажиллагаа, соёлоор хүний эрхийн боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэх)-ыг биелүүлдэг үү?				
*-Үндэсний хөтөлбөрийн дагуу нийгмийн ухаан, эрх зүйн боловсролын зэрэг зохих хичээлээр хүний эрхийн тухай заахаас гадна				
.....-ыг биелүүлэх талаар нэгдсэн ойлголтгүй-ыг хэрхэн биелүүлэх талаар танилцаж байна-ыг хэрхэн биелүүлэхэд хийнгээ суралцаж байна-ыг биелүүлдэг-ыг бүрэн биелүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.1.3. Сургуулийн хэмжээнд сургалтын болон хичээлийн хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
..... нэгдсэн ойлголтгүй, багш бүр өөрийнхөөрөө нэгдсэн ойлголттой болох эхлэл тавигдсан ч олон төрлийн хичээлүүдийн хувьд нийтлэг болон ялгаатай талаар тодорхойлоогүй нэгдсэн ойлголттой, хичээл бүрт төлөвлөх, хэрэгжүүлэх онцлогийг тодорхой болгоход хийнгээ суралцаж байгаа нэгдсэн ойлголттой, хичээл бүрийн хувьд төлөвлөж хэрэгжүүлдэг нэгдсэн ойлголттой, хичээл бүрийн хувьд бүрэн төлөвлөж хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.1.4. Дэлхийн иргэний боловсрол (ардчилсан байдлаар үйлдэх, нийгмийн хариуцлагатай үйлдэх, бүтээлчээр сэтгэх, бусадтай үр дүнтэй, бүтээлчээр харилцах)-ыг эзэмшүүлэх сургуулийн нэгдсэн бодлого, зарчим хэрэгжүүлдэг үү?				
.....-гүй, багш бүр өөрийнхөөрөө-тай танилцаж байна-ыг хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлдэг-ыг бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.1.5. Сургуулийн болон хичээлийн хөтөлбөрт ТХ/ТХБ-той холбоотой мэдлэгийг сурагч өөрийн идэвхтэй үйл ажиллагаагаар эзэмшихүйц төлөвлөлт хийж, хэрэгжүүлдэг үү?				
..... хийж, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт байхгүй, багш бүр өөрийнхөөрөө хийж, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголттой танилцаж байна хийж, хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна хийж, хэрэгжүүлдэг хийж, бүрэн дүүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.2.3. ЕБС–ийн БАГШ: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хбс.1.6. Хөтөлбөрт ТХЗ-ын төлөөх оролцооны шинэлэг арга (бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх, шинжилгээ судалгаа хийх, бодит хамтын үйл ажиллагаанд оролцох, алсын хараатай болох)-уудыг оновчтой сонгож бүрэн хэрэгжүүлдэг үү?				
.....уудыг оновчтой сонгож хэрэгжүүлэх нэгдсэн ойлголт бүрдээгүй, багш бүр өөрийнхөөрөө сургалтын аргаа сонгодогуудыг бүтээлчээр сонгож хэрэгжүүлэх талаарх танилцаж байнауудыг бүтээлчээр сонгож хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байнауудыг бүтээлчээр сонгож хэрэгжүүлдэгуудыг бүтээлчээр сонгож бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.1.7. Инклюзив (хүйс, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, танин мэдэхүйн, бие бялдар, сэтгэл зүйн нөхцөлөөс үл хамааран) бодож сэтгэх, үйлдэх болон эв нэгдэлтэй байх, хариуцлага хүлээх чадвар, хандлага төлөвших хэмжээнд сургуулийн соёл бүрдсэн үү?				
..... бүрдэх талаар нэгдсэн ойлголтгүй бүрдүүлэх талаар танилцаж байна бүрдүүлэхэд хийнгээ суралцаж байна бүрдүүлсэн бүрэн бүрдсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.1.8. ТХБ нь тусгаар хичээл биш, түүнчлэн аль нэг хичээл дээрх нэмэлт хэсэг ч биш, харин сургуулийн болон хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөний «цөм» болж интеграцчилдаг байх зарчим-ыг хэрэгжүүлдэг үү?				
.....-ын талаар нэгдсэн ойлголтгүй, багш бүр өөрийн хэмжээнд интеграцчилдаг-ын талаар судалж байна-ын талаар хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлдэг-ыг бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.1.9. Харилцан хамааралд нь авч үзэх зарчим (ТХ-ийн үндсэн тулгуур (хүрээлэл орчин, нийгэм, эдийн засаг)-ыг хамарч, орон нутгийн онцлогийг тооцох, соёлын олон янз байдал, түүх, соёлын хам нөхцөлийн ялгааг хүндэтгэх ТХБ-ын зарчим)-ыг хангасан сургуулийн хөтөлбөр-ийг төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
.....-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар судалж байна-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна-ийг төлөвлөж, хэрэгжүүлдэг-ийг мэргэшсэн түвшинд төлөвлөж, хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.1.10. Насан туршийн суралцахуйн чадвар, хандлага (өөрийн удирдлагатай суралцах, өөрийн танин мэдэхүйн онцлогоо мэдэх, дотоод сэдлээ удирдах г.м.) төлөвшүүлэхэд чиглэсэн нэгдсэн сургуулийн хөтөлбөр-ийг төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
.....-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх талаар судалж байна-ийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна-ийг төлөвлөж, хэрэгжүүлдэг-ийг мэргэшсэн түвшинд төлөвлөж, хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. БАГШЛАХУЙ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
б.хбс.2.1. ТХБ (Байгаль, нийгэмтэй харилцахдаа, өөртөө хандахдаа хамгийн зохистой шийдлийг хийх мэдлэг, чадвар, хандлага)-ыг дэмжсэн багшлахуй үйл ажиллагаа-г хэрэгжүүлдэг үү?				
.....-ны талаар харилцан адилгүй мэдлэгтэй-тай танилцаж байна-нд хийнгээ суралцаж байна-г хэрэгжүүлдэг-г бүрэн хэрэгжүүлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
б.хбс.2.2. Багш өөрийн хичээлийн бүхий л үйл ажиллагаандаа «хүний эрхэд суурилсан боловсрол»-ын зарчмын өмнө хүлээсэн үүрэг (Боловсролд хамрагдах эрхийг хангах үүрэг, Чанартай боловсролд хамрагдах эрхийг хэрэгжүүлэх үүрэг, Суралцахуйн орчинд хүүхдийн эрхийг хүндлэх үүрэг)-ээ биелүүлдэг үү?				
Эдгээр хуулийг сурталчилах, дагаж мөрдөх байдалд зорилготой ахиц дэвшил ажиглагдахгүй байна	Хуулийн талаар мэдлэг түгээдэг боловч бодит байдалд өөрчлөлт бага байна	Ашиг сонирхлын болон авилгын талаар ямар нэгэн зөрчил маргаан гардаггүй	Энэ талаар системтэй сургалт, төлөвшлийн арга хэмжээнүүдийг авдаг, нийтийн хяналт сайжирсан, удирдлагын баг болон хамт олон даган мөрдөх байдал хэвшсэн	Энэ талаар бүх түвшинд ямар нэгэн зөрчил гардаггүй, цаашид ч энэ байдал тогтвортой байх бүхий л нөхцөл, чадавх бүрдсэн
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.3.2. ЕБС–ийн АЖИЛЧИД: ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫН ХӨГЖИЛ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, АЖИЛЛАГААНЫ ТАВИЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.1.1. Танай сургуулийн хөгжлийн бодлого, практик үйл ажиллагаа болон бүтцийн нэгжүүд хоорондын зохицуулах механизмууд нь хүний нөөцөө чадавхжуулахад хэр зэрэг нийцсэн байдаг вэ?				
... зориулагдсан нийтлэг дүрэм журмыг мөрддөг.	... зориулагдсан боломжуудыг шинээр хайн судалж байна.	... зориулагдсан хөгжлийн тасралтгүй хэрэгцээг хангаж чадахуйц уян хатан, нээлттэй оновчтой бүтэц, механизмыг бий болгож чадсан.	... зориулагдсан бүтэц, механизмууд үр өгөөжтэй ажиллаж эхэлсэн.	... зориулагдсан бүтэц, механизмууд нийцтэй, үр өгөөжтэй, үр ашгтай, тогтвортой ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.1.2. Танай сургуулийн орчинд суралцагч үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргахад оролцох, өөрийн итгэл үнэмшилтэй байх, нэр төрөө эрхэмлэх, бие махбод, оюун ухаан, сэтгэл санааны аливаа хүчирхийлэл, доромжлол, бэртэл гэмтэлд өртөхөөс хамгаалуулах эрхээ эдлэх боломжийг олгосон бодлого, эрх зүй, ёс зүйн харилцааг зохицуулсан дүрэм журмууд ямар түвшинд үйлчилж байна вэ?				
... нийтлэг дүрэм, журмыг мөрддөг. Тэдгээрийн үйлчилгээ нь хүүхдийн эрхийг цогцоор нь бүрэн дүүрэн эдлүүлдэг гэдэгт эргэлздэг.	... -ыг хүүхдийн эрхийн бүрэлдэхүүн хэсэг бүрийг нарийвчлах, сургууль дээр тэдний эрхийг эдлүүлэх, хамгаалахад тохиолдож буй сорилт, асуудлуудын шалтгааныг илрүүлэх судалгааг эхлүүлсэн.	Судалгаа хийнгээ суралцаж, судалгааны үр дүнд тулгуурлан ... -ыг сайжруулах үндэслэл, арга замыг тодруулж, холбогдох бодлого, дүрэм, журмаа "Хүний эрхэд суурилсан арга хандлага"-ын дагуу шинэчилсэн.	"Хүний эрхэд-суурилсан арга хандлага"-д суурилсан бодлого, эрх зүй, ёс зүйн шинэ механизмуудыг хэрэгжүүлж эхэлсэнээр энэ арга хандлага нь зардал хэмнэдэг, асуудлыг цогцоор нь шийдвэрлэдэг, шударга ёсыг дэмждэг ач холбогдолтойг хамт олноороо мэдэрч, эхэлсэн.	Нэг талаас, багш, суралцагч, бусад оролцогчдын эрхээ эдлэх, эдлэхийг шаардах нөгөө талаас, үүрэг гүйцэдгэгч үүргээ гүйцэдгэх чадавх нь нэмэгдэхийн хэрээр эрхээ хэрэгжүүлэх эрх мэдэлтэй болж, хүний эрхийг хүндэлдэг нийгэмд шилжих үндэс суурийг тавигдаж байна.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.1.3. Жөндөрийн тэгш бус байдалд нөлөөлдөг нийгэм, соёлын ялгаанаас үүдэлтэй эрэлтийн болон сургуулийн бүхий л үйл ажиллагаанд шингэсэн байдаг нийлүүлэлтийн хүчин зүйлсийн хамаарлыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн стандарт, дүрэм журмуудын үйлчлэл аль түвшинд байна вэ?				
Эрэлт ба нийлүүлэлтийн хүчин зүйлсэд юу ордгийг гүйцэд, сайн мэдэхгүй тул тэдгээрийн тэнцвэржилтийг цогцоор нь хангасан зохицуулалт учир дутагдалтай байна.	Эрэлт ба нийлүүлэлтийн хүчин зүйлсийг тус тусад нь үнэлж, дүгнэх судалгааг хийж байна.	Энэ асуудлыг харилцан хамааралд авч үзэн судалж, дүгнэлт зөвлөмж гарган, бодлого, төлөвлөгөөний төслүүд боловсруулсан.	Боловсруулсан төслүүдээ өргөн хүрээнд хэлэлцүүлж батлаад хэрэгжилтийг зохион байгуулж эхэлсэн.	Баталсан бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг тохируулах үнэлгээ (assessment) ба дүгнэх үнэлгээ (evaluation)-ний арга хэрэгслүүд боловсруулан хэрэглэж байна.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.1.4. Танай сургуулийн хөгжлийн бодлого, практик үйл ажиллагаанд дэлхийн иргэний боловсролын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлс, ёс суртахууны кодуудыг интеграцчилахад шаардагдах хүний нөөцийн чадавх аль түвшинд байна вэ?				
Энэ чадавх сайн бүрдээгүй байна. Учир нь хүмүүсийн ойлголт, мэдлэг тодорхой бус, эмх цэгц муутай, харилцан адилгүй байна.	Ийм чадавхыг хөгжүүлэх сургалтын болон бусад дэмжлэгийн хэрэгцээг судлах хүрээнд асуудалтай танилцаж байна.	Хүний нөөцийн чадавхаа хөгжүүлэх чиглэлээр зорилтот бүлгүүдэд зориулсан төлөвлөгөө, хөтөлбөрүүд боловсруулж, олон арга хэлбэрийн сургалтууд зохион байгуулж байна	Хүний нөөцийн ялангуяа, багшийн чадавхын хөгжилд ахиц гарч, сургалын болон бусад үйл ажиллагаанд дэлхийн иргэний боловсрол интерацчилагдаж байна.	Дэлхийн иргэний боловсролын хүрээнд олсон амжилт, туршлагаа сум, аймаг, үндэсний түвшинд сурталчилж, туршлага хуваалцдаг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.3.2. ЕБС–ийн АЖИЛЧИД: ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫН ХӨГЖИЛ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, АЖИЛЛАГААНЫ ТАВИЛ

Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.1.5. Та сургуулийнхаа хөгжлийн алсын харааг тодорхойлох болон түүнд дөхөх үйл хэрэгт хэр зэрэг оролцдог вэ?				
"... алсын хараа"-ны талаар тодорхой ойлголтгүй байна.	... алсын харааг тодорхойлоход оролцоогүй	... алсын харааг тодорхойлоход оролцсон.	... алсын хараанд дөхөх үйл хэрэгт ухамсартайгаар хувь нэмрээ оруулдаг	... алсын хараагаа илүү тодорхой болгох шаардлагатай гэж үздэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.1.6. Танай сургууль хүний нөөцийн чадавхаа дайчлан илрүүлж бүрэн ашигладаг уу?				
... чадавхын талаар тодорхой сайн ойлголтгүй байна.	... чадавхаа дайчлан илрүүлдэггүй, бүрэн ашигладаггүй	... чадавхаа дайчлан илрүүлдэггүй, илэрсэнээ бүрэн ашигладаг	... чадавхаа дайчлан илрүүлдэг ч бүрэн ашигладаггүй	... чадавхаа дайчлан илрүүлдэг, бүрэн ашигладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.1.7. Бусад сургууль ба олон нийтийн сүлжээнд хамтран ажиллах танай сургуулийн хүний нөөцийн болон технологийн чадавх аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Хүний нөөцийн чадавх нь зөвхөн сургууль, эцэг эх, олон нийтийн хүрээнд, сум/дүүргийн түвшний сүлжээнд	Хүний нөөц болон технологийн чадавх нь зөвхөн сургууль, эцэг эх, олон нийтийн хүрээнд, сум/дүүргийн түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиуд, олон нийтийн хүрээнд, аймаг/нийслэлийн түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиудын хүрээнд, үндэсний түвшний сүлжээнд	Аль ч чадавх нь сургуулиудын хүрээнд, олон улсын түвшний сүлжээнд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.1.8. Танай сургуулийн хүний нөөцийн чадавх нь сургуулийнхаа 1) хэмжээ (хүүхдийн тоо) 2) бүтэц (5,9,12 жилийн), 3) байршил (баг, сум, аймаг/нийслэлийн төвд буюу хот, хөдөөд), 4) үйлчлүүлэгчдийн тусгай хэрэгцээ (малчдын хүүхэд-дотуур байр, гадаад хэл дээрх сургалт г.м.), 5) хэв шинж (гүнзгийрүүлсэн, төрөлжсөн олон улсын хамтарсан г.м.)-ийн онцлогтой хэр зэрэг нийцдэг вэ?				
Зөвхөн 1 онцлогт нийцсэн.	Эдгээрээс 2 онцлогт нийцсэн.	Эдгээрээс 3 онцлогт нийцсэн.	Эдгээрээс 4 онцлогт нийцсэн.	5 онцлогт нийцсэн.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.1.9. Танай сургуулийн албан тушаалтан бүрийн албан тушаалын тодорхойлолтод тэдний үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа, тэдгээрийн гүйцэтгэлд тавигдах шаардлагууд эрэмбэлэгдэн уялдсан байдаг уу? Тэдгээрийг уялдуулах арга механизм бий юу?				
... нь хоорондоо хэр зэрэг эрэмбэлэгдэн уялдсан байдгийг сайн мэдэхгүй	Миний ажлын байр ба бусад ажлын байрны ... нь хоорондоо хангалттай түвшинд эрэмбэлэгдэж уялдаагүй	Миний ажлын байр ба бусад ажлын байрны ... нь хоорондоо хангалттай түвшинд эрэмбэлэгдэн уялдсан	Албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлэх нийтлэг болон тусгай арга механизмууд байдаг ч сайн үйлчилдэггүй	Албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлэх нийтлэг болон тусгай арга механизмууд сайн үйлчилдэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.1.10. Танай сургууль хүний нөөцийн чадавхаа хөгжүүлэхэд бусад сонирхогч талууд болон түншлэгчдийг татан оролцуулж, ямар түвшинд хамтран ажилладаг вэ?				
... шаардлагатай хэрэгцээ ба хөрөнгө, хүчийг үнэлж тодорхойлдог.	... шаардлагатай гэж үзвэл сонирхогч болон түншлэгч талуудыг татан оролцуулдаг	... зориулсан тусгай төлөвлөгөө, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.	Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх төрөл бүрийн хариу арга хэмжээ авдаг.	Хүний нөөцийн чадавхын хөгжлийг тогтмол үнэлж, цаашдын хэрэгцээ, зорилтоо тодорхойлдог.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.2.1. Та ТХЗ-ууд ялангуяа, ТХЗ 4-ыг хангахад бусдад нөлөөлж, урам зориг өгч, зорилгодоо хүрэх, улмаар тэднийг өөрийнхөө зорилгын хязгаараас давж урагшлахад нь сэдэл тэмүүлэлтэй болгоход нь ямар түвшинд илүү нөлөөлдөг вэ?				
...би хийж үглгэрлэдэг, тэд анхааралтай ажигладаг, бид ярилцдаг.	... би хийж үглгэрлэдэг, тэд тусалдаг, бид ярилцдаг.	... тэд хийдэг, би тусалдаг, бид ярилцдаг.	... тэд хийдэг, би анхааралтай ажигладаг, бид ярилцдаг.	... тэд хийдэг, тэднийг хэн нэгэн анхааралтай ажигладаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.2.2. Боловсролын үйлчилгээ үзүүлэх хамран тойргийнхоо хүүхэд, залуучууд, иргэдэд чанартай боловсрол эзэмшүүлэх тэгш боломж (equality) олгох, үл алагчилал (equity)-ыг хэрэгжүүлэх, ялгаварлан гадуурхал (discrimination)-аас сэргийлэх, хүн бүрийн тусгай хэрэгцээг багтаасан (inclusive) байх, тогтолцооны гадна хэнийг ч үлдээхгүй (exclusion) байх зэрэг хүний эрхийн чухал стратегийг хэрэгжүүлэхэд таны манлайлал аль түвшинд байна вэ?				
Эдгээр стратегийг, тэдгээрийн хоорондох ялгаа, харилцан хамаарлыг сайн ялгаж ойлгодоггүй. Би өөрийгөө манлайлагчийн аль хэв маягт илүү хамаарагдахаа мэддэг.	Би өөрийгөө эдгээр стратегийг хэрэгжүүлэхэд хамт олноо манлайлж, орон нутагтаа эергээр нөлөөлөх боломжтой удирдагчдын нэг гэж үздэг	Эдгээр стратегийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх менежментийг манлайлахад миний ур чадварт ямар ямар сул тал, зааг завсар (gap) байгаа талаар би байнга эрэгцүүлж боддог.	Эдгээр стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай манлайллын ур чадвараа хөгжүүлэх талаар залгамж чанартай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг	Хүний эрхийн салбар дахь карьерийн зорилгоо тодорхойлж, манлайллын ур чадвараа хэрэгжүүлэхэд болон ирээдүйн удирдагчид зориулсан замын зураглал боловсруулдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.2.3. Жендэрийн тэгш байдал (gender equality)-ыг хангах чиглэлээр сектор дамнансан арга хандлагад суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мөн сургуульдаа Жендэрийн мэдлэг (gender aware) ба мэдрэмжтэй (gender sensitive), жендэрийн харалган (Gender blind) бус шинжтэй сургалт, үйл ажиллагааг төлөвшүүлэхэд Таны өөрөө үлгэрлэн манлайлах чадвар аль түвшинд байна вэ?				
Эдгээр ойлголтыг, ухагдахуун, тэдгээрийн хоорондох ялгаа, харилцан хамаарлыг сайн ялгаж ойлгодоггүй. Би өөрийгөө манлайлагчийн аль хэв маягт илүү хамаарагдахаа мэддэг.	Би өөрийгөө эдгээр ойлголтыг ухагдахууны сүлжээнд нь танин мэдэж, хамт олноо манлайлж, орон нутагтаа эергээр нөлөөлөх боломжтой удирдагчдын нэг гэж үздэг	Эдгээр ойлголтыг үйл ажиллагаандаа тусгах, менежментийг манлайлахад шаардлагатай миний ур чадварт ямар сул талууд, зааг завсар (gap) байгаа талаар би байнга эрэгцүүлж боддог.	Эдгээр ойлголтыг амжилттай интеграцчилахад шаардлагатай манлайллын ур чадвараа хөгжүүлэх талаар залгамж чанартай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг	Жендэрийн тэгш байдлын талбар дахь өөрийн карьерийн зорилгоо тодорхойлж, манлайллын ур чадвараа хэрэгжүүлэхэд болон ирээдүйн удирдагчид зориулсан замын зураглал боловсруулдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.2.4. Танай сургууль дэлхийн иргэний боловсролын танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн, зан үйлийн түвшинд харгалзах мэдлэг чадварын ач холбогдол хийгээд "Дэлхийн түвшинд сэтгэж, нутгийн түвшинд үйлдэх" гэсэн стратегийг орон нутгийнхаа иргэдэд таниулан сурталчлах, тэднийг манлайлах үйл ажиллагаа аль түвшинд явагдаж байна вэ?				
... сурталчлах, тэднийг манлайлах ажиллагаа манай сургууль дээр эхлээгүй байна.	... сурталчлах, тэдэнд нөлөөлөх арга замыг судалж, төлөвлөгөө боловсруулсан.	Орон нутгийн иргэд, олон нийтийг сургуулийн жижиг төсөлд татан оролцуулах замаар тэдний арга хандлагад нөлөөлж байна.	Орон нутгийнхаа иргэдэд дэлхийн иргэний боловсролын хэрэгцээ, агуулга, ач холбогдлыг сурталчилж, тэдний боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг болсон.	Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, олон нийт дэлхийн иргэний боловсролын хүрээнд санаачилга гаргаж, хөрөнгө босголцож, сургуультай олон арга хэлбэрээр хамтран ажилладаг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.2.5. Та сургуульдаа, салбартаа юуны төлөө боловсролын хувирган өөрчлөлт хийх хэрэгтэй байгааг ямар түвшинд урьдчилан харж байна вэ?				
Хувирган өөрчлөлт, өөрчлөлт шинэчлэл, өөрчлөлт зэрэг ойлголт, тэдгээрийн хэрэгцээ ба зорилгын ялгаатай талуудыг тодорхой мэдэхгүй.	Дэлхий нийтийн, үндэсний, сургуулийн түвшинд юуны төлөө боловсролын хувирган өөрчлөлтийг хийх хэрэгтэй болсон мөн энэ хүрээнд юу хийхээр төлөвлөж, баталсныг ерөнхийд нь төсөөлнө.	Дэлхий нийтийн, үндэсний, сургуулийн түвшинд боловсролын хувирган өөрчлөлтийн хүрээнд юу хийхээр төлөвлөж баталсныг тодорхой сайн мэднэ.	Сургуулийнхаа менежментийг хувирган өөрчлөхийн тулд юуг шинээр хийх шаардлагатайг ерөнхийдөө мэднэ.	Сургуулийнхаа менежментийг хувирган өөрчлөх хүрээнд юуг шинээр хийх шаардлагатайг сайн мэднэ.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.2.6. Та сургуулийнхаа болон салбарынхаа зорилгын төлөө бусдад нөлөөлж, урам зориг өгч, бусдыг сэдэл тэмүүлэлтэй болгоход ямар түвшинд хувь нэмэр оруулдаг вэ?				
Ур чадвар, тууштай байдал, хамтрагчдаа хүндэлдэг, зөв зам мөртэй, хариуцлагатай, сайн зан чанартай зэрэг байхыг хичээдэг.	Зорьсондоо хүрэх итгэл үнэмшилтэй, "хийж чадна" гэсэн зорилгыг хандлагатай, хүмүүсийнхээ урам зоригийг бадраадаг, тэдэнд тусалдаг, өөдрөг сэтгэл, урам зоригтой ажилладаг.	Хүмүүсийг сонсдог, тэдний хэрэгцээ, сайн сайхан байдал нь санаа тавьдаг, манлайлын чадавхыг хөгжүүлдэг, тэдэнтэй шинийг "хамтран бүтээх"-ын төлөө ажилладаг.	Хамтрагчдаа мэхэлдэггүй, шинийг санаачилж, шинийг хийх үед нь тулгарсан сорилттой нь хамт тэднийг орхидоггүй, харин хамтдаа алдаан дээрээ суралцаж, гайхалтай үр дүнд хүрэхийг уриалдаг.	Өөртөө итгэлтэй, өөрийгөө сурталчлах чадвартай ч даруу байхыг хичээдэг. Алдаа гаргавал түүнийгээ хүлээн зөвшөөрч, гол нь бусдыг нухацтай сонсож, тэдний санал хүсэлтийг авч алдаанаасаа суралцах ёстой гэж үздэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.2.7. Та тодорхой нэг зорилгын төлөө сонгосон байгууллага, хүмүүстэй мэдээлэл солилцож, харилцаа холбоотой байхын тулд тухайн сүлжээнд хэрхэн ажилладаг вэ?				
Сүлжээ үүсгэнэ гэдэг нь хүмүүстэй уулзаж, харилцах үйл явц учраас харилцаандаа хүндэтгэлтэй, ёс зүйтэй, мэргэжлийн байхыг эрмэлздэг.	Тухайн хүн болон байгууллагын нэр, чиг үүрэг, ажил мэргэжлийн талаарх товч мэдээлэл олж, сүлжээнд ажиллах зорилгоо урьдчилан тодорхойлдог.	Мэдээлэл болон яриагаа товч, тодорхой бэлтгэж, мэдээлэл солилцоходоо аль болох бусдын цагийг шаардлагагүй зүйлд үрэхгүйг хичээдэг.	Танд цаг, зав гаргаж, үнэтэй мэдээлэл солилцсоны төлөө харилцагч нартаа талархал илэрхийлэхийг чухалчилдаг.	Сүлжээндээ идэвхтэй ажиллаж, тогтоосон холбоо харилцаагаа хадгалж байхыг хичээдэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.2.8. Танай сургуулийн хувирган өөрчлөгдөх үйл явц дахь эрсдэл (гамшгийн, үйл ажиллагааны, санхүүгийн, стратегийн гэсэн төрөлтэй)-ийн менежмент дэх Таны манлайлал аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуульд тохиолдож болох эрсдэлийн төрлүүдийг мэргэжлийн экспертүүд, хамт олонтойгоо хамтран байнга эрэмбэлж, болзошгүй эрсдлийг тодорхойлж байдаг.	Эрсдэл гарах магадлал болон эрсдэлийн нөлөөллийн зэргийг түүний давтамж, ноцтой байдлаар тооцож, хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө зардлын зураглал хийдэг	Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, эрсдэлийг хянаж урьдчилан сэргийлэх, шилжүүлэх зэрэг байж болох бусад шийдлийг үнэлдэг.	Боломжит бүх шийдлээс сонгон шийдвэр гаргаж, шаардлагатай нөөцүүдийг бэлтгэн, худалдан авалт хийж, уг шийдвэрээ дэс дараатай, тууштай хэрэгжүүлэн албан ёсны үйл ажиллагаа болгон хувиргадаг.	Албажсан үйл ажиллагаагаа дэмжиж, эрсдэлийн соёлыг хөгжүүлснээр байгууллага аливаа өөрчлөлтийн өмнө илүү уян хатан, дасан зохицох чадвартай болдог
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 2. МАНЛАЙЛАЛ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.2.9. Танай сургуулийн хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх (ХНЧХ) менежментийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний оновчтой, шат дараалсан, тууштай, үр өгөөжтэй, тогтвортой байдал аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Шинэ стратеги боловсруулахын өмнө сургуулиа дотоод, гадаад орчинд нь сайтар судлаж, зорилго, бүтэц, албан тушаалын чиг үүргүүд, ажиллах хүч, түүний чадавх зэргийг үнэлж, хамт олныхоо урам зориг, тэдэнд учирч буй сорилт, бэрхшээлийг олж мэддэг.	Судалгааны үр дүндээ тулгуурлан хүний нөөцийн хөгжлийн бүхий л чиглэлийг хамарсан шинэ стратеги боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх бүх оролцогчдод танилцуулж ойлгуулдаг.	Шинэ стратеги хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхын, санхүүгийн, ложистик нөөцийг шинжилж, одоо байгаа болон шинээр шаардагдах нөөцийг харьцуулан зөрөөг тооцож, нөөц хомсдолтой байгаа бол санхүүжилт татах арга замыг судалж, санхүүжилт босгодог.	Хүрэлцээтэй нөөцтэй, төгс стратегитэй байгаад ч тодорхой арга хэмжээ авч, үйл хийхгүй бол тэдгээр нь үнэ цэнтэй эрдэм чадал болон хувирч чаддаггүй тул хэрэгжилтэд онцгой ач холбогдол өгч, үйл явцыг дуустал нь үргэлжлүүлдэг.	Стратеги хэрэгжүүлэх үйл явцыг дагаж хянах замаар гарч буй ахиц дэвшил, төлөвлөлтөөс эерж хазайсан өөрчлөлтүүдийг тус тус илрүүлж, тэдгээрийн шалтгааныг олж тогтоон цаг тухайд нь тохиргоо хийж залруулж ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.2.10. Үйл ажиллагаандаа дотроосоо болон гаднаас мэргэжлийн экспертүүдийг татан оролцуулах, тэднийг тогтоон барих сургуулийн тогтолцоо ба механизмын бүрдүүлэлт мөн жендэрийн зөрөөтэй байдлын индекс-ЖЗБИ (gender parity) аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуулийн дэвшүүлсэн зорилго, зорилтыг хангах, тулгамдаж буй сорилт, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай байгаа чиглэлээр эксперт ажиллуулах хэрэгцээг тодруулдаг. Сургуульдаа ЖЗБИ-ийг 0.97-оос 1.03-т дөхүүлэх бодлого баримталдаг.	Эксперт урихдаа хувь хүнийг тодорхойлдог гол хүчин зүйлс болох төрөлхийн авьяас чадвар, боловсрол, мэргэшил, туршлага, нийгэм дэх идэвхтэй сүлжээ буюу салбартаа тогтоосон харилцаа зэргийг судалж, экспертүүдийн нөөцийн жагсаалт гаргадаг.	Эксперттэй үр өгөөжтэй хамтран ажиллахын тулд сургуулийн нөөц ба чадавх, бүтэц, тогтолцоо ба үйл явцууд, манлайлал, дотоод сүлжээ, сургалт, багууд зэрэг хүчин зүйлсийн онцлогоо тооцож, зохих бэлтгэлийг хангадаг.	Сургуулийнхаа тогтвортой хөгжлийг хангахын тулд хамт олон дундаасаа экспертүүдийг өсгөн бойжуулах бодлогын хүрээнд ухаалаг, гүйцэдгэл сайтай, хүмүүсийг ажилд авч, тэднийг хөгжүүлэх, хадгалах, гадагш нь алдахгүй ажиллуулах стратеги баримталдаг.	Сургуульдаа аль болох олон тооны өөрийн экспертүүд бойжуулж, тэднийг тасралтгүй хөгжүүлэх, тууштай ажиллуулах, тогтоон барих, дэвшсэн ч эргэх холбоотой ажиллах зорилттой ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.3.1. Тогтвортой хөгжил (ТХ), ногоон хөгжил (НХ), тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ), тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол (ТХЗБ)-ын талаарх мэдлэг, ТХБ-ын болон тогтвортой байдлын цогц чадамжуудын төлөвшил аль үе шатанд илүү харгалзаж байна вэ?				
.. -тай холбоотой түлхүүр үг, нэр томьёо, тэдгээрийн хоорондох харилцан хамаарлыг өөрт байгаа арга хэрэгслийг ашиглан хайх замаар эхлээд хөгжүүлэхийг хүсэж буй мэдлэг, чадвараа тодорхойлдог.	... -тай холбоотой ухагдахуун, тэдгээрийн хоорондох холбоосуудыг үүсгэн ухагдахууны сүлжээ зурж, өөрийн үгээр товч тэмдэглэл хийх замаар тэдгээрийг хэрэглэхэд бэлтгэж, цаашид өөрөө болон бусадтай хамтран баяжуулан, гүнзгийрүүлж суралцдаг.	... -тай холбоотой зарим сэдвүүд, харилцан хамаарлуудыг ойлгохгүй, хэрэглэж чадахгүй байгаа “гох дэгээ”-г олж тайлахын тулд мөн өөр өнцгөөс хандахын тулд дахин дахин уншиж, бичиж, эргэцүүлж, агуулгыг эзэмшдэг	... тай холбоотой хэвлэмэл, аудио, видео, болон цахим эх сурвалжуудыг ашиглан тухайн сэдэв, үзэл баримтлалтай холбоотой танин мэдэхүйнхээ хамрах хүрээг аажмаар өргөжүүлдэг.	... -тай холбоотой мэдлэгийн гүнзгийрэл, ур чадварын өсөлтөө байнга өөрөө шалгаж үнэлж, хөгжүүлж байдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.3.2. Хүний эрхэд суурилсан арга хандлага, түүний зарчмууд болон боловсролд хамрагдах, чанартай боловсрол эзэмших, сургуулийн орчинд хүндлүүлэх суралцагчийн эрх, мөн эдгээр эрхийг эдлүүлэх үүрэг хүлээсэн гүйцэтгэгчдийн үүргийн талаарх мэдлэг, чадвар, тэдгээрийн хэрэглээ, үр дүн аль шатанд илүү харгалзаж байна вэ?				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, эмх цэгц муутай байна.	Эдгээр асуудлыг судалж эхлэх буюу тэдгээртэй танилцаж байна.	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүрэгтэй холбоотой мэдлэгээ гүнзгийрүүлж, тодорхой үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлж байна.	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүрэгтэй холбоотой мэдлэг, туршлагаа үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна.	Эдгээр арга хандлага, зарчим, чиг үүргүүд сургуулийн үйл ажиллагаанд бүрэн нэвтэрч, эерэг үр нөлөөгөө өгдөг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.3.3. Жендэрийн дүн шинжилгээ хийх (Gender analyses), жендэрийн асуудлыг харгалзсан төлөвлөлт хийх (Gender-responsive planning), жендэрийн асуудлыг харгалзсан төсөв боловсруулах, батлуулах (Gender responsive budgeting), жендэрийн асуудлыг харгалзсан арга хэмжээ авах (Gender responsive) мэдлэг, ур чадвар, тэдгээрийн хэрэглээ аль шатанд илүү харгалзаж байна вэ?				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, эмх цэгц муутай байна.	Эдгээр асуудлыг судалж эхлэх буюу тэдгээртэй танилцаж байна.	Эдгээр суудалтай холбоотой мэдлэгээ гүнзгийрүүлж, тодорхой үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлж байна.	Эдгээр ур чадвартай холбоотой мэдлэг, туршлагаа үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна.	Эдгээр ур чадваруудаа ашиглан сургуулийн үнэлгээ, судалгаа, төлөвлөлт, төсөвлөлтөд жендэрийн асуудлууд харилцан уялдаатайгаар бүрэн тусаж, эерэг үр нөлөөгөө өгдөг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.3.4. Дэлхийн иргэний боловсрол нь “Суралцахуйд эрхэмлэх үнэт эрдэм” сэдэвт Делорсын илтгэл (1996), Бага, дунд боловсролын стандарт, киррикулимыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлалын суралцахуйн 4 тулгуур багана (2002), ТХЗ 4.7 ба насан туршийн болон амьдралын олон талт агуулга (lifelong, life-wide) бүхий боловсрол (2015)-той тус тус хэрхэн холбоотойгоор хөгжиж ирсэн замналын талаар танай хамт олны мэдлэг, чадвар аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
... талаарх ойлголт, мэдлэг маань нэлээд ерөнхий, уялдаа холбоогүй, эмх цэгц муутай байна.	... талаарх ойлголт, мэдлэгээ цэгцлэх болон асуудлуудын хоорондох холбоо хамаарлыг тогтоох чиглэлээр судалгаа хийж байна.	... хүрээнд асуудлуудын хоорондох холбоо хамаарлыг илрүүлснээр хүний эрх, жендэрийн тэгш байдал, тогтвортой хөгжлийн сургуулийн түвшний бодлого, стратегиүдтэй холбох арга замыг эрэлхийлж байна.	Дурдагдсан стратегиүдийг сургуулийн менежмент, үйл ажиллагаанд цогцоор нь интеграцчилах төлөвлөгөө боловсруулсан	Боловсруулсан төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлсэн ба энэ интеграцчилалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга хэрэгсэл боловсруулан туршиж эхэлсэн.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ

Бойжилтын түвшин

1	2	3	4	5
а.хнх.3.5. Дэлхий нийтийн болон үндэсний түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн замнал болон хувирган өөрчлөлтийн алсын хараа, зорилго, зорилтын талаарх Таны мэдлэг аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Монгол Улсын ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар ерөнхийд нь мэддэг.	Монгол Улсын ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын тодорхой сайн мэддэг.	Дэлхий нийтийн түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар ерөнхийд нь мэддэг.	Дэлхий нийтийн түвшин дэх ТХ/ТХБ-ын төлөөх боловсролын хөгжлийн түүхэн замнал, түүний шат бүр дэх алсын хараа, зорилго зорилтын талаар тодорхой сайн мэддэг.	Дэлхий нийтийн болон үндэсний түвшинд боловсролыг хувирган өөрчлөх 2030 он хүртлэх алсын хараа, зорилго, зорилтууд, тэдгээрийн бие биедээ эрэмбэлэгдсэн байдлын тодорхой сайн мэддэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.3.6. Суралцахуй ба эзэмшихүйн зүй тогтол, багшлахуйн конструктив арга хандлагын талаарх Таны мэдлэг, чадвар аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Тодорхой нэг судлагдахууны дидактикт суурилсан багшлах түвшинд	Хэд хэдэн судлагдахууны интеграцчилах дидактикт суурилсан багшлах түвшинд	Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх түвшинд	Дидактикийн онол, арга зүйгээр зөвлөн туслах түвшинд	Дидактикийн онол, арга зүйгээр магадлан шинжлэх түвшинд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.3.7. Та өөрийн мэргэжил, эрхэлж буй албан тушаалд тавигдах мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд аль түвшин (үйл ажиллагаа (operational)-ны, хувь хүн (personal)-ний, стратеги (strategic)-ийн сүлжээг хэр зэрэг ашигладаг вэ?				
Өөрийн мэргэжил, эрхэлж буй албан тушаалын гүйцэтгэлд тавигдах мэдлэгээ гүнзгийрүүлж, чадвараа хөгжүүлэхэд сүлжээний олон түвшин, төрлийг хэрхэн ашиглахаа тодорхой сайн мэдэхгүй байна.	Ажлыг үр өгөөжтэй явуулах, гүйцэдгэлийн чадавхыг тэтгэх зориулалттай үйл ажиллагааны түвшний сүлжээнд ажилладаг. Энэ түвшний сүлжээ нь голдуу удирдлагаас өгөгдөх үүрэг даалгавартай холбоотой тул хувь хүний хэрэгцээг хангахдаа хязгаарлагдмал байдаг.	Хувь хүний хөгжлийн асуудлуудаа шийдвэрлэхдээ сонирхол нэгтэй мэргэжлийн болон төгсөгчдийн холбоо, клубт элсэн сургуулиас гадуурх танилын хүрээгээ тэлж, мэдээлэл солилцох, дадлагажих суралцах замаар хувь хүний хөгжлийг дэмждэг сүлжээнд ажилладаг.	Хувийн сүлжээний тусламжтайгаар өөрийгөө болон илүү өргөн хүрээтэй орчныг танин мэдэж, мэргэжлийн нийгэмлэгт олсон харилцаагаа сургуулийнхаа зорилгод нийцүүлэн ашигладаг манлайлагч болж хөгжихийн тулд хувийн сүлжээгээ өргөжүүлэн ажилладаг.	Техникийн чадавхаа хөгжүүлэхдээ үндэсний болон дэлхий нийтийн түвшинд сэтгэж, сургууль, орон нутгийнхаа түвшинд үйлдэн боловсролын хувирган өөрчлөлтийг хөшүүрэгдэхэд хувь нэмрээ оруулахын тулд стратегийн түвшний сүлжээнд ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 3. МЭДЛЭГ				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.3.8. Хувь хүн мэргэжлийн болон бусад хүрээний чадавхаа хөгжүүлэх эрэлт хэрэгцээгээ хангахад өнөөгийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны үйлчлэл буюу энэ чиглэлээр сургууль, орон нутаг, үндэсний түвшнөөс үзүүлж буй дэмжлэг туслалцаа аль төлөв байдалд илүү харгалзаж байна вэ?				
МД тогтолцоон дахь албан сургалтуудын агуулга, арга зүй нь сургалтын хөтөлбөрийн хөгжлийн тухайн үеийн онцлог хэрэгцээнд төвлөрдөг, багш, ажилтан бүрийг хамруулдаг, хүлээн зөвшөөрөгдөн гэрчилгээждэг, улс ба орон нутгийн төсвөөр санхүүжигдэж тогтворжсон давуу талуудтай. Энэ төрлийн сургалт давтамж холтой, хугацаа богинотой, агуулга ихтэй байдгаас хувь хүнд ачаалалтай, бэрхшээлтэй, тулгасан шинжтэй байдаг сул талтай.	Үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшинд захиргааны ба мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулагддаг, тэдний боловсруулсан агуулга, арга зүй бүхий МД төрөлжсөн сургалтуудаас сонгон суралцах боломжт олгодог ч санхүүжилт ба цаг хугацааны нөөц хомс, хувь хүнийхээ хөгжлийн төлөө хийсэн чармайлтаа хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулах боломж хязгаарагдмал байдаг.	Аль ч түвшний байгууллагаас зохион байгуулж буй сургалт, үйл ажиллагааны зорилго, хэрэгцээ, цаг хугацаа нь дээд түвшний удирдлагаас хүчтэй хамааралтай өөрөөр хэлбэл, хүний нөөцийн чадавхын хөгжилд чиглэсэн үйлчилгээ нь хувь хүмүүсийн бодит хэрэгцээ, боломжинд бус үйлчилгээ үзүүлэгч талын нийлүүлэлтэд давамгайлж байгаа тул суралцагч бүрийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, боломжид бүрэн нийцэхийг зорьдог.	Сургуулиас бусадтай харилцаж, нийгэм-соёл, зан үйлийн хүрээний хандлага, дадлага, туршлагаа хөгжүүлэх боломж олгодог интерактив сургалтууд мөн хувь хүний үнэт зүйл, сонирхол, хандлага, ажил мэргэжлийн хүлээлт, суралцах хэв маяг, хөгжлийн боломж зэргээ шинжин бие даасан шийдвэр гаргаж, өөрийгөө хөгжүүлэх боломж олгодог арга зам (цахим мэтийн)-уудыг хөгжүүлж, оновчтой, хослуулан ашиглахад анхаарч ажилладаг.	Ирээдүйн хэрэгцээнд баримжаалсан тасралтгүй өсөн нэмэгдэж буй хэрэгцээ нь гүйцэдгэж буй ажил үүргийнхээ хүлээлтийг нарийвчлан тодруулах, гүйцэдгэлийн сайжруулалтыг чухалчилах, ажил үүргийн ерөнхий ба эрхэм ховор чадварууд мөн янз бүрийн хам нөхцөлд зөөгдөн хэрэглэгдэх бусад ерөнхий цогц чадамж эзэмших үйл явцыг дэмждэг насан туршийн сурацахуйн зарчим, арга хэлбэрийг хөгжүүлэх стратеги барьдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.3.9. Насан туршын суралцахуйн стратегийн хүрээнд ТХ-ын төлөөх загвар сургуульд шаардагдах мэргэжлийн тасралтгүй хөгжлөө хангахарТа аль түвшинд ажиллаж байна вэ?				
Юу мэдэж, чаддаг болсон, юу мэдэж, чадаж байгаа, юуг илүү мэдэж чадахыг хүсэж байгаагаа эрэгцүүлж бодож өөрийгөө таниж мэддэг.	Хүссэн мэдлэг, чадвараа хэрхэн эзэмших арга замаа тодорхойлж, хүрэх үр дүн, ахиц дэвшлээ хянах алхмуудаа төлөвлөдөг.	Төлөвлөгөөний дагуу ажиллаж, суралцах үйлээ нээлттэй байлгаж, өдөр тутмын суралцахуйн үр өгөөжөө дээд хэмжээнд байлгахын тулд туршлагажих үйлийнхээ талаар тогтмол эрэгцүүлэн боддог.	Онолоо практикт хувиргах, сурсан зүйлээ ажилдаа нэвтрүүлэх, мэдлэгээ гүнзгийрүүлэх, хамт олны дэмжлэгээс ашиг тус хүртэхийн тулд өөрийн мэдлэгээ олон нийттэй хуваалцдаг	Хийж буй ажилд суралцахуй маань ямар үр нөлөө үзүүлж байгааг хэмжиж үнэлдэг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.3.10. ТХ/ТХБ-ын талаар танай сургуулийн багш, ажилтан, эцэг эх болон иргэд, олон нийтэд хүргэж буй мэдлэг, мэдээллийн агуулга, энэ төрлийн боловсролын үйлчилгээний менежмент, үр өгөөж ямар түвшинд байна вэ?				
Сум/дүүрэгт энэ төрлийн үйл ажиллагаа үе үе явагддаг ч түүний агуулга, менежмент, үр өгөөжийг үнэлж сайн мэдэхгүй.	Сум/дүүрэгт энэ төрлийн үйл ажиллагаа үе үе явагддаг ба уг арга хэмжээ нь сонирхолтой, хэрэгцээтэй агуулгатай байдаг.	Сургууль энэ төрлийн үйл ажиллагааг эцэг эх, олон нийттэй хамтарч, чухал агуулга, сонирхолтой хэлбэрээр тогтмол зохион байгуулж, тэдний хандлагад нөлөөлдөг.	Хүмүүсийн ажил, амьдралын тодорхой хэрэгцээнд нийцсэн, сонирхолтой арга хэмжээ үе үе явагдаж, тэдний мэдлэг, хандлагад зарим өөрчлөлтүүд гарч эхэлсэн.	Хүмүүсийн ажил, амьдралын олон талт хэрэгцээнд нийцсэн, системтэй үйл ажиллагаа тогтмолжиж, тэдний мэдлэг, хандлага, зан үйлд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.4.1. Танай сургуульд эгэх хариуцлагын соёлыг хөгжүүлэх үйл явц нь таны болон хамт олны тогтвортой байдлын түлхүүр 8 цогц чадамж (тогтолцоон сэтгэлгээ; урьдчилан тооцоолох; хэм хэмжээг мөрдөх; стратеги боловсруулах хэрэгжүүлэх; хамтран ажиллах; шүүмжлэлт сэтгэлгээ; өөрийгөө таньж мэдэх; асуудал шийдвэрлэх)-ын эзэмшилт, төлөвшлийн түвшнээс хэр зэрэг хамаарч байна вэ?				
Хамааралтай эсэхийг хэлж мэдэхгүй. Учир нь хүмүүс эдгээр асуудлаар нэгдсэн ойлголтгүй, өөр өөрийн төсөөлөлтэй байна.	Хамааралтай гэж таамаглаж байна. Гэвч эдгээр асуудлыг дөнгөж судалж эхэлсэн, тэдгээртэй танилцаж байна.	Хамааралтай гэж боддог болсон. Учир нь эгэх хариуцлагын тодорхой үйл гүйцэдгэхдээ эдгээр цогц чадамжыг хэрэглэж, эзэмшиж байна.	Хамааралтай гэж итгэх хариуцлагад эдгээр цогц чадамжуудыг хэрэглэдэг болсноор хүмүүс өөрчлөгдөж үүрэг хариуцлагын гүйцэдгэл эрс сайжирсан.	Нийт хамт олон хамааралтай гэсэн итгэл үнэмшилтэй болсон. Учир нь эгэх хариуцлага ба тогтвортой байдлын цогц чадамжууд нь байгууллагад шинэ соёл авчирч чадсан.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.4.2. Эрх эзэмшигч эрхээ эдлэх, үүрэг хүлээгч үүргээ биелүүлэх харилцааг зохицуулах механизмыг дэмждэг, хүний эрхэд суурилсан арга хандлагыг хэрэгжүүлэхэд тусалдаг "Сайн хөтөлбөр"-ийн талаарх Таны мэдлэг чадвар аль түвшинд байна вэ?				
"Сайн хөтөлбөр"-ийн талаар тодорхой мэдэхгүй байна.	"Сайн хөтөлбөр"-ийн талаар судалж эхлэсэн буюу түүнтэй танилцаж байна.	"Сайн хөтөлбөр"-ийн талаар нарийвчлан судалж, сургуулийн "Сайн хөтөлбөр"-тэй болсон	Сургуулийнхаа "Сайн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байна.	Сургуулийнхаа "Сайн хөтөлбөр"-ийн явцын болон үе шатны гүйцэдгэлийг үнэлдэг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.4.3. Жендэрийн тэгш байдлыг хангаж буй эсэхийг хэмжих индикаторууд бүхий хэсэгчилсэн болон иж бүрэн жендэрийн анализын арга хэрэгсэл, мөн сонирхогч болон түншлэгч талуудыг оролцуулсан эргэх холбооны механизмыг тус тус бүтээж, жендэрийн асуудлыг сургуулийн өөрийн үнэлгээний гол шалгуурын нэг болгон нотолгоонд суурилсан, ил тод шийдвэр гаргах соёлын төлөвшил аль түвшинд байна вэ?				
Эдгээр асуудлын талаарх ойлголт, мэдлэг маань сургуулийн түвшинд нэлээд ерөнхий, эмх цэгц муутай, хамтрагч ба түншүүд ойлголтын зөрөө их байна.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буй эсэхийг хэмжих үнэлгээний төрлүүд, тус бүрийнх нь шалгуур, индикаторууд, арга аргачлалыг боловсруулж байна	Жендэрийн тэгш байдлыг хангах талаар хамтрагч, түншлэгч нартаа сурталчилж, жендэрт суурилсан эргэх холбооны механизмыг бий болгож байна.	Жендэрийн мэдлэг, мэдрэмжтэй, жендэрийн тэгш оролцоотой байх шаардлага үйл ажиллагааныхаа бүх талбарт хэрэгжүүлж байна.	Жендэрийн тэгш байдалд суурилсан эгэх хариуцлагын тогтолцоо бүрэлдэж байна.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.4.4. Дэлхийн иргэний боловсролын хүрээнд сургуульд боловсролын үйлчилгээ эрхлэгчид ба тэдний үйлчлүүлэгч нар, мөн хяналтын ажилтнуудын үйл ажиллагааны уулзварт бусад сонирхогч, хувь нийлүүлэгч бүх талуудыг татан оролцуулах систем, механизмыг бий болгох, тэдний санал хүсэлтийг авч ашиглах эргэх холбоо тогтоох, түүнчлэн шаардлагатай платформуудыг ашиглах чадавх, бэлэн байдал ямар түвшинд бүрдсэн бэ?				
Үйлчилгээ эрхлэгчид, үйлчилгээ хүртэгчид, хяналтын албаныхан (үндсэн оролцогчид)-тай харилцаж, зохих эрх зүйн зохицуулалтын хүрээнд тэдний санал хүсэлтийг авч ашиглах түвшинд	Үндсэн оролцогчдоос гадна бусад сонирхогч ба хувь нийлүүлэгч талуудыг татан оролцуулах механизм, платформуудыг ашиглах түвшинд	Бүх талуудтай эргэх холбоо тогтоож, үйл ажиллагаагаа зохицуулах бэлэн байдал хангагдах түвшинд	Бүх талуудтай тогтоосон эргэх холбоогоо ашиглан тэднээс суралцах, өөрийгөө зохицуулах, өөрчлөх түвшинд	Эгэх хариуцлагын хүрээнд гаргах шийдвэр нь хууль ёсны, ил тод байх, хариу үйлдэл үзүүлэх чадавх дээшилсэн, эрх ашгийн нөлөөлөл буурсан байх түвшинд
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.4.5. Танай сургуульд эгэх хариуцлагын тогтолцоог хэр бүрэн гүйцэт тодорхой, ойлгомжтой түвшинд бүрдүүлж, ажиллуулдаг вэ?				
Эгэх хариуцлагын ажиллагаа сайтай тогтолцоо бүрэлдээгүй.	Эгэх хариуцлагын тогтолцоог тодорхой, ойлгомжтой байдлаар боловсруулж баталгаажуулсан ч түүнийг бүрэн мөрдөж ажилладаггүй	Энэ тогтолцоон дахь шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчид ба сонирхогч талуудын санал, хүсэлтийг тусгах механизмын ажиллагаа доголдолтой.	Энэ тогтолцоон дахь шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчид ба сонирхогч талуудын санал, хүсэлтийг тусгах механизмын ажиллагаа сайн..	Эгэх хариуцлагын биелэлтийг тооцож ажиллах соёл төлөвшиж байгаа..
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.4.6. Танай сургуулийн хамт олны гишүүн бүр өөрийн дуу хоолойгоо илэрхийлэх, үр өгөөжтэй шийдвэрлүүлэх тогтолцоо механизм хэр зэрэг үр өгөөжтэй ажилладаг вэ?				
Хамт олны гишүүд дуу хоолойгоо сургуулийн удирдлагад хүргэж санал хүсэлтээ илэрхийлдэг, тэдгээрийг оновчтой зөв шийдвэрлүүлдэг эгэх хариуцлагын инклюзив тогтолцоо, механизм бүрэн бүрдээгүй байна.	Хамт олон санал хүсэлтээ илэрхийлж, үр дүн шаардахад зориулагдсан тусгай журам боловсруулж, энэ үйл ажиллагаанд мөрдөх зөв хэм хэмжээг тогтоох чиглэлд сургуулийн удирдлагууд санаачилгатай, үр нөлөөтэй ажилладаг.	Хамт олны гишүүдээс дуу хоолойгоо хүргэж буй зан үйл, өнгө аяс, түүнд бусад хүмүүсийн татагдан оролцох байдал зэргийг судалж, хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг.	Хамт олны гишүүн бүр дуу хоолойгоо илэрхийлж, санал хүсэлт санаачилга гаргахад нь шаардлагатай нөөц боломжоор хангаж, тэднийг сонсож, хүлээн зөвшөөрч, урамшуулж, харилцан ойлголцож, уян хатан ажилладаг.	Сургуулийн удирдлага хамт олны дуу хоолойг хүлээн авах, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлдэг тасралтгүй “суралцагч байгууллагын” эгэх хариуцлагын дэвшилтэт соёл төлөвшиж байна.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.4.7. Та болон танай байгууллагын удирдлагууд эгэх хариуцлагын хүрээнд хариу үйлдэл үзүүлэх чадвараа нэмэгдүүлэх, гаргасан шийдвэр нь ил тод, хууль ёсны байлгахад ямар шалгуур тавьж, хэрхэн ажилладаг вэ?				
Тухайн асуудлыг судлан хэлэлцэж, шийдвэрлэх шаардлагатай асуудал мөн болохыг хүлээн зөвшөөрч, гаргах шийдвэрийнхээ зорилгыг тодорхойлдог.	Асуудлын шийдлийг дэнслэн үнэлэх, сонголт хийхэд шаардлагатай шалгуур, индикаторыг боловсруулж, холбогдох мэдээлэл цуглуулдаг.	Шийдвэрийн хувилбаруудыг хууль эрх зүйн зөрчилгүй байхаар боловсруулж, тэдгээрээс улбаалан үүсэж болох үр дагаварыг урьдчилан тооцдог.	Шийдвэрийн хувилбаруудыг ил тод хэлэлцэж, шударга, бусдыг хүндэлсэн, амжилтаа хэмжих, урамшуулах боломжтой, эргэлзэхгүйгээр шууд үйлдэж болох, сэтгэл хөдлөлд хөтлөгдөөгүй байх зэрэг "сайн шийдвэр"-ийн үнэт зүйлсийн шалгуурыг дааж чадахуйц эцсийн шийдвэр гаргахыг эрмэлздэг.	Эцсийн шийдвэрээ үнэлж, түүний үйлчлэл оновчтой сайн байна гэдэгт итгэлтэй болох, шаардлагатай бол залруулж, сайжруулдаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.4.8. Та болон танай сургуулийн удирдлагууд эгэх хариуцлагын хүрээнд бусад байгууллага, нийгмийн бүлгүүдтэй холбоо тогтоон тэдний саналыг авч, өөрийн байгууллагын хөгжлийн хэрэгцээгээ хэр зэрэг ханган ажилладаг вэ?				
Хамтын ажилагаанд ямар хүндрэл, эрсдэл тохиолдох, ямар үр өгөөж, ашиг тустай байх хүчин зүйлсийг судалж, боломжит түншүүдийн мэдээллийн санг төрөлжүүлэн бүрдүүлдэг, жагсаалт гаргаж, эхний шатны түүвэр хийдэг.	Эгэх хариуцлагын циклийн хүрээнд хамтын ажиллагааны зорилго, үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэлд тавигдах шаардлагууд зэргийг агуулсан ажлын даалгавар, гэрээний төсөл боловсруулж баталдаг.	Түншлэгчдийн мэдээллийн сангаас эхний шатны түүвэр хийж, хамтран ажиллах санал, танилцуулгыг түүвэрт хамрагдсан хувь нийлүүлэгчдэд хүргүүлж, шаардлагатай бол уулзалт хийж, тэдний санал зөвлөмж, болзлыг сонсдог.	Сургуулийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, сургуулийн үнэт зүйлсийн хүндэтгэсэн, үр өгөөжтэй хамтран ажиллах түншлэгчээ сонгон шалгаруулж, шийдвэр гарган хариу мэдэгддэг.	Сонгогдсон түнштэйгээ холбогдох гэрээ, хэлцэл байгуулж, хамтын ажиллагааны явцад талуудын хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлтэд хяналт тавьж, зохицуулан ажилладаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. ЭГЭХ ХАРИУЦЛАГА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хнх.4.9. Танай сургууль ТХ-ийн төлөөх загвар сургууль болж хувиран өөрчлөгдөхөд шаардлагатай стратегиудыг хэрэгжүүлэхийн тулд эгэх хариуцлагын хүрээнд тасралтгүй суралцан хөгжиж, өөрсдийгөө зохицуулан өөрчлөгдөж байгааг үнэлдэг тогтолцоо, арга механизм нь аль түвшинд илүү харгалзаж байна вэ?				
Сургуулийн үйлчилгээнд соёл ба зан үйл хоорондын хамаарлыг үл тоомсорлож, соёл, уламжлалын олон янз байдалд бүрэн нийцээгүй, хөгжүүлэлт хийгдээгүй үйлчилгээний тогтолцоо, арга барилыг үйлчлүүлэгчдэд тулгасан (Жишээ нь малчдын хүүхдийн сургалт)-аар, эрэлт, нийлүүлэлтэд зай завсар үүсэж, соёлд сорилт үүсэн буй нь ажиглагддаг. Иймд сургуулийн өөрийн үнэлгээний хяналтын хуудас, бойжилтын загвар, PDCA цикл зэрэг арга хэрэгслийг судалж байна.	Сургуулийн үйлчилгээнд далд нуугддаг шударга бус байдал, үйлчлүүлэгчдэд учрах дарамт зэрэг нь тэдний хэрэгцээнд нийцсэн, уян хатан, үл алагчилсан үйлчилгээ бүрэн үзүүлж чадахгүй байх, голдуу үйлчлүүлэгчийн идэвхтэй оролцоог хязгаарлах, эсвэл соёлын ялгаанд нийцсэн боловсролын үйлчилгээг багасгахад хүргэж, үл алагчлах стратегийг хэрэгжүүлэх чадавх илт дутагдаж байна.	Соёлын ялгаатай бүлэг бүрийн хүмүүс ижил соёл ба дадал хэвшилтэй байдаг гэсэн соёлын харалган төсөөлөл нь түгээмэл байгаа учраас сургууль нь үүсэл гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн давхарга зэргийн ялгаанаас үл хамааран бүх үйлчлүүлэгчдэд боловсролын "сайн" үйлчилгээг хүргэж, ялгаварлан гадуурхахын эсрэг сурталчилгаа явуулах, холбогдох бодлого, хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй гэж боддог.	Сургуулийн үйлчилгээнд нийгэм соёлын хүчин зүйлс хүчтэй нөлөөлдгийг ухаарч, тэдгээрийг цаашид зайлшгүй тооцох нь зүйтэйг мэддэг болсноор соёлын ялгаатай хүн амд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр судалгаа эхлүүлэх, зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах, захиргааны ба мэргэжлийн байгууллагууд, зөвлөх багуудас дэмжлэг тусалцаа авах замаар нийгэм-соёл, зан үйлийн хүрээний цогц чадамжуудаа нэмэгдүүлж эхэлсэн.	Үйлчилгээндээ үл алагчлах стратегийг нэвтрүүлэхийн ач холбогдлыг ойлгож, өөрсдийн цогц чадамжуудаа хөгжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч, энэ чиглэлээр сургуулийн өөрийн үнэлгээ хийх, стратеги төлөвлөгөө боловсруулахдаа оролцооны ил тод зарчмыг баримталж, хамт олон тасралтгүй суралцахдаа хүчин чармайлт гаргадаг, соёлын өвөрмөц онцлогт тохирсон үйлчилгээндээ байнгын үнэлгээ ба сайжруулалт хийдэг болсон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хнх.4.10. Танай сургууль хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоондоо оролцогч талуудын хамтын ажиллагаанд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлийг шийдвэрлэх, эрх ашгийн нөлөөллийг бууруулах шалгуур, индикаторуудын хэрэглээ аль түвшинд байна вэ?				
Хувийн сонирхол буюу эрх ашиг гэж юу болох, тэдгээрт ямар хүчин зүйлс нөлөөлдөг, түүнийг хэрхэн бууруулдаг, үнэлэхдээ ямар индикаторууд хэрэглэдэг талаар сайн мэдэхгүй байна.	Түншлэгчдийн сонирхлын зөрчилд нөлөөлдөг хүчин зүйлс нь юу (ашиг орлогын ногдол, хувь хүмүүсийн хандлагын өвөрмөц шинжүүд, үр дүнгийн гинжин хамаарал, үйлдэл хийх үр чадвар) болохыг судалж байна	Эрх ашгийн сонирхолд харгалзан үзэх гол шалгуур болох хувь хүний хандлагын объект ба түүний төрөл (үнэт зүйлийн, сэтгэгдэлийн, гаралтын үр дүнгийн)-үүд болохыг судалж, тэдгээрийг эрх ашгийн нөлөөллийг бууруулах индикаторууд болгон хэрэглэх бэлтгэлээ хангаж байна.	Хамтрагч талуудын хоорондох үүсэж болох бодит, эсвэл болзошгүй зөрчил болон талууд өөрсдийн байгууллагууддаа үнэнч байх үүрэг хүлээсэн тохиолдолд үүсэх ашиг сонирхлын зөрчлийг талуудын хооронд байгуулах гэрээгээр, шаардлагатай бол гэрээнд өөрчлөлт оруулж шийдвэрлэдэг.	Хамтрагч талуудын эрх ашгийг зохих ёсоор тэнцвэржүүлж, зохицуулаагүй, байгууллага ба нийгмийн хооронд үүссэн ашиг, сонирхлын зөрчил гаргахгүй байхад анхаарч, гарсан тохиолдолд хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.3.3. ЕБС-ийн АЖИЛЧИД: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хбс.1.1. Сургуулийн сургалтын болон хичээлийн хөтөлбөрт ТХБ-ыг интеграцчилах арга, хандлага (ТХБ-ын цогц чадамж төлөвшүүлэх нэгж, ТХ/ТХБ-той холбогдох сэдэв, ТХ/ТХБ-ын асуудал нь сурагчийн шийдэх асуудал байх г.м.)-ыг хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт бүрдсэн үү?				
.....-ыг хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт бүрдээгүй, сургуулийн ажилтан ямар оролцоотойг мэдэхгүй-ыг хэрэгжүүлэхэд сургуулийн ажилтан ямар оролцоотой байх талаар танилцаж байна-ыг хэрэгжүүлэхэд сургуулийн ажилтан ямар оролцоотой байх талаар хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлэхэд сургуулийн ажилтны оролцоог хангадаг-ыг хэрэгжүүлэхэд сургуулийн ажилтны оролцоог бүрэн хангадаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хбс.1.2. Сургуулийн сургалтын болон хичээлийн хөтөлбөр*-ийг төлөвлөх хэрэгжүүлэхэд хүний эрхэд суурилсан байх зарчим (нэг талаас сурагчийн эрхийг хүндэтгэсэн сургалт, үнэлгээгээр багш бүр, нөгөө талаас хүний эрхийг хангахын төлөөх сургуулийн үйл ажиллагаа соёлоор хүний эрхийн боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэх)-ыг биелүүлдэг үү?				
* -Үндэсний хөтөлбөрийн дагуу нийгмийн ухаан, эрх зүйн боловсролын зэрэг зохих хичээлээр хүний эрхийн тухай заахаас гадна				
.....-ыг биелүүлэх талаар нэгдсэн ойлголтгүй, сургуулийн ажилтан ямар оролцоотойг мэдэхгүй-ыг хэрхэн биелүүлэх талаар болон сургуулийн ажилтан ямар оролцоотой байх талаар танилцаж байна-ыг биелүүлэхэд сургуулийн ажилтан ямар оролцоотой байх талаар хийнгээ суралцаж байна-ыг биелүүлэхэд сургуулийн ажилтны оролцоог хангадаг-ыг биелүүлэхэд сургуулийн ажилтны оролцоог бүрэн хангадаг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хбс.1.3. Сургуулийн хэмжээнд жендэрийн мэдрэмжтэй сургалтын болон хичээлийн хөтөлбөр төлөвлөж хэрэгжүүлдэг байдал ямар түвшинд байдаг вэ?				
..... ямар түвшинд ямар байгааг, мөн сургуулийн ажилтан ямар оролцоотойг мэдэхгүй-ын хувьд нэгдсэн ойлголттой болох эхлэл тавигдсан, сургуулийн ажилтан, ажилчдын оролцоог бүрэн тодорхойлоогүй-ын хувьд нэгдсэн ойлголттой, ажилтан, ажилчид үйл ажиллагаагаа уялдуулахад хийнгээ суралцаж байгаа-ыг биелүүлэхэд сургуул.....-ын хувьд нэгдсэн ойлголттой, ажилтан, ажилчид үйл ажиллагаагаа уялдуулсан-ын хувьд нэгдсэн ойлголттой, ажилтан, ажилчид үйл ажиллагаагаа мэргэшсэн түвшинд уялдуулсан
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
а.хбс.1.4. Дэлхийн иргэний боловсрол (ардчилсан байдлаар үйлдэх, нийгмийн хариуцлагатай үйлдэх, бүтээлчээр сэтгэх, бусадтай үр дүнтэй, бүтээлчээр харилцах)-ыг эзэмшүүлэх сургуулийн нэгдсэн бодлого, зарчим хэрэгжүүлдэг үү?				
.....-гүй, сургуулийн ажилтан ямар оролцоотойг мэдэхгүй-ыг хэрэгжүүлэхэд сургуулийн ажилтан ямар оролцоотой байх талаар танилцаж байна-ыг хэрэгжүүлэхэд сургуулийн ажилтан ямар оролцоотой байх талаар хийнгээ суралцаж байна-ыг хэрэгжүүлэхэд сургуулийн ажилтны оролцоог хангадаг-ыг хэрэгжүүлэхэд сургуулийн ажилтны оролцоог бүрэн хангадаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



1.3.3. ЕБС–ийн АЖИЛЧИД: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ ай

АГУУЛГЫН ХҮРЭЭ 4. СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				
Бойжилтын түвшин				
1	2	3	4	5
а.хбс.4.1. ТХ/ТХБ нь сургуулийн өдөр тутмын амьдралын зайлшгүй хэсэг болон төлөвшсөн үү?				
..... хэрхэн болдог тухай нэгдсэн ойлголт байхгүй, сургуулийн ажилчдын үүрэг оролцоо тодорхойгүй болгоход сургуулийн ажилчдын үүрэг, оролцоотой танилцаж байна болгоход сургуулийн ажилчдын үүрэг, оролцоог хэрэгжүүлэхэд хийнгээ суралцаж байна болгоход сургуулийн ажилчдын үүрэг, оролцоог хэрэгжүүлдэг болгоход сургуулийн ажилчдын үүрэг, оролцоог бүрэн дүүрэн хэрэгжүүлдэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
